



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	2
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	6
1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага	6
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	6
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	7
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	11
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	11
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	13
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	13
2.1. Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд	14
2.2. Холбогдох субъектээс мэдээлэл цуглуулах хүрээнд	14
2.3. Биечлэн судалгаа, хэлэлцүүлэг зохион байгуулах хүрээнд	14
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	15
3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	15
3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	32
3.3. “Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:.....	48
3.4. Гадаад улс орнуудын тусгай хамгаалалттай газар нутгийн зохицуулалтын харьцуулсан шинжилгээ	54
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	57
4.1. ДҮГНЭЛТ	57
4.2. ЗӨВЛӨМЖ.....	59
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	68

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, хэсэг, заалт .	8
Хүснэгт 2. Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, хэсэг, заалт	9
Хүснэгт. 3. Бусад үр дагавар шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, хэсэг, заалт	10
Хүснэгт 4.ТХГНтХ-аар хэм хэмжээний акт батлах эрхийг олгосон хэсэг, заалт, батлах субъект	18
Хүснэгт 5. ТХГНтХ-д заасны дагуу батлагдсан захиргааны хэм хэмжээний актын жагсаалт....	20
Хүснэгт 6. Тусгай хамгаалалттай газар нутагт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил	26
Хүснэгт 7. ТХГНХЗ-дад төвлөрсөн орлого, сая төгрөг.....	37
Хүснэгт 8. Байгаль хамгаалагчид ногдох талбайн хэмжээ	43
Хүснэгт 9. ТХГН-д газар ашиглалтын нөхцөл байдал	47
Хүснэгт 10. Харьцуулсан хүснэгт.....	56

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Хамгаалалтын захиргаадын санхүүжилт.....	36
График 2. Нэвтрэх хураамжийн орлого, тэрбум төгрөг.....	38
График 3. Тусгай хамгаалалттай газарт газар ашиглаж буй аж ахуйн нэгжийн тоо.....	47

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	16
Зураг 2. Менежментийн төлөвлөлт болон санхүүжилт	28
Зураг 3. УТХГ-ын хамгаалалтын захиргааны төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он.....	29
Зураг 4. Өгөгдөл байгаа хэдий ч шийдвэр гаргалтад ашиглахгүй байна	31
Зураг 5. Улсын болоод орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ	34
Зураг 6. Богдхан уулын дархан цаазат газрын дотоод бүсэд орсон өөрчлөлт	39
Зураг 7. Богдхан уулын дархан цаазат газрын дотоод бүсчлэл	41

ХАВСАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны хүний нөөцийн судалгаа.....	71
Хавсралт 2. УТХГ-ын хамгаалалтын захиргааны төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он	75
Хавсралт 3. Судалгааны хүрээнд цуглуулсан мэдээлэл	78
Хавсралт 4. ТХГН-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон хүчингүй болсон эрх зүйн актуудын жагсаалт	85
Хавсралт 5. Баруун бүсийн уулзалтын тэмдэглэл.....	97
Хавсралт 6. Хойд бүсийн уулзалтын тэмдэглэл.....	103

ХУРААНГУЙ

Тусгай хамгаалалттай газар
нутгийн тухай хуулийн
хэрэгжилтийн үнэлгээ

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль нь Монгол Улсын байгаль хамгаалалтын эрх зүйн суурь орчныг бүрдүүлсэн боловч хэрэгжилтийн түвшинд институцийн уялдаа сул, эрх зүйн зохицуулалтын зааг тодорхой бус, менежмент болон санхүүжилт, хяналтын механизм хангалтгүй байгаагаас хамгаалалтын бодлогын үр нөлөө хязгаарлагдмал байна. Хамгаалалтын бодлого нь хамрах хүрээг нэмэгдүүлэхэд төвлөрсөн боловч чанарын менежмент, үр дүнд суурилсан хэрэгжилтийн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна.

Гол дүгнэлт. Хуулийн зорилт нь орчин үеийн байгаль орчны бодлоготой бүрэн нийцээгүй, хэрэгжилтийн үр дүнг хэмжих шалгуур дутмаг байна. Захиргааны хэм хэмжээний актуудын хэрэгжилт жигд бус, зарим зохицуулалт батлагдаагүй, хүчингүй болсон, эсхүл хуульд нийцээгүй хэлбэрээр мөрдөгдөж байгаа нь эрх зүйн хийдэл, зөрчил үүсгэж байна.

Засаглалын түвшинд төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрхийн хуваарилалт тодорхой бус, давхардсан шинжтэй байгаагаас шийдвэр гаргалтын нэгдмэл байдал алдагдаж, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байна.

Менежментийн төлөвлөлт нь санхүүжилт, зөвшөөрөл, хяналтын шийдвэртэй уялдахгүй, хэлбэрийн төдий шинж давамгайлж байна. Газар ашиглалт, зөвшөөрөл олголт нь дотоод бүсчлэл, нөөцийн даацтай бүрэн уялдахгүй байгаа нь хамгаалалт-ашиглалтын тэнцвэр алдагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хяналт, мэдээллийн тогтолцоо салангид, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт бүрдээгүй байгаа нь хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байна.

Бодлогын гол асуудал. Одоогийн тогтолцоо нь хууль, тогтоомжийн зохицуулалт болон хэрэгжилт хоорондын уялдааг бүрэн хангаж чадахгүй байгаагаас хамгаалалтын бодлогын хэрэгжилт нэгдсэн тогтолцоонд суурилаагүй, салангид шинжтэй байна, үр дүнд чиглэсэн менежментийн тогтолцоо бүрдээгүй байна.

Зөвлөмж. Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд дараах чиглэлээр цогц шинэчлэл хийх шаардлагатай. Үүнд:

❖ Хуулийн зорилтыг экосистемд суурилсан менежмент, нөөцийн даац, уур амьсгалын өөрчлөлт зэрэг орчин үеийн бодлоготой уялдуулан шинэчилж, хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;

❖ Хууль болон захиргааны хэм хэмжээний актын зохицуулалтыг цэгцэлж, батлагдаагүй, хуучирсан, нийцээгүй зохицуулалтыг шинэчлэх;

❖ Төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрхийн хуваарилалтыг тодорхой болгож, институцийн уялдаа, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх;

❖ Менежментийн төлөвлөлтийг санхүүжилт, зөвшөөрөл, гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулж, үр дүнд суурилсан менежментийн тогтолцоонд шилжүүлэх;

❖ Газар ашиглалт, зөвшөөрөл олголтыг нөөцийн даац, дотоод бүсчлэлд суурилсан ил тод, нэгдсэн шалгуур бүхий тогтолцоонд шинэчлэх;

❖ Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, шийдвэр гаргалтыг өгөгдөлд суурилсан тогтолцоонд шилжүүлэх;

❖ Хяналт, хариуцлага, албадан хэрэгжилтийн механизмыг бэхжүүлж, хуулийн хэрэгжилтийн бодит үр нөлөөг хангах.

Дүгнэлт. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах нь зөвхөн зарим зохицуулалтын агуулгад хэсэгчлэн нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжгүй бөгөөд институцийн уялдаа, менежмент, санхүүжилт, мэдээллийн тогтолцоог цогцоор нь шинэчлэх шаардлагатай бодлогын асуудал юм. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

---o0o---

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ Үүнд:

- ✓ Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- ✓ Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- ✓ Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- ✓ Харьцуулах хэлбэрийг сонгох;
- ✓ Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
- ✓ Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурал Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг 1994 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 1995 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд батлагдсанаас хойш нийт 17¹ удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Хууль тогтоомжийн тухай хууль²-ийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт "... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ" гэж заасан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"³-ийн 3.4.1.1-д "Байгалийн унаган төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулна." гэж тусгажээ.

Энэхүү үндэслэл, шаардлагын хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу энэхүү үнэлгээг гүйцэтгэлээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ нь уг хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, бодит байдалд дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, зардлыг харгалзан үзэх нь чухал бөгөөд хуулийг бүхэлд нь хамруулан үнэлэх нь өндөр зардал, хугацаа шаарддаг тул оновчтой сонголт хийх шаардлагатай байдаг. Иймд тус үнэлгээг хийхдээ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөнд

1 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759661596171&showType=1>

2 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

3 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311>

хамгийн ихээр нөлөөлж буй, мөн практикт асуудал үүсгэж буй гол зохицуулалтуудыг сонгон авч судалгаанд хамруулсан болно.

Тухайлбал, дараах үндсэн чиглэлүүдийг үнэлгээний хүрээнд авч үзэв. Үүнд:

- хуулийн зорилт;
- захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт;
- төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглал;
- тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн тогтолцоо;
- менежментийн төлөвлөлт;
- нутгийн оролцооны зохицуулалт;
- санхүүжилтийн тогтолцоо;
- дотоод бүсчлэл, хамгаалалтын дэглэм;
- газар ашиглалт, зөвшөөрлийн зохицуулалт;
- хяналт, хариуцлагын тогтолцоо;
- хууль хоорондын уялдаа зэрэг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт шууд нөлөөлөх асуудлуудыг хамруулан судалж, үнэлгээ хийхээр тогтов.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, үнэлгээний хүрээ, онцлогт нийцүүлэн дараах шалгуур үзүүлэлтүүдийг сонгосон болно. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;
3. Бусад үр дагавар.

Эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн сонгосон зүйл, хэсэг, заалтуудын хэрэгжилтийг системтэйгээр үнэлж, эрх зүйн зохицуулалтын үр нөлөө, тулгамдсан асуудал, цаашид сайжруулах шаардлагыг тодорхойлсон болно.

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлтээр тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоохыг зорьдог. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан.

Энэ хүрээнд тус хуулийн зорилт, нийтлэг зохицуулалтын үзэл баримтлал нь зорилгодоо хүрсэн эсэх, хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль дахь төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглалтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэхийг судлан үзнэ.

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, хэсэг, заалт

№	Сонгосон зүйл, хэсэг, заалт	Зүйл, хэсэг, заалтын агуулга
1.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 1 дүгээр зүйл.	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах,танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн5.3 дахь хэсэг, 6 ¹ .1, 6 ¹ .2, 6 ¹ .4, 6 ¹ .5 дахь хэсэг, 25.2 дахь хэсэг, 26.5, 26.6 дахь хэсэг	5.3. Улсын хил хамгаалах байгууллага нь зохих хууль тогтоомжийн дагуу улсын хилийн болон хил орчмын дэглэмд нийцүүлэн улсын хил дээрх болон улсын хил орчмын тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх журмыг Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална. 6¹.1. Тусгай хамгаалалттай газар нутаг нь тусгай хамгаалалттай газрын менежментийн зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилт, үр дүнгийн шалгуурыг тодорхойлсон менежментийн төлөвлөгөөтэй байна. Менежментийн төлөвлөгөөг 10 жилийн хугацаатайгаар тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 6¹.2. Тусгай хамгаалалттай газар нутагт ашиглаж болох газар нутгийн хэсгийг тодорхойлж, төлөвлөсөн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны саналыг авсны үндсэн дээр батална. 6¹.5. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг менежментийн төлөвлөгөөтэй байж болох бөгөөд төлөвлөгөөг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална. 25.2. Засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, эдгээр газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой ангилалд хамааруулах, дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагийг батлах, өөрчлөх. 26.5. энэ хуульд заасан хамгаалалтын дэглэмийн хүрээнд тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын горимыг батлах; 26.6. байгалийн нөөц газрын болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох.
3.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27.2, 27.3, 27.8, 27.9, 27.14, 27.18 дахь хэсэг, 36.4 дэх хэсэг	27.2. тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа, шинжилгээний ажлын журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, зөвшөөрөл олгох, холбогдох тайлан, мэдээллийг авч нэгдсэн санд оруулах; 27.3. биологийн төрөл зүйлд судалгаа, тооллого явуулах, бүртгэл хөтлөх аргачлал, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, зөвшөөрөгдсөн бүсээс ажиглалтын зориулалтаар дээж, сорьц авах, хэмжилт хийх, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор ан амьтныг агнах, барих журам тогтоох;

		27.8.тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүс дэх суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан батлах; 27.14.газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах журмыг батлах; 17/тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах аргачлал, үр ашигт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам батлах; 27.18.энэ хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5, 7, 8-д заасан төлбөр, хураамжийн хэмжээг тогтоох. 36.4.Сонгон шалгаруулалтад оролцогчид болон ирүүлэх төсөлд тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлсон журмыг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
4.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28.4 дэх хэсэг	28 дугаар зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх 28.4.орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг батлах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг орон нутгийн төсөвт тусгах.

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Иймд тус судалгааны хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд дараах зүйл, заалтуудыг сонгон практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэллээ.

Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, хэсэг, заалт

№	Сонгосон зүйл, хэсэг, заалт	Зүйл, хэсэг, заалтын агуулга
1.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйл.	3 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал
2.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 дугаар зүйл	6 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг санхүүжүүлэх
3.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 7-24 дүгээр зүйл	Дархан цаазат газар, түүний хамгаалалтын дэглэм Байгалийн цогцолборт газар, түүний хамгаалалтын дэглэм Байгалийн нөөц газар, түүний хамгаалалтын дэглэм Дурсгалт газар, түүний хамгаалалтын дэглэм
4.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 30, 31, 32 дахь зүйл	30 дугаар зүйл. Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа 31 дүгээр зүйл. Байгаль хамгаалагчийн бүрэн эрх 32 дугаар зүйл. Байгаль хамгаалагч зэвсэг хэрэглэх

5.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 33-35 дугаар зүйл.	
----	---	--

1.3.3. “Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Судалгааны хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дараах зохицуулалтуудыг үнэлсэн болно.

Хүснэгт 3. Бусад үр дагавар шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, хэсэг, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Холбогдох хэсэгт хамаарах асуудал
1.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 7-12 дахь зүйл, 13-18 дахь зүйл, 19-24 дахь зүйл	7 дугаар зүйл. Дархан цаазат газар 8 дугаар зүйл. Дархан цаазат газрын бүс 9 дүгээр зүйл. Онгон бүсийн дэглэм 10 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн дэглэм 11 дүгээр зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм 12 дугаар зүйл. Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагаа 13 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газар 14 дүгээр зүйл. Байгалийн цогцолборт газрын бүс 15 дугаар зүйл. Онцгой бүсийн дэглэм 16 дугаар зүйл. Аялал, жуулчлалын бүсийн дэглэм 17 дугаар зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм 18 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газарт хориглох үйл ажиллагаа 19 дүгээр зүйл. Байгалийн нөөц газар 20 дугаар зүйл. Байгалийн нөөц газрын төрөл 21 дүгээр зүйл. Байгалийн нөөц газрын дэглэм 22 дугаар зүйл. Дурсгалт газар 23 дугаар зүйл. Дурсгалт газрын төрөл 24 дүгээр зүйл. Дурсгалт газрын дэглэм
2.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 36, 36 ¹ , 36 ² дахь зүйл	36 ¹ дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалт 36 ² дугаар зүйл. Сонгон шалгаруулах үйл ажиллагааны дараалал
3.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 38, 39, 40, 41 дэх зүйл	38 дугаар зүйл. Газар ашиглагчийн эрх, үүрэг 39 дүгээр зүйл. Газар ашиглагчид хориглох үйл ажиллагаа 40 дүгээр зүйл. Газар ашиглах зөвшөөрлийн эрх дуусгавар болох, хүчингүй болох, газрыг чөлөөлөх 41 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах байгууллага, түүний үүрэг
3.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 42.1, 42.2 дахь хэсэг, 43.1 дэх хэсэг	42.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хамгаалалтын захиргаа, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина. 42.2. Байгаль орчны хяналтын улсын байцаагчид тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд

		хяналт тавьж, зөрчигчдөд эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага хүлээлгэнэ. 43.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
4.	Бусад хууль	Бусад хууль, тогтоомжтой харилцан уялдаа, нийцэлтэй байгаа эсэх талаар асуудал

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлох, үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгоно.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Аргачлалд заасны дагуу тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлэх, эсхүл асуулт тавих, хэрэгжилтийн үр нөлөө, үр дагавар нь гарч ирэх шалгуур үзүүлэлтийг сонгон, таамаглал дэвшүүлэх, товч, тодорхой томьёолох зорилтыг баримталсан болно.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилттой холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх. Хуулийн зорилт нь байгаль хамгаалалтын бодлого, улсын болон салбарын урт хугацааны хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцэж байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглалтай холбоотой зохицуулалт зорилгодоо нийцэж байгаа эсэх. Бүрэн эрхийн хуваарилалт нь институцийн уялдаа, хариуцлагын тодорхой байдлыг хангаж байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан менежментийн төлөвлөлт, санхүүжилттэй холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх. Эдгээр зохицуулалт нь хамгаалалтын үйл ажиллагааны тогтвортой байдал, үр нөлөөг хангах боломжийг бүрдүүлж байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан мэдээлэл, бүртгэл, шийдвэр гаргалтын уялдаатай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх. Мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтын эрх зүйн орчин бүрдсэн эсэх.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6¹ дүгээр зүйлд заасан менежментийн төлөвлөлттэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Менежментийн төлөвлөгөө нь бодит хэрэгжилт, санхүүжилт, шийдвэр гаргалттай уялдаж байгаа эсэх, хэрэгжилтэд хүндрэл, бэрхшээл үүсэж байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг санхүүжүүлэх зохицуулалтын хэрэгжилт, практикт ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 7–25 дугаар зүйлд заасан хамгаалалтын дэглэм, дотоод бүсчлэл практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Бүсчлэл нь бодит шийдвэр гаргалтад ашиглагдаж байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30–32 дугаар зүйлд заасан хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хүний нөөц, чадавх, гүйцэтгэлийн стандарт хангалттай байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 33–35 дугаар зүйлд заасан зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Шийдвэр гаргалтын шалгуур, ил тод байдал, дотоод бүсчлэлтэй уялдаа хангагдаж байгаа эсэх.

Бусад үр дагавар шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36¹, 36², 37, 38 дугаар зүйлд заасан газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалт, гэрээ, газар ашиглагчийн эрх, үүргийн зохицуулалтын хэрэгжилт практикт хэрхэн хангагдаж байгаа, ямар эрх зүйн хийдэл, хүндрэл, давхардал үүсэж байна вэ?.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 39 дүгээр зүйл. Газар ашиглагчид хориглох үйл ажиллагаа, газар ашиглагчид хориглох үйл ажиллагааны зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, хэрэгжилтийн явцад ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 40 дүгээр зүйл. Газар ашиглах зөвшөөрлийн эрх дуусгавар болох, хүчингүй болох, газрыг чөлөөлөх, газар ашиглах зөвшөөрлийн эрх дуусгавар болох, хүчингүй болох, газрыг чөлөөлөх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, хэрэгжилтийн явцад ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 43 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн уялдаа, нийцэл нь ямар үр дагавар үүсгэж байна вэ? Эрх зүйн давхардал, зөрчил, хийдэл нь шийдвэр гаргалт болон хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байгаа эсэх.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд тоон болон чанарын мэдээлэл ашиглаж, дүн шинжилгээ хийх шатанд дараах аргуудыг хэрэглэсэн болно.

а)Байгаа мэдээллийг цуглуулах

Тухайн хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглана;

б)Холбогдох субъектээс судалгаа авах

Тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж байгаа болон чиг үүргээрээ түүнтэй холбоотой төрийн байгууллага, албан хаагч, хуулийн хэрэгжилтэд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдээс мэдээлэл цуглуулах, мөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагаас албан ёсоор тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулж авна.

в)Биечлэн судалгаа хийх

Хууль тогтоомж хэрэгжиж байгаа орчин нөхцөлд биечлэн очиж, ажиглалт хийх, эсхүл дээр дурдсаны дагуу анкетын болон ярилцлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулна.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн сонгосон зүйл, хэсэг, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилт болон бусад үр

дагаврыг илрүүлэх зорилгоор баримт бичгийн судалгаа, харьцуулсан шинжилгээ, оролцогч талуудаас мэдээлэл авах, бүсчилсэн хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг арга зүйг төлөвлөж, хэрэгцээт мэдээллийг системтэйгээр цуглуулж, судалгааны багийн оролцоотой хэрэгжүүлэв.

2.1. Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, журам, дүрэм, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, статистик мэдээ зэрэг хоёрдогч эх сурвалжийг цуглуулж, дүн шинжилгээ хийв.

Мөн ТХГН-ийн менежмент, газар ашиглалт, хамгаалалтын дэглэм, хяналт, санхүүжилт, институцийн зохион байгуулалттай холбоотой өмнөх судалгаа, тайлангуудыг нэгтгэн шинжилж, тухайн зохицуулалтын хэрэгжилтийн түвшнийг үнэлэхэд ашиглав. Судалгаанд ашигласан эх сурвалжийг тайлангийн ном зүйн хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.

2.2. Холбогдох субъектээс мэдээлэл цуглуулах хүрээнд

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтэд оролцогч байгууллагуудаас мэдээлэл цуглуулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанууд, аймаг, нийслэлийн Байгаль орчны газар, холбогдох төрийн байгууллагуудаас хэрэгжилтийн тайлан, мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг авч ашиглав. Мөн газар ашиглалт, зөвшөөрөл олголт, менежментийн төлөвлөлт, хяналт, зөрчил, санхүүжилттэй холбоотой мэдээллийг холбогдох байгууллагуудаас тодруулан авч, харьцуулсан байдлаар шинжилсэн.

2.3. Биечлэн судалгаа, хэлэлцүүлэг зохион байгуулах хүрээнд

Судалгааны хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ТХГН-ийн Бодлого, зохицуулалтын газар, Монголын Байгалийн Өв Сан, “Өнө мөнхийн Монгол” хөтөлбөрийн зохицуулах нэгжийн хамтран зохион байгуулсан тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны хойд⁴ болон баруун⁵ бүсийн уулзалт, хэлэлцүүлгийн тэмдэглэлүүдийг (хавсралт 5, хавсралт 6) ашигласан бөгөөд эдгээр нь хуулийн хэрэгжилтийн бодит нөхцөл, тулгамдсан асуудлыг газар дээрээс илэрхийлсэн чухал эх сурвалж болсон болно.

Баруун бүсийн уулзалтад ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, аймаг, сумын байгаль орчны байгууллагууд, орон нутгийн удирдлагын төлөөлөл, газар ашиглагчид, аялал жуулчлалын салбарын төлөөлөл оролцож, газар ашиглалт, зөвшөөрөл олголт, хяналт, дотоод бүсчлэлийн хэрэгжилт, институцийн уялдаа, санхүүжилттэй холбоотой асуудлыг хэлэлцсэн байна.

4 Тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтын Захиргааны хойд бүсийн уулзалт., Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон, Ami resort, 2025 он.

5 Тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтын Захиргааны баруун бүсийн уулзалт., Завхан аймгийн Дөрвөлжин сум, Хомын талын БЦГ, 2025 он

Зүүн бүсийн уулзалт, хэлэлцүүлгээр мөн адил ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, орон нутгийн байгууллагууд, мэргэжлийн байгууллага, иргэдийн төлөөллийг хамруулан менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, хяналтын давхардал, мэдээллийн уялдаа, дотоод бүсчлэлийн практик хэрэглээ, газар ашиглалтын зохицуулалтын асуудлуудыг тодруулжээ.

Эдгээр хэлэлцүүлгийн үр дүнд:

- дотоод бүсчлэл нь шийдвэр гаргалтад хангалттай ашиглагддаггүй,
- газар ашиглалтын зөвшөөрөл, гэрээ нь бүсчлэл, менежментийн төлөвлөгөөтэй уялдахгүй,
- хяналтын чиг үүрэг давхардсан,
- мэдээлэл салангид, нэгдсэн систем дутмаг,
- санхүүжилт нь хамгаалалтын үр дүнтэй уялдахгүй зэрэг нийтлэг асуудлууд бүс нутгийн түвшинд давтагдан илэрч байгааг тогтоосон.

Мөн аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, хамгаалалтын захиргаа, салбарын экспертүүдтэй ганцаарчилсан уулзалт хийж, хууль хэрэгжилтийн институцийн, процессын болон зохицуулалтын шинжтэй асуудлуудыг тодруулан судалсан.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү үе шатанд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ цуглуулсан тоон болон чанарын мэдээллийг нэгтгэн шинжилж, хууль тогтоомжийн зорилго, хэрэгцээ шаардлага болон бодит хэрэгжилтийн үр дүнтэй харьцуулан энэхүү үнэлгээг боловсруулав. Үнэлгээг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу мэдээллийн хангалттай байдал, хамаарал, бодитой эсэхийг нягтлан, ТХГН-ийн ангилал, хамгаалалтын дэглэм, удирдлагын тогтолцоо, санхүүжилт, орон нутгийн оролцоо, бусад хууль тогтоомжтой уялдаа зэрэг асуудлыг хамруулан дүн шинжилгээ хийсэн. Цуглуулсан мэдээлэлд тоон болон чанарын үнэлэлт өгч, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн зүйл тус бүрийн хэрэгжилтийн үр дагаврыг дараах байдлаар үнэлэв.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилттой холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх, мөн тус хуулийн зорилт урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцэж байгаа эсэх.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт байгалийн баялаг, түүний дотор газар нутаг, экосистем нь төрийн хамгаалалтад байх бөгөөд нийтийн өмч болохыг тодорхойлсон. Энэ суурь зарчмын хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, зохистой ашиглахтай холбоотой харилцааг бие даасан хуулиар зохицуулах үндэслэл бүрдсэн.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалах, судлах, зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахыг хуулийн зорилт болгон тодорхойлсон байна.

Хуулийн зорилтын хэрэгжилтийг үнэлэхдээ хамгаалалтын бодлогын үр дүн болон менежментийн бодит хэрэгжилтийг илэрхийлэх дараах үндсэн үзүүлэлтүүдийг авч үзэв.


(а) Хамгаалалтын хамрах хүрээ болон экосистемийн төлөв байдал

Сүүлийн жилүүдэд тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээ тогтвортой өсөж, улсын нийт нутаг дэвсгэрийн 21 хувийг хамарсан нь хамгаалалтын бодлогын тоо хэмжээгээр илэрхийлэх зорилт тодорхой түвшинд хэрэгжсэнийг харуулж байна (Зураг 1).

Гэвч хамгаалалтын хамрах хүрээ нэмэгдсэнтэй зэрэгцэн экосистемийн чанарын үзүүлэлтүүд, тухайлбал:

- экосистемийн доройтол;
- биологийн олон янз байдлын өөрчлөлт;
- хүний үйл ажиллагааны дарамт зэргийг нэгдсэн байдлаар үнэлэх, хянах тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна.

Зураг. 1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг



Эх сурвалж: БОУАӨЯамны тоон мэдээлэл, 2025 он

Иймд хамгаалалтын бодлого нь өнгөрсөн 31 жилийн хугацаанд “хамрах хүрээ” төвтэй хэрэгжсэн боловч “чанарын менежмент” хангалттай төлөвшиж хэлбэржээгүй нь харагдаж байна.

Шигтгээ 1.

“...хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал, ашиглалтын үйл ажиллагаа нэмэгдэж байгаа боловч хамгаалалтын зорилго, даацын үнэлгээтэй уялдахгүй байна. Байгаль хамгаалах зорилго бодит шийдвэрт тусахгүй байна...”

Бүсийн хэлэлцүүлгийн ярилцлагын тэмдэглэлийн хэсгээс

б) Хүний үйл ажиллагааны дарамт ба газар ашиглалтын нөлөөлөл

Судалгааны хүрээнд цуглуулсан мэдээлэл болон бүсийн хэлэлцүүлгийн үр дүнгээс харахад аялал жуулчлал, дэд бүтэц, газар ашиглалтын үйл ажиллагаа тодорхой бүс нутагт төвлөрч, хамгаалалтын дэглэмийн хэрэгжилт жигд бус байна.

Ялангуяа дотоод бүсчлэлийн зохицуулалт бодит шийдвэр гаргалтад ашиглагдахгүй, бүсчлэл нь зөвшөөрөл, ашиглалтын шалгуур болж үйлчлэхгүй байгаа нь хуулийн зорилтод тусгагдсан “зохистой ашиглалт” нь практикт бүрэн хангагдахгүй байх нөхцлийг бүрдүүлжээ.

в) Хяналт, хамгаалалтын үр нөлөө

Хяналтын тогтолцоо нь олон субъектэд хуваагдсан, мэдээллийн уялдаа сул, урьдчилан сэргийлэхээс илүү реактив шинж давамгайл байгаа нь хамгаалалтын бодит үр нөлөөг бууруулж, зөрчил давтагдах, хамгаалалтын дэглэм алдагдах, хууль хэрэгжилтийн нөлөө сулрах нөхцөл бүрдэж байна.

Иймд хяналтын тогтолцоо нь хуулийн зорилтод нийцсэн үр дүнтэй хамгаалалтын механизм болж чадаагүй байна.

г) Менежментийн үр нөлөө

Менежментийн төлөвлөгөө боловсруулагдаж байгаа боловч газар ашиглалтын шийдвэртэй уялдахгүй, санхүүжилттэй холбогдохгүй, хэрэгжилт формаль шинжтэй байгаа нь хамгаалалтын зорилтыг бодит менежментийн үр дүнд хөрвүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Түүнчлэн хуулийн зорилт нь орчин үеийн хөгжлийн бодлого болох ногоон хөгжил, экосистемийн үйлчилгээ, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тогтвортой аялал жуулчлал, орон нутгийн оролцоонд суурилсан менежмент зэрэг чиг хандлагатай уялдсан байдлаар нарийвчлан зохицуулаагүй байх тул хэрэгжилтийн үр нөлөөг системийн түвшинд хязгаарлаж байна.

Өөрөөр хэлбэл, хуулийн зорилт нь менежментийн хэрэгсэл (төлөвлөлт, санхүүжилт, хяналт)-тэй бүрэн холбогдож чадахгүй буюу Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн зорилт нь хамгаалалтын хамрах хүрээг өргөжүүлэх чиглэлд тодорхой хэмжээнд хэрэгжсэн боловч хамгаалалтын чанар, менежментийн үр нөлөө, хяналтын тогтолцооны хувьд зорилгодоо бүрэн хүрсэн гэж үзэхэд хангалтгүй байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх

Хуулиар нарийвчлан зохицуулах боломжгүй харилцааг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулах эрхийг олгосон нь хуулийн хэрэгжилтийг хангах суурь механизм юм. Энэ хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд хамгаалалтын дэглэм, газар ашиглалт, менежментийн төлөвлөлт, сонгон шалгаруулалт, хяналт, үнэлгээ зэрэг харилцааг журмаар нарийвчлан зохицуулахаар Засгийн газар болон эрх бүхий этгээдэд эрх олгосон байна.

Гэвч уг эрх олголтын хэрэгжилтийг үнэлэхэд захиргааны хэм хэмжээний актын бүрдэлт, эрх зүйн чанар, хэрэгжилт, зохицуулалтын түвшний хувьд системийн шинжтэй доголдлууд илэрч байна.

а) Журмын бүрдэлт, батлагдсан байдал

Судалгааны дүнд хуулиар журам батлахаар заасан зохицуулалтуудын хэрэгжилтийг нэгтгэн үзэхэд тодорхой хэсэг нь хүчин төгөлдөр батлагдан мөрдөгдөж байгаа боловч, зарим журам хүчингүй болсон, зарим нь огт батлагдаагүй байдал ажиглагдаж байна.

Үүний улмаас газар ашиглалтын шалгуур, сонгон шалгаруулалтын шаардлага, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, хяналтын нэгдсэн аргачлал зэрэг гол харилцаанд эрх зүйн хийдэл үүссэн байна. Энэ нь хуулийн хэрэгжилтийг хангах механизм бүрэн ажиллахгүй байгааг илтгэнэ.

Хүснэгт 4. ТХГНТХ-аар хэм хэмжээний акт батлах эрхийг олгосон хэсэг, заалт, батлах субъект

Холбогдох төрийн байгууллага	Эрх олгосон байдал, өөрчлөлт
Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн /2/	6 ¹ дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент - 1. Тусгай хамгаалалттай газар нутаг нь тусгай хамгаалалттай газрын менежментийн зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилт, үр дүнгийн шалгуурыг тодорхойлсон менежментийн төлөвлөгөөтэй байна. Менежментийн төлөвлөгөөг 10 жилийн хугацаатайгаар тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. - 4. Тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр ашиг, үр нөлөөг үнэлэх журмыг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд уг журмын дагуу менежментийн төлөвлөгөөг хоёр жил тутамд үнэлж, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулна.
Төрийн захиргааны төв байгууллага /13/	27 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх - 2/ тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа, шинжилгээний ажлын журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, зөвшөөрөл олгох, холбогдох тайлан, мэдээллийг авч нэгдсэн санд оруулах.

	- 3/ биологийн төрөл зүйлд судалгаа, тооллого явуулах, бүртгэл хөтлөх аргачлал, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, зөвшөөрөгдсөн бүсээс ажиглалтын зориулалтаар дээж, сорьц авах, хэмжилт хийх, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор ан амьтныг агнах, барих журам тогтоох; - 4/ ойг арчлах, ойжуулах, хөрс, ургамлыг нөхөн сэргээх журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, нөхөн сэргээх газрын хэмжээ, уг ажлыг гүйцэтгэх арга, технологийг тогтоох; - 5/ хортон шавьж, мэрэгчид, түймрээс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх журам, аргачлал тогтоох, гамшиг болон аюулаас тусгай хамгаалалттай газар нутагт учирсан хор уршгийг багасгах арга хэмжээ авах; - 6/ рашаан, эмчилгээ, сувилгааны зориулалттай бусад эрдэс, байгалийн дагалт баялгийг ашиглах журам, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлын жагсаалт, тэдгээрийг түүж бэлтгэх журмыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтоох; - 7/ аялал, жуулчлалын зам, чиглэл, журам тогтоох; - 8/ тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүс дэх суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан батлах; - 9/ тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журам, уг газарт байлгаж болох малын төрөл, тоог тогтоох; - 14/газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах журмыг батлах - 15/улсын тусгай хамгаалалттай газрын дотоод бүсчлэл тогтоох - 16/улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих; - 17/тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах аргачлал, үр ашигт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам батлах; - 36^{1.4}.Сонгон шалгаруулалтад оролцогчид болон ирүүлэх төсөлд тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлсон журмыг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
Улсын хил хамгаалах байгууллагатай хамтран батлах /1/	- 5 дугаар зүйл. Улсын хилийн болон хил орчмын газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах - 3. Улсын хил хамгаалах байгууллага нь зохих хууль тогтоомжийн дагуу улсын хилийн болон хил орчмын дэглэмд нийцүүлэн улсын хил дээрх болон улсын хил орчмын тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх журмыг Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.
Цагдаагийн төв байгууллагатай зөвшилцөн тогтооно /1/	- 32 дугаар зүйл. Байгаль хамгаалагч зэвсэг хэрэглэх - 1. Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагчийн хэрэглэх зэвсэг, хэрэгслийн төрөл, тэдгээрийг хэрэглэх журмыг төрийн захиргааны төв байгууллага цагдаагийн төв байгууллагатай зөвшилцөн тогтооно
НИЙТ	17 хэм хэмжээний акт байна.

б) Журмын эрх зүйн чанар, нийцэл

Захиргааны ерөнхий хуулийн⁶ 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.” гэж заасан. Энэхүү шалгуурын дагуу дээрх 17 захиргааны хэм хэмжээ тогтоосон акт нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд тус актыг батлах эрх хэмжээ буюу хэн батлахыг тодорхой заасан болон иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн үр дагавар үүсгэсэн, тухайн байгууллагын дотоод зохион байгуулалт, зохицуулалтын шинжийг агуулаагүй байх нийтлэг шинжийг агуулсан байхаас гадна Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байх ёстой.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн⁷ 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1}, 27^{1.2} дахь хэсэгт заасан шалгуур, хориглолт, мөн Засгийн газрын 2025 оны 206 дугаар тогтоолын дагуу хяналт шинжилгээ хийхэд Захиргааны ерөнхий хуульд заасан заавал дагаж мөрдүүлэхээр, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжийг агуулсан 17 захиргааны хэм хэмжээ тогтоосон акт байна.

Батлагдсан зарим журам нь Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээний актын шаардлагыг бүрэн хангаагүй, улсын нэгдсэн санд бүртгэгдээгүй, эсхүл эмхэтгэлд нийтлэгдээгүй атлаа практикт мөрдөгдөж байгаа тохиолдлууд ажиглагдаж байна.

Шигтгээ 2.

“...журмууд байгаа боловч газар дээрээ хэрэгжихдээ ойлгомжгүй, нэг аймагт нэг өөр, нөгөө аймагт өөр байдлаар хэрэгжиж байна. Зарим тохиолдолд ямар журам мөрдөх нь тодорхойгүй байдаг...”

Бүсийн хэлэлцүүлгийн ярилцлагын тэмдэглэлийн хэсгээс

Мөн зарим тохиолдолд хуулиар олгогдоогүй асуудлыг журмаар зохицуулсан, эсхүл огт зохицуулаагүй, хуулийн хүрээнээс давсан зохицуулалт бий болгосон, хүний эрх, ашиг сонирхолд нөлөөлөх шинжтэй зохицуулалтыг тогтоосон байдал илэрч байх бөгөөд зарим журмыг захиргааны хэм хэмжээний актын бүртгэлд бүртгүүлээгүй нь эрх зүйн хүчин төгөлдөр байдалд эргэлзээ үүсгэж, хууль хэрэгжилтийн нэгдмэл байдлыг алдагдуулжээ.

Хүснэгт 5. ТХГНТХ-д заасны дагуу батлагдсан захиргааны хэм хэмжээний актын жагсаалт

Батлах эрх бүхий субъект	Эрх олгосон хэсэг, заалт	Журмын нэр, холбоос
Засгийн газрын гишүүн буюу Байгаль орчны асуудал эрхэлсэн	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 ¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	Байгаль, орчин аялал, жуулчлалын сайдын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/16 тоот тушаалын хавсралтаар “Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүй” батлагдсан.

⁶ Захиргааны ерөнхий хууль 2015 он, Төрийн мэдээлэл эмхэтгэл 2015 оны №28 дугаарт нийтлэгдсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11259>

⁷ Хууль тогтоомжийн тухай хууль 2015 он, Төрийн мэдээлэл эмхэтгэл 2015 оны №25 дугаарт нийтлэгдсэн, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

Засгийн газрын гишүүн		Энэ арга зүйн баримт бичиг нь www.legalinfo.mn эрх зүйн нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдээгүй.
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 ¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдалд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх журам батлагдсан гэх бөгөөд Энэ журам нь www.legalinfo.mn эрх зүйн нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдээгүй.
Төрийн захиргааны төв байгууллага	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа шинжилгээний ажил явуулахад мөрдөх журам Байгаль орчны сайдын 1996 оны 36 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=204360&showType=1 Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 1997 оны 3-р сарын 26-ны өдрийн №968 дугаарт бүртгэсэн.
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Байгаль орчны сайдын 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 209 дугаар тушаалаар “улсын тусгай хамгаалалттай газар нутагт амьтны сүргийн бүтцийг зохицуулах, заазлах, судалгаа шинжилгээний дээж, сорьц авах, хэмжилт хийх, нутагшуулах, халдварт өвчний голомтыг устгах зорилгоор амьтан агнах, барих журам”-ыг баталсан. https://legalinfo.mn/mn/detail/13900 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/453 дугаар тушаалаар хүчингүй болгосон.
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 4 дахь хэсэг	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 12-р сарын 29-ний өдрийн 417 дугаар тушаалын хавсралтаар “Нөхөн сэргээлтийн өнөөгийн байдал, эрх зүйн орчин аргачлал” батлагдсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=205266 БОНХАЖС-ын 2015-А-138 дугаар тушаалаар хүчингүй болсон.
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 5 дахь хэсэг	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 63/67/87 дугаар тушаалын хавсралтаар “Пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг турших, ашиглах журам” батлагдсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=205219 БОАЖС, ХХААХҮС, ЭМС-ын хамтарсан 2018 оны А/319,А-147,А/353 дугаар тушаалаар хүчингүй болсон.
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 6 дахь хэсэг	Байгаль орчны сайдын 2000 оны 21 дүгээр тушаалын хавсралтаар “Тусгай хамгаалалттай газар нутагт рашаан ашиглах журам” батлагдсан боловч хүчин болгосон. https://legalinfo.mn/mn/detail?lawId=204363

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	Байгаль орчны сайдын 2002 оны 6 дугаар сарын 1-ний өдөр 117 дугаар тушаалаар "Тусгай хамгаалалттай газар нутаг /ТХГН/-т аялал жуулчлал явуулах журам"-ыг 1 дүгээр, "ТХГН-д үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлс төлөх журам"-ыг 2 дугаар, ТХГН-т үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлс төлөх тасалбарын загварыг 3 дугаар, ТХГН-т мөрдөх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлсний хэмжээг 4 дүгээр хавсралтын ёсоор баталсан боловч эхний 3 хавсралтын тус тус хүчингүй болгосон. БОАЖС-ын 2023 оны А/71 дүгээр тушаалаар 4-р хавсралтыг хүчингүй болгосон. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Дугаар А-361 дүгээр тушаалын хавсралтаар "Журам батлах тухай /Бурхан Халдун хайрханд аялах болон уламжлалт зан үйлийн ёслол үйлдэх журам/" батлагдсан боловч хүчингүй болгосон. Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Дугаар 171 дүгээр тогтоолын хавсралтаар "Монгол Улсын аялал жуулчлалын гол чиглэл"-ийг 1 дүгээр хавсралт, "Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын чиглэл"-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсан байна. https://legalinfo.mn/mn/detail?lawId=13578 БОАЖСайдын 2018 оны 12 сарын 11-ний өдрийн А/498 тоот тушаалаар "Тусгай хамгаалалттай газар нутагт мөрдөгдөх нэгдсэн өнгө төрх, загварыг батлах тухай" батлагдсан боловч хуулиар ийм эрх олгогдоогүй тул Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдээгүй.
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 8 дахь хэсэг	Төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан батлах харилцааг журамлах асуудлыг хуульчлаагүй тул холбогдох журам батлагдаагүй.
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 9 дахь хэсэг	Холбоотой харилцааг зохицуулсан журам батлагдаагүй буюу нэгдсэн санд бүртгэлгүй. Аймгийн ИТХ-аас холбогдох асуудлыг тухайлан зохицуулсан горим хэлбэрээр батлагдаж, хүчин төгөлдөр үйлчилж байна. https://legalinfo.mn/mn/detail?lawId=210992
Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 14 дэх хэсэг	Байгаль орчны сайдын 2000 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 07 дугаар тушаалаар " Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай" журмыг хавсралтын ёсоор баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=7928 Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2000 оны 1-р сарын 26-ны өдрийн 1531 дугаарт бүртгэсэн.

		/Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тодорхой асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах гэж заасныг үндэслэн тушаал гаргасан/
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 15 дахь хэсэг	Улсын тусгай хамгаалалттай газрын дотоод бүсчлэл тогтоох асуудлыг зохицуулсан эрх зүйг акт батлагдаагүй.
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 16 дахь хэсэг	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/16 дугаар тушаалаар баталсан “Менежментийн төлөвлөлтийн арга зүй”-д зарим асуудлыг зохицуулсан байх боловч процессыг тодорхой болгож, сайжруулах шаардлагатай.
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 17 дахь хэсэг	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/16 дугаар тушаалаар “Менежментийн төлөвлөлтийн арга зүй”-г баталсан боловч Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдээгүй.
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36 ¹ дугаар зүйлийн 4 дэх хэсэг	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/202 дугаар тушаалын хавсралтаар тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалтад оролцогчдоос төсөл хүлээн авах журам”-ыг баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140419530401&showType=1
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн А/219 дугаар тушаалын хавсралтаар “Улсын тусгай хамгаалалттай газар нутагт хяналт, шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулахад ашиглагдах “СМАРТ” програмын гарын авлагын арга зүйг батлах тухай”-ыг баталсан боловч Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдээгүй.
Улсын хил хамгаалах байгууллагатай хамтран батлах	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Батлагдсан эсэх нь тодорхойгүй буюу Эрх зүйн нэгдсэн мэдээллийн сангаас олдоогүй
Цагдаагийн төв байгууллагатай зөвшилцөн тогтооно	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай	Монгол улсын ерөнхий прокурор, хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны хамтарсан а/03 а/04 дүгээр тушаалын хавсралт байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар.

	хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	https://legalinfo.mn/mn/detail?lawId=207568
--	--	---

Хүснэгт 5-д нэгтгэн үзүүлсэн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтын хэрэгжилтийг бүхэлд нь авч үзэхэд нийт 17 захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргах эрхийг хуулиар олгосон боловч Засгийн газрын тогтоолоор батлагдсан/1 акт/, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн 2, хүчин төгөлдөр мөрдөж байгаа 2, Захиргааны ерөнхий хуулийн 59, 60, 61 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцээгүй 5 акт бүртгүүлээгүй, хүчин төгөлдөр бус болгосон мөн 6 акт байна. Харин хуулиар захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх хэмжээг олгосон боловч одоо хүртэл 3 акт батлаагүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангах үндсэн механизмын хувьд бүрэн төлөвшөөгүй, системийн түвшинд олон төрлийн зөрчил, хийдэл дагуулсан ноцтой байдалтай байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар Засгийн газарт тусгайлан эрх олгоогүй боловч Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн ерөнхий зохицуулалтаар баталсан 1 захиргааны акт, Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд 2, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 13, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулга, хил хамгаалах байгууллагатайтай хамтаран 2 захиргааны хэм хэмжээний актыг тус тус батлахаар хуульчилсан бөгөөд эдгээр хэм хэмжээний актын хэрэгжилт нь хуулийн зорилтод сөргөөр нөлөөлж байна.

Түүнчлэн, хүчингүй болсон, батлагдаагүй, бүртгэлгүй нийт 15 захиргааны хэм хэмжээний акт буюу дүрэм, журмаар нарийвчлан зохицуулах ёстой байсан асуудлын хүрээнд эрх зүйн хийдэл буюу зохицуулагдаагүй харилцааг бий болгож байна. Нэгэнт хуульд тодорхой байдлаар тусгаагүй асуудлын хүрээнд журам батлахаар хуульд заасан учир тухайн асуудлыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байдаг.

Иймд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг засаж сайжруулах, боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна. Ийнхүү боловсронгуй болгохдоо захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгохыг онцгойлон анхаарч, хуулиар зохицуулах харилцаа, дүрэм, журмаар зохицуулах харилцаагаа нарийвчлан тодорхойлох нь зүйтэй.

Дээрхээс нэгтгэн дүгнэвэл, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт зорилгодоо бүрэн хүрээгүй байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглалтай холбоотой зохицуулалт зорилгодоо нийцэж байгаа эсэх. Бүрэн эрхийн хуваарилалт нь институцийн уялдаа, хариуцлагын тодорхой байдлыг хангаж байгаа эсэх.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрхийг олон түвшинд хуваарилан зохицуулсан бөгөөд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харьяа агентлаг, хамгаалалтын захиргаа, бүх шатны Засаг дарга, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зэрэг олон субъект оролцохоор тогтоосон.

Энэхүү зохицуулалтын зорилго нь хамгаалалтын бодлогыг төв болон орон нутгийн түвшинд уялдуулан хэрэгжүүлэх, оролцоог хангах, хариуцлагыг хуваарилах явдал боловч хэрэгжилтийн түвшинд бүрэн эрхийн хуваарилалт нь институцийн уялдаа, хариуцлагын тодорхой байдлыг бүрэн хангаж чадахгүй байна.

(а) Бүрэн эрхийн давхардал, зааг тодорхойгүй байдал

Хуулиар олон субъектэд ижил төстэй чиг үүрэг олгосон боловч эдгээрийн хоорондын зааг тодорхой бус байгаагаас бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг давхцах, аль байгууллага эцсийн хариуцлага хүлээх нь тодорхойгүй болох, шийдвэр гаргалт олон шат дамжлагаар дамжин удаашрах нөхцөл үүсч байна.

Ялангуяа төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн захиргаа болон хамгаалалтын захиргааны хоорондын эрх хэмжээний зааг тодорхой бус байгаа нь хамгаалалтын бодлогыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна.

(б) Төв-орон нутгийн эрх мэдлийн зөрчил

Судалгааны явцад, тэр дундаа бүсийн хэлэлцүүлгүүдийн үр дүнгээс харахад орон нутгийн байгууллагууд, ялангуяа аймаг, сумын түвшинд хамгаалалтын дэглэмтэй зөрчилдөх шийдвэр гаргах, газар ашиглалт, аялал жуулчлал, дэд бүтцийн асуудлыг хамгаалалтын зорилготой уялдуулахгүй байх тохиолдлууд түгээмэл тэмдэглэгдсэн.

Энэ нь нэг талаас орон нутгийн оролцоог хангах зорилготой боловч нөгөө талаас хамгаалалтын бодлогын нэгдмэл байдал алдагдах, экосистемийн даац, бүсчлэлд суурилсан шийдвэр гаргалт хангагдахгүй байх сөрөг үр дагаварт хүргэжээ.

Шигтгээ 3.

“...хамгаалалтын захиргаа нэг зүйл хэлдэг, орон нутгийн удирдлага өөр шийдвэр гаргадаг. Аль нь эцсийн шийдвэр гаргах нь тодорхойгүй. Хариуцлага хэн хүлээх нь ойлгомжгүй...”

Бүсийн хэлэлцүүлгийн ярилцлагын тэмдэглэлийн хэсгээс

(в) Хамгаалалтын захиргааны институцийн чадавх

Хамгаалалтын захиргаа нь тусгай хамгаалалттай газар нутгийн өдөр тутмын менежментийг хэрэгжүүлэх үндсэн субъект боловч хүний нөөцийн хүрэлцээ, мэргэшил сул,

санхүүжилт тогтворгүй, гүйцэтгэлийн тодорхой шалгуур, үнэлгээний тогтолцоо сул байгаа нь бодит хэрэгжилтийн үр нөлөөг хязгаарлаж байна.

Үүний улмаас хамгаалалтын захиргаа бодлогын хэрэгжилтийг бүрэн хангах бус, зөвхөн хэлбэрийн төдий гүйцэтгэлийн түвшинд ажиллах хандлага ажиглагдаж байна.

(г) Хяналт, хариуцлагын тогтолцоо

Хяналтын чиг үүрэг олон байгууллагад хуваарилагдсан боловч мэдээллийн уялдаа сул, давхардсан шалгалт, хяналт, урьдчилан сэргийлэхээс илүү зөрчил гарсны дараах илэрүүлэх хандлага давамгайлах шинжтэй бөгөөд улсын тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой нийт 186 шүүхийн шийдвэр, мөн байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сангаас 140 бүртгэлийг түүвэрлэн авч, газарзүйн байршил болон хамгаалалтын захиргаадын харьяалалтай уялдуулан харьцуулж /Хүснэгт 6/ судлан үзлээ.

Хүснэгт 6. Тусгай хамгаалалттай газар нутагт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил

Бүсийн төв	Хамгаалалтын захиргаа	Бүртгэгдсэн хэрэг, зөрчил (тоо)	Агуулгын ангилал
Хан Хэнтийн бүс	Хан Хэнтийн УТХГ	2	Ойн сангийн зөрчил
Хан Хэнтийн бүс	Богдхан уулын ДЦГ	5	Зөвшөөрөлгүй мод бэлтгэл
Хан Хэнтийн бүс	Горхи-Тэрэлж БЦГ	8	Мод бэлтгэх, тээвэрлэх
Хан Хэнтийн бүс	Тужийн нарсны БЦГ	7	Мод бэлтгэх, гарал үүсэлгүй тээвэр
Хан Хэнтийн бүс	Зэд-Хантайн ДЦГ	6	Ойн сангийн зөрчил
Хан Хэнтийн бүс	Ноён уулын ДЦГ	4	Зөвшөөрөлгүй ашиглалт
Говь гурван сайхан бүс	Говь гурван сайхан БЦГ	1	Байгалийн нөөцийн зөрчил
Говь гурван сайхан бүс	Говийн их ДЦГ "А"	0	Бүртгэл илрээгүй
Говь гурван сайхан бүс	Их Богд уулын БЦГ	1	Байгаль орчны зөрчил
Говь гурван сайхан бүс	Говийн бага ДЦГ	0	Бүртгэл илрээгүй
Говь гурван сайхан бүс	Их газрын чулуу БЦГ	0	Бүртгэл илрээгүй
Дорнодын бүс	Дорнодын УТХГ	0	Бүртгэл илрээгүй
Дорнодын бүс	Нөмрөгийн ДЦГ	0	Бүртгэл илрээгүй
Дорнодын бүс	Дарьганы БЦГ	0	Бүртгэл илрээгүй
Дорнодын бүс	Онон-Балжийн БЦГ	2	Ан агнуур, ойн сангийн зөрчил
Дорнодын бүс	Гутайн даваа БЦГ	1	Байгалийн нөөц ашиглалт
Хангайн нурууны бүс	Хангайн нурууны БЦГ	3	Ойн сангийн зөрчил
Хангайн нурууны бүс	Отгонтэнгэрийн УТХГ	5	Зөвшөөрөлгүй мод бэлтгэл
Хангайн нурууны бүс	Хөвсгөлийн УТХГ	18	Мод бэлтгэх, тээвэрлэх, хохирол
Хангайн нурууны бүс	Улаан тайгын УТХГ	2	Байгалийн нөөцийн зөрчил
Хангайн нурууны бүс	Тарвагатайн БЦГ	9	Зөвшөөрөлгүй мод бэлтгэх
Хангайн нурууны бүс	Орхоны хөндийн БЦГ	12	Мод бэлтгэх, бүлэглэсэн үйлдэл
Хангайн нурууны бүс	Хөгнө-Тарнын БЦГ	4	Ойн сангийн зөрчил
Хангайн нурууны бүс	Тэсийн гол-Булнайн нуруу БЦГ	3	Байгаль орчны зөрчил
Хар-Ус нуурын бүс	Хар-Ус нуур УТХГ	3	Байгалийн нөөцийн зөрчил

Хар-Ус нуурын бүс	Увс нуурын ай сав УТХГ	4	Ан агнуур, мод бэлтгэл
Хар-Ус нуурын бүс	Ачит нуур-Дэвэлийн арал БЦГ	0	Бүртгэл илрээгүй
Хар-Ус нуурын бүс	Хан Хөхийн нуруу УТХГ	1	Ойн сангийн зөрчил
Хар-Ус нуурын бүс	Монгол Алтайн нуруу УТХГ	6	Мод бэлтгэх, ан агнуур
Хар-Ус нуурын бүс	Хөх Сэрхийн нуруу УТХГ	2	Байгалийн нөөц ашиглалт
Хар-Ус нуурын бүс	Мөнххайрханы БЦГ	2	Ойн сангийн зөрчил
Хар-Ус нуурын бүс	Говийн их ДЦГ “Б”	0	Бүртгэл илрээгүй
Хар-Ус нуурын бүс	Монгол элсний БЦГ	0	Бүртгэл илрээгүй
Хар-Ус нуурын бүс	Мянган угалзатын БЦГ	1	Байгаль орчны зөрчил

Эх сурвалж: [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан](#)

(д) Институцийн уялдаа, системийн асуудал

Дээрх нөхцөл байдлуудыг нэгтгэн үзэхэд бүрэн эрхийн хуваарилалт нь институцийн уялдааг хангахгүй, шийдвэр гаргалтыг нэгдсэн бодлогын хүрээнд чиглүүлэхгүй, харилцаанд олон субъект оролцдог боловч “хариуцлага төвлөрсөн” бус, харин “хариуцлага сарнисан” тогтолцоо бүрдсэн байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглалтай холбоотой зохицуулалт нь оролцоог хангах, төв–орон нутгийн уялдааг бий болгох зорилготой боловч хэрэгжилтийн түвшинд бүрэн эрхийн давхардал, зааг тодорхойгүй байдал, төв–орон нутгийн шийдвэрийн зөрчил, институцийн чадавхын сул байдал, хяналт, хариуцлагын тогтолцооны үр нөлөө сул зэрэг асуудлууд илэрч байгаа тул зорилгодоо бүрэн нийцээгүй гэж дүгнэв.

Үүний улмаас хамгаалалтын бодлогын хэрэгжилт нэгдмэл бус, үр нөлөө сул, хариуцлагын тогтолцоо тодорхой бус байдалд хүрч байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан менежментийн төлөвлөлт, санхүүжилттэй холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх. Эдгээр зохицуулалт нь хамгаалалтын үйл ажиллагааны тогтвортой байдал, үр нөлөөг хангах боломжийг бүрдүүлж байгаа эсэх.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд менежментийн төлөвлөлт, санхүүжилттэй холбоотой зохицуулалтыг хамгаалалтын бодлогыг бодит хэрэгжилт болгон хэрэгжүүлэх үндсэн механизм болгон тусгасан байдаг. Ялангуяа сүүлийн нэмэлт, өөрчлөлтөөр менежментийн төлөвлөгөөг 10 жилийн хугацаатай батлах, хэрэгжилтийг үнэлэх, шаардлагатай тохиолдолд шинэчлэх зохицуулалтыг нэвтрүүлсэн нь хамгаалалтын үйл ажиллагааг системтэй, урт хугацаанд төлөвлөх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна.

Гэвч эдгээр зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэхэд менежментийн төлөвлөлт болон санхүүжилтийн механизм нь хамгаалалтын бодлогын зорилгыг бодитой хэрэгжүүлэх түвшинд бүрэн хүрээгүй байна.

(а) Менежментийн төлөвлөлтийн бодит хэрэгжилт

Хуулиар тусгай хамгаалалттай газар нутаг бүр менежментийн төлөвлөгөөтэй байхаар зохицуулсан боловч практикт төлөвлөгөө хэлбэрийн шинжтэй, газар ашиглалт, бүсчлэл, зөвшөөрлийн шийдвэртэй уялдахгүй, хэрэгжилтийн хяналт, үнэлгээ сул байгаа нь ажиглагдаж байна.

Олон тохиолдолд менежментийн төлөвлөгөө нь бодит шийдвэр гаргалтад ажиглагдахгүй, харин шаардлага хангах зорилгоор заавал байх баримт бичгийн бүрдлийн хэмжээнд боловсруулагдсан хэрэгжихгүй цаасан дээр үлдэж байна. Үүний улмаас хамгаалалтын зорилго бодит менежментийн үйл ажиллагаанд бүрэн тусгагдахгүй, төлөвлөлт-хэрэгжилтийн зөрүү үүсч байна.

Шигтгээ 4.

“...менежментийн төлөвлөгөө байдаг боловч хэрэгжүүлэх санхүүжилт байдаггүй. Төлөвлөгөө батлагддаг ч төсөвтэй уялддаггүй. Ихэнх тохиолдолд тухайн жилд төсөвт орсон ажлыг л хийдэг...”

Бүсийн хэлэлцүүлгийн ярилцлагаас

Зураг. 2 Менежментийн төлөвлөлт болон санхүүжилт



(б) Санхүүжилтийн тогтолцоо

Хуулиар тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийг улсын төсөв, төсөл, хөтөлбөр, хандив зэрэг олон эх үүсвэрээс бүрдүүлэхээр заасан боловч бодит байдал дээр санхүүжилт тогтворгүй, урсгал зардалд төвлөрсөн, гүйцэтгэл, үр дүнтэй уялдаагүй байна.

Түүнчлэн байгалийн нөөц ашигласны төлбөр, аялал жуулчлал, зөвшөөрлийн орлого зэрэг эх үүсвэр нь хамгаалалтын үйл ажиллагаанд шууд буцаж хуваарилагдах механизм сул байгаа нь хамгаалалтын байгууллагуудын санхүүгийн бие даасан байдал, тогтвортой байдлыг хязгаарлаж, төсвөөс шууд хамааралтай болгож байна.

Зураг. 3 УТХГ-ын хамгаалалтын захиргааны төсвийн зарлагын гүйцэтгэл, 2023 он

№	Хамгаалалтын захиргааны нэр	Харьяалах ТХГН	Хамраах талбай (га)	Нэг байгаль хамгаалагчид нолдох талбай (га)	Батлагдсан төсөв (сая.төг)	Гүйцэтгэл (сая.төг)	Зөрүү (сая.төг)	Гүйцэтгэлийн хувь
1	Хан Хэнтийн УТХГ	Хан хэнтий ДЦГ, Өндөрхаан уул БЦГ, Биндэрьяа хан уул ДГ, Хангал нуур ДГ	1,762,660.37	46,385.80	1,635.20	1,487.80	-147.5	91.00%
2	Богдхан уулын ДЦГ	Богдхан уул ДЦГ	42,192.36	1,834.45	1,430.90	1,352.80	-78.1	94.50%
3	Горхи-Тэрэлж БЦГ	Горхи-Тэрэлж БЦГ, Нагалхаан уул БНГ	295,396.17	32,821.80	874.4	778.6	-95.8	89.00%
4	Түжийн нарсны БЦГ	Түжийн нарс БЦГ	70,804.72	14,160.94	403.8	361.8	-41.9	89.60%
5	Зэд-Хантайн ДЦГ	Зэд-Хантай-Бүтээлийн нуруу ДЦГ	604,265.56	46,482.73	689.55	567.91	-121.64	82.30%
6	Ноён уулын ДЦГ	Ноён уул ДЦГ	22,320.00	3,720.00	—	—	—	—
7	Говь гурван сайхан БЦГ	Говь гурван сайхан БЦГ	2,697,170.84	107,886.83	961.7	753.8	-207.9	78.40%
8	Говийн их ДЦГ "А"	Говийн их ДЦГ, Ээж хайрхан ДГ	6,469,024.67	281,262.81	743.91	612.35	-131.56	82.40%
9	Их Богд уулын БЦГ	Заг байддрэгийн голын эхэн сав БЦГ, Их Богд уул БЦГ	379,164.35	25,277.62	668.2	519.1	-149.1	77.70%
10	Говийн бага ДЦГ	Говийн бага ДЦГ	1,830,429.42	96,338.39	748.62	704.33	-44.3	94.10%
11	Их газрын чулуу БЦГ	Их газрын чулуу БЦГ	175,906.14	43,976.54	365.4	295.2	-70.2	80.80%
12	Дорнодын Улсын тусгай хамгаалалттай газар	Дорнод Монгол ДЦГ, Монгол дагуур ДЦГ, Тосон хулстай БНГ, Угтам БНГ, Яхь нуур БНГ	1,453,808.61	121,150.72	723.02	510.07	-212.95	70.50%
13	Нөмрөгийн ДЦГ	Нөмрөг ДЦГ	320,979.46	35,664.38	495.88	404.39	-91.5	81.50%
14	Дарьганы БЦГ	Дарьганга БЦГ	64,547.60	6,454.76	520.1	425.5	-94.7	81.80%
15	Онон-Балжийн БЦГ	Онон-Балж БЦГ, Өндөрхаан уул БЦГ, Хар ямаат БНГ	484,757.49	44,068.86	700.5	675.1	-25.4	96.40%
16	Гутайн даваа БЦГ	Гутайн даваа БЦГ	102,640.69	20,528.14	286.3	246.3	-40.1	86.00%
17	Хангайн нурууны БЦГ	Ноён хангай БЦГ, Хангайн нуруу БЦГ	995,742.66	82,978.56	678.2	647.5	-30.7	95.50%
18	Отгонтэнгэрийн УТХГ	Отгонтэнгэр уул ДЦГ, Тарвагатайн нуруу БЦГ	638,128.55	39,883.03	733.79	642.51	-91.28	87.60%
19	Хөвсгөлийн УТХГ	Хөвсгөл БЦГ, Даяндээрхийн агуй ДГ	1,206,879.38	44,699.24	1,225.70	1,078.20	-147.4	88.00%
20	Улаан тайгын УТХГ	Улаан тайга ДЦГ, Хорьдол сарьдаг ДЦГ, Тэнгис-Шилгэдийн голын ай сав БЦГ	1,534,077.76	47,939.93	1,145.20	876.9	-268.3	76.60%
21	Тарвагатайн БЦГ	Тарвагатайн нуруу БЦГ	547,629.89	45,635.82	657.4	588.4	-69.1	89.50%
22	Орхоны хөндийн БЦГ	Орхоны хөндий БЦГ, Хүйсийн найман нуур ДГ	92,717.99	7,132.15	710.3	666.4	-43.9	93.80%
23	Хөгнө-Тарнын БЦГ	Хөгнө-Тарна БЦГ	84,143.06	12,020.44	460.6	353.4	-107.2	76.70%
24	Тэсийн гол-Булнайн нуруу БЦГ	Тэсийн гол-Булнайн нуруу БЦГ	369,630.89	73,926.18	—	—	—	—
25	Хар-Ус нуур УТХГ	Хар ус нуур БЦГ, Шарга манхан БНГ	1,249,286.04	73,487.41	737.1	633.3	-103.7	85.90%
26	Увс нуурын ай сав УТХГ	Увс нуурын ай сав ДЦГ	755,244.05	47,202.75	901.5	846.6	-54.9	93.90%
27	Ачит нуур-Дэвэлийн арал БЦГ	Дэвэлийн арал БНГ	211,552.83	30,221.83	—	—	—	—
28	Хан Хөхийн нуруу УТХГ	Хан Хөхийн нуруу, Хяргас нуурын БЦГ	221,598.00	14,773.20	714.8	630.7	-84.1	88.20%
29	Монгол Алтайн нуруу УТХГ	Алтай таван богд БЦГ, Сийлэмийн нуруу БЦГ, Цамбагарав уул БЦГ	917,712.65	61,180.84	690.6	656.5	-34.1	95.10%
30	Хөх Сэрхийн нуруу УТХГ	Хөх Сэрхийн нуруу ДЦГ, Чигэртэйн голын ай сав БЦГ	242,938.39	34,705.48	413.88	398.81	-15.06	96.40%
31	Мөнххайрханы БЦГ	Мөнххайрхан БЦГ	506,094.61	29,770.27	718.9	554.9	-164	77.20%
32	Говийн их ДЦГ "Б"	Говийн их ДЦГ, Алаг хайрхан БНГ	6,469,024.67	308,048.79	777.73	557.82	-219.92	71.70%
33	Монгол элсний БЦГ	Хасагт хайрхан ДЦГ, Монгол Элс БЦГ	298,073.88	49,678.98	425.3	405.1	-20.2	95.30%
34	Мянган угалзатын БЦГ	Мянган Угалзатын нуруу БЦГ	303,774.59	30,377.46	517.4	412.5	-104.8	79.70%

Эх сурвалж: БОУАӨЯам

(в) Төлөвлөлт–санхүүжилтийн уялдаа

Менежментийн төлөвлөгөө болон санхүүжилтийн хоорондын уялдаа хангалтгүй байгаа нь системийн гол асуудлын нэг болсон буюу төлөвлөгөөнд туссан үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилт баталгааждаггүй, санхүүжилт нь төлөвлөгөөнд бус, төсвийн боломжид тулгуурлан хуваарилагддаг, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн механизм бүрдэхгүй байгаа нь төлөвлөлтийг бодит хэрэгжилтээс салангид болгож, менежментийн үр нөлөөг эрс бууруулж байна.

Шигтээ 6.

“...тусгай хамгаалалттай газар нутгаас орлого ордог ч тэр нь хамгаалалтын захиргаанд буцаж ирдэггүй. Төлбөр, хураамж төв рүү орчихдог, харин хамгаалалтын ажил хийх мөнгө хүрэлцдэггүй...”

Бүсийн хэлэлцүүлгийн ярилцлагаас

(г) Үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээ

Хуулиар менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх зохицуулалт байгаа боловч үнэлгээний шалгуур тодорхой бус, хэрэгжилтийн үр дүнг бодитой хэмжих тогтолцоо сул, үнэлгээ нь дараагийн төлөвлөлт, санхүүжилтэд нөлөөлөхгүй байгаа байдал ажиглагдаж байна.

Иймээс менежментийн төлөвлөлт нь “үр дүнд суурилсан удирдлагын хэрэгсэл” бус, харин “хэлбэрийн төдий баримт бичгийн” түвшинд хэрэгжиж байгаа тул хамгаалалтын үйл ажиллагааны тогтвортой байдал, үр нөлөөг хангах боломжийг бүрэн бүрдүүлж чадахгүй, уг зохицуулалт нь зорилгодоо бүрэн хүрээгүй гэж дүгнэж байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 5. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан мэдээлэл, бүртгэл, шийдвэр гаргалтын уялдаатай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх. Мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтын эрх зүйн орчин бүрдсэн эсэх.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд хамгаалалтын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл, бүртгэл, судалгаа, тайлангийн тогтолцоог бүрдүүлэх, түүнийг шийдвэр гаргалтад ашиглах эрх зүйн үндсийг тодорхойлсон байдаг. Энэ хүрээнд кадастр, газар ашиглалтын бүртгэл, судалгаа шинжилгээ, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээлэл зэрэг нь хамгаалалтын бодлого, шийдвэр гаргалтын суурь болох ёстой.

Гэвч эдгээр зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэхэд мэдээлэл–шийдвэр гаргалтын уялдаа бодит түвшинд бүрэн хангагдаагүй байна.

(а) Мэдээллийн сан, бүртгэлийн тогтолцоо

Хуулиар мэдээлэл, бүртгэлийг бүрдүүлэхээр зохицуулсан боловч бодит байдал дээр мэдээллийн сангууд салангид, стандарт, ангилал жигд бус, өгөгдөл давхардсан, зөрүүтэй байх

тул тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх мэдээлэл нэгдсэн, үнэн зөв, шуурхай хэлбэрээр ашиглагдах боломж хязгаарлагдаж байна.


(б) Мэдээллийн чанар, хүртээмж

Мэдээллийн шинэчлэлт тогтмол бус, зарим тохиолдолд хуучирсан, бүрэн бус мэдээлэл ашиглагдаж байгаа нь шийдвэр гаргалтын чанарт сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн, мэдээлэл олон нийт, оролцогч талуудад хүртээмжтэй, ил тод хэлбэрээр хүрэхгүй байгаа нь оролцогч талуудын итгэл, оролцоог бууруулах, хяналт, ил тод байдлыг сулруулах нөхцөл бүрдүүлж байна.

(в) Шийдвэр гаргалтад ашиглагдах байдал

Мэдээлэл тодорхой хэмжээнд бүрдэж байгаа боловч бодит шийдвэр гаргалтад системтэйгээр ашиглагдахгүй, төлөвлөлт, зөвшөөрөл, бүсчлэлтэй уялдахгүй, бодлогын сонголтыг нотлох хэрэгсэл болж чадахгүй. Өөрөөр хэлбэл, шийдвэр гаргалт нь өгөгдөлд бус, институцийн практик, захиргааны шийдвэрт илүү тулгуурлах хандлага давамгайл /Зураг 4/ байна.

Зураг. 4 Өгөгдөл байгаа хэдий ч шийдвэр гаргалтад ашиглахгүй байна



(г) Институцийн уялдаа

Мэдээлэл бүрдүүлэх, ашиглах үүрэг бүхий байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох механизм сул, хариуцлагын зааг тодорхой бус, нэгдсэн платформ, стандарт дутмаг байгаа нь мэдээллийн уялдааг алдагдуулж байна.

Дээрх байдлыг дүгнэвэл, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан мэдээлэл, бүртгэл, шийдвэр гаргалтын уялдаатай холбоотой зохицуулалт нь онолын хувьд мэдээлэлд суурилсан удирдлагын эрх зүйн үндсийг бүрдүүлсэн боловч мэдээллийн сангийн нэгдмэл байдал хангалтгүй, мэдээллийн чанар, шинэчлэлт сул, мэдээлэл шийдвэр гаргалтад системтэй ашиглагдахгүй, институцийн уялдаа хангалтгүй байгаа тул мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтын орчин бүрэн бүрдээгүй дүгнэж байна.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан тусгай хамгаалалттай газар нутгийн ангилалын ялгаа газар ашиглалтын шийдвэрт бодитоор нөлөөлж байна уу? Орон нутгийн хамгаалалтад авах шийдвэрүүдэд шинжлэх ухааны үнэлгээ хангалттай байна уу?

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйлд улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэсэн дөрвөн ангиллаар тогтоож, хамгаалалтын дэглэмийг шаталсан байдлаар хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна.

Дархан цаазат газруудыг он цагийн дарааллаар авч үзэхэд Монгол Улсад байгаль хамгааллын бодлого үе шаттайгаар хөгжиж, 1950-иад оноос эхлэн хууль, тогтоомжийн хүрээнд өргөжин тэлж ирсэн байна. Ялангуяа 1990-ээд оноос хойш тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ эрчимтэй нэмэгдэж, экосистемийн төлөөллийг хамгаалах бодлого илүү системтэй хэрэгжиж эхэлсэн нь харагдаж байна.

Дархан цаазат газрын талаарх дээрх мэдээлэл нь тусгай хамгаалалттай газар нутгийн тогтолцоо нь нэг удаагийн шийдвэр бус, урт хугацаанд үе шаттайгаар бүрэлдэн тогтсон бодлогын үр дүн болохыг харуулж байна. Байгалийн цогцолборт газруудыг он цагийн дарааллаар авч үзэхэд Монгол Улсад тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ 1990-ээд оноос хойш эрчимтэй өргөжин тэлж, экосистемийн төлөөллийг бүс нутгийн түвшинд хамгаалах бодлого системтэй хэрэгжиж эхэлсэн үетэй давхцаж байна. Ялангуяа уул, нуур, ой, хээрийн экосистемийг хамарсан цогц хамгаалалтын хэлбэр давамгайлжээ.

Байгалийн цогцолборт газрын ангилал нь дархан цаазат газартай харьцуулахад илүү уян хатан хамгаалалтын дэглэмтэй бөгөөд аялал жуулчлал, уламжлалт ашиглалт, нутгийн иргэдийн оролцоог тодорхой хэмжээнд зөвшөөрдөг онцлогтой байна. Иймд энэхүү ангилал нь хамгаалалт болон ашиглалтын тэнцвэрийг хангах бодлогын гол хэрэгсэл болсон.

Байгалийн нөөц газар нутгууд нь тодорхой экосистем, амьтан, ургамлын нөөцийг хамгаалах зорилгоор үе шаттайгаар хамгаалалтад авсан байна. Төрийн захиргааны төв байгууллагаас баримталж буй бодлогын хүрээнд 2010 оноос хойш байгалийн нөөц газрын ангилалд шинээр газар нутгууд нэмэгдэх хандлага ажиглагдаж, бүс нутгийн экосистемийн тэнцвэрийг хадгалах бодлого идэвхжиж байна.

Байгалийн нөөц газрын ангилал нь тодорхой нөөцийг хамгаалах зорилготой бөгөөд бусад ангилалтай харьцуулахад хамгаалалтын зорилго илүү чиглэсэн, тодорхой объектод төвлөрсөн онцлогтой байна. Иймд энэхүү ангилал нь биологийн олон янз байдлын тодорхой бүрэлдэхүүн хэсгийг хамгаалах бодлогын чухал арга хэлбэр болсон байна.

Дурсгалт газрууд нь байгалийн өвөрмөц тогтоц, геологийн онцлог, түүх соёлын ач холбогдол бүхий объектуудыг хамгаалах зорилгоор үе шаттайгаар хамгаалалтад авсан байна. Сүүлийн жилүүдэд дурсгалт газрын ангилалд шинэ газар нутгууд нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа нь байгалийн өвийг хамгаалах бодлогын хүрээ өргөжиж байгааг илтгэнэ.

Дурсгалт газрын ангилал нь бусад ангиллаас ялгаатайгаар тодорхой байгалийн өвөрмөц объект, тогтоц, түүх-соёлын ач холбогдол бүхий газрыг хамгаалахад чиглэдэг бөгөөд хамгаалалтын дэглэм нь харьцангуй хязгаарлагдмал, тодорхой объект төвтэй байдаг онцлогтой байна.

Эдгээр ангилал нь хамгаалалтын зорилго, ашиглалтын хэлбэр, дэглэмийн ялгааг тодорхойлох замаар газар ашиглалтын шийдвэрийг ялгамжтай, шинжлэх ухаанд суурилсан байдлаар гаргах үндсэн хэрэгсэл байх ёстой хэдий ч ангиллын ялгаа менежментийн бодит ялгаралд бүрэн тусахгүй, хамгаалалтын дэглэмийн хэрэгжилт жигд бус, газар ашиглалтын шийдвэр ангиллын онцлогт зарим талаар нийцэхгүй байгаа нь ажиглагдаж байна.

(б) Орон нутгийн хамгаалалтын тэлэлт: тоон өсөлт ба чанарын асуудал

Сүүлийн жилүүдэд энэхүү зохицуулалтын хүрээнд орон нутгийн түвшинд тусгай хамгаалалттай газар нутгийн тоо, хамрах хүрээ эрчимтэй нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг нийтдээ 1370 (аймаг хотын 517, сум дүүргийн 853) байршилд 30,523,902.552 га буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 19.37% нь орон нутгийн хамгаалалтад авагдаад байна⁸.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг гол төлөв усны эх, ус хангамжийн бүс, уул, нуруу, бэлчээрийн бүс, байгалийн өвөрмөц тогтоц, орон нутгийн экологийн эмзэг бүсүүдийг хамгаалах зорилгоор тусгай хамгаалалтад авах чиг баримжаатай байх бөгөөд “Экологийн хувьд чухал ач холбогдол бүхий газар нутгийн үнэлгээ” судалгааны илтгэлд дурдсанаар⁹ орон нутгийн

⁸ Де Нэйче Консерванси (TNC) Байгаль хамгааллын ОУТББ, Орон нутгийн Тусгай хамгаалалттай газар нутгийн Орон зайн дүн шинжилгээний тайлан, Зөвлөх Док. Р. Самъяа, Э. Одбаатар, С. Энхболд, 2025 он.,


⁹ Де Нэйче Консерванси (TNC) Байгаль хамгааллын ОУТББ Байгаль хамгаалал, төлөвлөлт хариуцсан зохицуулагч Н. Жавзансүрэн

тусгай хамгаалалттай газар нутгийг эрх зүйн, экологийн, газар зүй, орон зайн болон соёл, нийгэм-эдийн засаг гэсэн үндсэн 4 шалгуураар үнэлж үзэхэд 14.8 сая га талбайгаар буюу нийт газар нутгийн 9.45 хувиар улсын тусгай хамгаалттай газар нутгийг өргөжүүлэх боломжтой байна. Гэвч орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн энэхүү хурдацтай өсөлт нь дараах бодлогын шинжтэй асуудлуудыг үүсгэж байна. Үүнд:

- улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээтэй уялдахгүй, давхардал үүсэх,
- кадастр, газар ашиглалтын бүртгэлтэй зөрчилдөх,
- хамгаалалтын дэглэм, менежментийн стандарт тодорхой бус байх,
- санхүүжилт, хүний нөөцийн чадавх хүрэлцэхгүй байх,
- хамгаалалтын бодит үр нөлөө сулрах эрсдэл бий болох зэрэг орно.

Иймд орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг шинээр тогтоох, өргөтгөх үйл ажиллагааг үндэсний түвшний төлөвлөлт, экологийн үнэлгээ, нэгдсэн мэдээллийн системтэй уялдуулах, давхардлыг арилгах, хамгаалалтын үр нөлөөг нэмэгдүүлэх институцийн болон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Зураг. 5 Улсын болоод орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ



Эх сурвалж: Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн орон зайн дүн шинжилгээ, Судалгааны тайлан 2025 он

Нөгөө талаар тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллын тогтолцоо нь онолын хувьд газар ашиглалтын шийдвэрийг ялгамжтай, шинжлэх ухаанд суурилсан байдлаар гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн боловч практикт ангиллын ялгаа бодит шийдвэр гаргалтад хангалттай нөлөөлөхгүй, менежментийн ялгарал ойлгомж муутай, орон нутгийн хамгаалалтын шийдвэрүүд шинжлэх ухааны үндэслэл гэхээс уул уурхайн хориглолт хэлбэртэй, хамгаалалтын сүлжээний

уялдаа алдагдсан, мэдээлэл, бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байгаа тул уг зохицуулалт практикт бүрэн нийцэж, үр дүнтэй хэрэгжихгүй байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг санхүүжүүлэх зохицуулалтын хэрэгжилт, практикт тулгарч буй асуудал

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд хамгаалалтын үйл ажиллагааны санхүүжилтийн бүтэц, эх үүсвэрийг өргөн хүрээнд зохицуулсан бөгөөд хамгаалалтын ажлын төсөв нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, судалгаа шинжилгээ, мониторинг, сурталчилгаа, ажиллагсдын цалин хөлс зэрэг зардлаас бүрдэхээр, санхүүжилтийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, аялал жуулчлалын болон үйлчилгээний орлого, хандив тусламж, байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр, тусгай сангийн орлого, байгалийн нөөц ашигласны болон бэлчээр ашигласны төлбөр, нэвтрэх хураамж зэрэг олон төрөлтэй байхаар хуульчилсан байна.

Хуульд оруулсан 2023 оны нэмэлт, өөрчлөлтөөр нэвтрэх хураамж, байгалийн нөөц ашигласны болон бэлчээр ашигласны төлбөрийг санхүүжилтийн эх үүсвэрт тодорхой тусгасан нь орлогын эрх зүйн хүрээг өргөжүүлсэн боловч эдгээр эх үүсвэрийг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах нэгдсэн, уялдаа бүхий механизм бүрэн бүрдээгүй хэвээр байна.

Төлбөр, хураамжийн зохицуулалтын хувьд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын журмуудын хооронд уялдаа сул байгаа нь орлого бүрдүүлэх практикт давхардал, тодорхой бус байдал үүсгэж байна. Мөн Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэх орлогын эх үүсвэрийг хуульд заасан боловч орлого бүрдүүлэх, шилжүүлэх, зарцуулах нэгдсэн аргачлал батлагдаагүй хэвээр байна.

БОАЖ-ын сайдын 2023 оны А/71 тушаалаар нэвтрэх хураамжийн хэмжээг шинэчилсэн боловч орлогын санхүүгийн урсгалыг бүрэн хянах, бүртгэх нэгдсэн систем нэвтрээгүй, экологи-эдийн засгийн үнэлгээнд суурилсан хохирлын төлбөрийг төвлөрүүлэх механизм тодорхой журамд нэгтгэгдээгүй байна. Түүнчлэн нэвтрэх хураамжийг төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах харилцааг хэрхэн зохицуулах талаар тодорхой зохицуулалтгүй явж ирсэн нь санхүүгийн урсгалын ил тод байдал, үр ашигт сөргөөр нөлөөлж байна.

(а) Санхүүжилтийн бүтэц ба зардлын онцлог

Өнгөрөгч 2021–2025 оны хугацаанд тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны улсын төсвөөс олгогдох нийт санхүүжилтийн хэмжээ жилд дунджаар 21.7 тэрбум төгрөг байсан бөгөөд үүний 91.5 хувь нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалтын зардалд зарцуулагдсан байна.¹⁰ Өөрөөр хэлбэл, менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан

¹⁰ БОУАӨЯамын тоот мэдээлэл, 2025 он

хамгаалалт, судалгаа, хяналт-шинжилгээний бодит үйл ажиллагаанд нийт төсвийн 8.5 хувиас ихгүй хэсэг ноогдож байна.

Ийм зардлын бүтэц нь хамгаалалтын бодлогыг газар дээр хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, хамгаалалтын дэглэмийн бодит хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

2026 оны байдлаар тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын үндсэн хөрөнгийн хэмжээг ойролцоогоор 4 дахин нэмэгдүүлэх, түүнчлэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд жил бүр 16.0 тэрбум төгрөгөөс багагүй нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр бий болгох шаардлагатай байна.¹¹ Одоогийн байдлаар тоног төхөөрөмж, эд хөрөнгийн хэрэгцээний ихээхэн хэсгийг олон улсын төсөл, хөтөлбөрөөр хангаж ирсэн нь санхүүжилтийн тогтвортой байдлын эрсдэл дагуулж байна.

График. 1 Хамгаалалтын захиргаадын санхүүжилт



Эх сурвалж: Өнө мөнхийн Монгол” хөтөлбөрийн зохицуулах нэгж

(б) Орлогын гүйцэтгэл ба динамик

Санхүүжилтийн бодит гүйцэтгэлийг авч үзвэл 2013–2016 оны хугацаанд жуулчдын тоо өссөн ч орлого харьцангуй бага түвшинд байсан бөгөөд 2016 онд 346,868 жуулчин бүртгэгдсэн боловч нийт орлого 280.4 сая төгрөг байсан нь нэгж жуулчнаас олох орлого бага байсныг илтгэнэ.

Харин 2017–2025 оны хооронд дараах өөрчлөлт ажиглагдаж байна:

- 2017–2019 онд аялал жуулчлалын урсгал өсөж, орлого тогтвортой нэмэгдсэн;
- 2020–2021 онд COVID-19 цар тахлын нөлөөгөөр орлого огцом буурсан;

¹¹“Өнө мөнхийн Монгол” хөтөлбөр-ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын суурь судалгаа, 2025.

- 2022 оноос хойш аялал жуулчлал эрчимтэй сэргэж, 2025 оны байдлаар орлого 30 орчим тэрбум төгрөгт хүрэх түвшинд өссөн,

Газрын төлбөрийн орлого мөн өсөх хандлагатай байгаа бөгөөд 2013–2016 онд 5–7 тэрбум төгрөгийн түвшинд байсан бол 2025 оны урьдчилсан тооцооллоор 30 гаруй тэрбум төгрөгт хүрэх боломжтой байна.

(в) Системийн зөрчил: орлого ба зарцуулалтын зөрүү

Төсвийн тухай хуулийн дагуу төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон бусад орлого нь улсын төсвийн орлогын бүрэлдэхүүнд хамаарахаар зохицуулагдсан. Тусгай хамгаалалттай газар нутаг нь төрийн өмчийн газрын ангилалд хамаарах тул түүнийг ашигласнаас үүсэх нэвтрэх хураамж, газар ашиглалтын төлбөр зэрэг орлого нь улсын төсөвт төвлөрч, нэгдсэн төсвөөр дамжин дахин хуваарилагддаг.

Шигтээ 7.

“...жуулчлалаас орлого ордог ч хамгаалалтын захиргаанд шууд буцаж ирдэггүй...”
 “...орлого байгаа хэрнээ хамгаалалтын ажилд зарцуулах эрх, механизм тодорхой биш...”
 “...төсөл, хөтөлбөрөөс хамааралтай байдал өндөр байна...”

Бүсийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс

Хэдийгээр Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд эдгээр орлогыг хамгаалалтын захиргааны орлого гэж тогтоосон боловч бодит байдалд уг зохицуулалт бүрэн хэрэгжихгүй байна. Ингэснээр хуульд заасан орлогын харьяалал болон төсвийн хуульд заасан төвлөрүүлэх зарчим хооронд зөрчил үүсч, санхүүжилтийн бодит урсгал хуулийн зорилгод нийцэхгүй байна.

Хүснэгт. 7 ТХГНХЗ-дад төвлөрсөн орлого, сая төгрөг

	2020	2021	2022	2023	2024	2025
Улсын төсөв	9,380.3	9,415.4	9,398.2	18,639.3	31,467.8	32,758.7
Орон нутгийн төсөв	97.8	94.4	137.7	324.7	627.3	615.0
Нэвтрэх хураамж	283.5	302.9	443.8	3,268.9	4,169.4	4,641.8
ОУБСанхүүжилт	2,127.3	1,857.1	1,006.9	2,234.1	2,845.4	2,931.9
Хандив	25.0	36.0	115.3	22.0	15.6	22.0
НИЙТ	11,913.9	11,706.2	11,101.8	24,587.4	39,194.3	40,969.4

Эх сурвалж: “Өнө мөнхийн Монгол” хөтөлбөрийн Төслийн зохицуулах нэгж


Дээрх хүснэгтээс харахад 2020–2025 оны хугацаанд нийт орлогын хэмжээ огцом өссөн боловч:

- орлогын удирдлагын тогтолцоо сайжраагүй,
- орлогын тодорхой хэсэг хамгаалалтад эргэн зарцуулагдахгүй,
- зардлын бүтэц урсгал зардалд төвлөрсөн хэвээр,
- олон эх үүсвэр бодит байдалд бүрэн ашиглагдахгүй зэрэг асуудлууд үргэлжилсээр байна.

(г) Эрсдэл: орлогын тогтворгүй байдал

Нэвтрэх хураамжийн орлого 2023 оноос огцом өссөн шалтгаан нь нүүрс тээврийн машинаас нэвтрэх хураамж авч байсантай холбоотой бөгөөд Улсын дээд шүүхийн 2025 оны 001/ХТ2025/0068 тоот шийдвэрээр¹² БОУАӨСайдын 2024 оны “Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийн хэмжээ”-ний тухай А/844 дугаар тушаалын Хавсралтын “1.Дархан цаазат газар” гэсэн 1 дэх хүснэгтийн “Ачааны тээврийн машин” гэсэн баганад 50,000 төгрөг” гэж заасныг хүчингүй болгосон тул цаашид нэвтрэх хураамжийн орлого 2022 оны түвшинд хүрч буурах нөхцөл бүрдсэнийг тэмдэглэх нь зүйтэй байна.

График. 2 Нэвтрэх хураамжийн орлого, тэрбум төгрөг



Эх сурвалж: Өнө мөнхийн Монгол” хөтөлбөрийн зохицуулах нэгж

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан санхүүжилтийн зохицуулалт нь эх үүсвэрийн хувьд өргөн хүрээг хамарсан, эрх зүйн суурь орчныг бүрдүүлсэн боловч орлого төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах нэгдсэн механизм бүрдээгүй, хууль хоорондын уялдаа сул, орлого хамгаалалтын үйл ажиллагаанд шууд ашиглагдахгүй, зардлын бүтэц урсгал зардалд төвлөрсөн, санхүүжилтийн тогтвортой байдал хангалтгүй байгаа тул уг зохицуулалт практикт бүрэн нийцэж, хамгаалалтын бодит үр нөлөөг хангах түвшинд хэрэгжихгүй байна.

Иймээс санхүүжилтийн эрх зүйн хүрээ бүрдсэн боловч бодит санхүүгийн урсгал, зарцуулалтын тогтолцоо нь хуулийн зорилготой нийцэхгүй, хамгаалалтын үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлэх хэмжээнд хүрээгүй байна.

¹² Улсын дээд шүүхийн 2025 оны 001/ХТ2025/0068 тоот шийдвэрийн хураангуй. https://shuukh.mn/single_case/3412?daterange=2025-01-01%20-%202025-12-31&id=3&court_cat=3&bb=1

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 7–25 дугаар зүйлд заасан хамгаалалтын дэглэм, дотоод бүсчлэл практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Бүсчлэл нь бодит шийдвэр гаргалтад ашиглагдаж байгаа эсэх.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 7–25 дугаар зүйлд дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газрын ангилал тус бүрт тохирсон хамгаалалтын дэглэмийг тогтоож, мөн тухайн газрын дотоод бүсчлэлийг (онгон, хамгаалалтын, хязгаарлалтын, аялал жуулчлалын бүс гэх мэт) ялган зохицуулсан. Эдгээр зохицуулалт нь хамгаалалт–ашиглалтын ялгамжтай менежментийг хэрэгжүүлэх, хүний үйл ажиллагааны дарамтыг зохистой удирдах, экосистемийн тэнцвэрийг хадгалах үндсэн хэрэгсэл байх ёстой.

Дээрх зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэхэд хамгаалалтын дэглэм болон дотоод бүсчлэл нь бодит шийдвэр гаргалтад бүрэн ашиглагдахгүй, байгалийн учир шалтгаан, ан амьтны тархалт, шинжлэх ухааны үндэслэл гэхээсээ илүүтэй шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн хандлага, хүний хүчин зүйлс давамгайлж байна.

(а) Бүсчлэлийн хэрэгжилт ба менежментийн уялдаа

Хуульд заасан дотоод бүсчлэл нь менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байдаг боловч бодит хэрэгжилтийн түвшинд газар ашиглалтын шийдвэр бүсчлэлтэй уялдахгүй байх, зөвшөөрөл олголтод бүсийн дэглэм бодит шалгуур болохгүй, төлөвлөгөө нь шийдвэр гаргалтад нөлөөлөхгүй, хэлбэрийн шинжтэй баримт бичгийн шинжийг агуулж байна.

Энэхүү нөхцөл байдлыг бодит жишээгээр авч үзвэл, Богдхан уулын дархан цаазат газрын дотоод бүсчлэл нь 2014 оноос хойш олон удаа шинэчлэгдсэн байна. Тухайлбал, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын сайдын 2014 оны А-393, 2015 оны А/291, 2020 оны А/429, 2022 оны А/405, А/243, 2024 оны А/78, 2025 оны А/452 дугаар тушаалуудын дагуу дотоод бүсчлэлийг удаа дараа шинэчлэн баталсан байна. Мөн дотоод бүсүүдийн талбайд өөрчлөлт орж, тухайлбал хамгаалалтын бүс 2022 онд 28,490.03 га-с хоёр жилийн хугацаанд 28,050.41 га болж буурсан, хязгаарлалтын бүс 6,859.56 га-аас 6,443 га хүртэл өөрчлөгдсөн бол нийт талбайн хэмжээ 2022-2025 оны хооронд 843.76 га талбайгаар багассан байна.

Зураг. 6 Богдхан уулын дархан цаазат газрын дотоод бүсэд орсон өөрчлөлт

Дотоод бүсчлэл	2014 оны А-392	2020 оны А/429	2022 оны А/405	2022 оны А/243	2024 оны А/78	2025 оны А/452
Онгон бүс				6,921.66 га	6,921.66 га	6,921.66 га
Хамгаалалтын бүс				28490,03 га	28050,41	28062,54 га
Хязгаарлалтын бүс				6859,56 га	6455,82 га	6443,29 га
Нийт				42,271.25 га	41,427.89 га	41,427.49 га

Эх сурвалж: Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, 2025 он

Эдгээр өөрчлөлтүүд нь дотоод бүсчлэл тогтворгүй, байнга өөрчлөгдөж байгааг харуулж байгаа бөгөөд бүсчлэл нь тогтвортой, урт хугацааны менежментийн суурь хэрэгсэл болохоос илүү захиргааны шийдвэрээр байнга өөрчлөгдөх шинжтэй байгаагаас шалтгаалан бүсчлэлд суурилсан төлөвлөлт, шийдвэр гаргалтын тогтвортой байдал алдагдах, хөрөнгө оруулалт, ашиглалтын шийдвэрүүд бүсчлэлтэй нийцэхгүй байх, хамгаалалтын дэглэмийн бодит хэрэгжилт сулрах эрсдэл бий болжээ.

Иймээс бүсчлэл нь хамгаалалтын бодлогын үндсэн хэрэгсэл байх ёстой боловч практикт тогтвортой хэрэгжих, шийдвэр гаргалтад бодитоор ашиглагдах түвшинд хүрээгүй гэж дүгнэв.

(б) Хамгаалалтын дэглэмийн хэрэгжилтийн жигд бус байдал

Ангилал болон бүсчлэлээс хамааран үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, зөвшөөрөх ялгамжтай зохицуулалт хуулиар тогтоогдсон боловч аялал жуулчлал, дэд бүтэц, газар ашиглалт тодорхой бүсэд хэт төвлөрөх, хориглосон болон хязгаарласан үйл ажиллагаа бодитоор ялгарахгүй хэрэгжих, хамгаалалтын бүсүүдийн дэглэм сул мөрдөгдөх зэрэг асуудлууд нийтлэг байна.

Ялангуяа онгон болон хамгаалалтын бүсийн дэглэм бодит хяналт, хэрэгжилт сул байгаагаас хамгаалалтын ялгарал алдагдах хандлага ажиглагдаж байна.

(в) Шийдвэр гаргалтад бүсчлэлийн нөлөө

Бүсчлэл нь газар ашиглалт, зөвшөөрөл олголт, дэд бүтцийн төлөвлөлт, аялал жуулчлалын хөгжлийн шийдвэрүүдэд үндсэн шалгуур болох ёстой хэдий ч зөвшөөрөл олголт бүсчлэлд тулгуурлахгүй, тухайн бүсийн даац, экологийн онцлогийг харгалзан үзэхгүй шийдвэр гаргах, богино хугацааны эдийн засгийн ашиг сонирхол давамгайлах байдалтай байгаагаас хамгаалалт-ашиглалтын тэнцвэр алдагдах, экосистемийн доройтол үүсэх эрсдэл нэмэгдэж байна.

(г) Мэдээлэл, кадастрын уялдаа

Дотоод бүсчлэлийг бодитой хэрэгжүүлэхэд шаардлагатай кадастр, газарзүйн мэдээллийн системийн уялдаа хангалтгүйн улмаас бүсчлэлийн хил зааг тодорхой бус байх, мэдээлэл хоорондоо зөрүүтэй, шийдвэр гаргахад ашиглах боломж хязгаарлагдмал байгаа нь бүсчлэлийн хэрэгжилтийг сулруулж байна.

Шигтгээ. 8


“...хаана ямар бүс вэ гэдгээс илүү зөвшөөрөл олгох нь түрүүлдэг...”
“...аялал жуулчлалын бүс, хамгаалалтын бүсийн ялгаа бодит дээрээ тодорхой биш...”

Бүсийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс


Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 7–25 дугаар зүйлд заасан хамгаалалтын дэглэм, дотоод бүсчлэлийн зохицуулалт нь онолын хувьд хамгаалалт–ашиглалтын ялгамжтай менежментийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн боловч бүсчлэл шийдвэр гаргалтад бодит шалгуур болж ашиглагдахгүй, хамгаалалтын дэглэмийн хэрэгжилт жигд бус, зөвшөөрөл, газар ашиглалт бүсчлэлтэй уялдахгүй, мэдээлэл, кадастрын уялдаа хангалтгүй байгаа тул уг зохицуулалт практикт бүрэн нийцэж, үр нөлөөтэй хэрэгжихгүй байна.

Зураг. 7 Богдхан уулын дархан цаазат газрын дотоод бүсчлэл

Байгаль орчны сайдын
2008 оны 119 тоот
тушаалаар тогтоосон
дотоод бүс



Байгаль орчин, ногоон
хөгжлийн сайдын 2014
оны А/392 тоот 6200 га
талбайрг хягуаарлалтын
бүсээс хамгаалалтын
бүсэд нэмж хамгаалалтад
авсан



Байгаль орчин, аялал
жуулчлалын сайдын
2015 оны А/291 тоот
тушаалаар 221 га талбайг
хамгаалалтын бүсээс
хасч хязгаарлалтын бүс
болгон газар ашиглах
зөвшөөрөл олгосон



Эх сурвалж: Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, 2025 он

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30–32 дугаар зүйлд заасан хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хүний нөөц, чадавх, гүйцэтгэлийн стандарт хангалттай байгаа эсэх.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30–32 дугаар зүйлд хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа, байгаль хамгаалагчийн бүрэн эрх, тэдгээрийн хэрэгжүүлэх чиг

үүргийг тодорхойлсон. Эдгээр зохицуулалт нь хамгаалалтын бодлогыг газар дээр хэрэгжүүлэх үндсэн институцийн тогтолцоог бүрдүүлж байх бөгөөд уг зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэхэд хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчийн үйл ажиллагаа нь хүний нөөц, чадавх, гүйцэтгэлийн стандартын хувьд хангалтгүй, жигд бус хэрэгжиж байна.

(а) Хүний нөөцийн хүрэлцээ, ачаалал

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлээр хамгаалалтын захиргааны хамгаалалт хариуцсан ажилтан болон байгаль хамгаалагчийг байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэгтэй байхаар зохицуулж, тусгай хамгаалалттай газар нутагт хууль тогтоомжийн хэрэгжилтэд хянат тавих, зөрчлийг таслан зогсоох, шалгалт хийх, иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоох, эд зүйл хураах, албан үүргээ гүйцэтгэхдээ ээвсэг, хэрэгсэлтэй байх зэрэг өргөн хүрээний бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна. Энэхүү зохицуулалт нь хамгаалалтын горимыг газар дээр нь шуурхай хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаа боловч тухайн эрхийг бодитой хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой асуудлууд практикт тулгарч байна.

Хүний нөөцийн бүтэц, тоон үзүүлэлтээс харахад нийт орон тооны дийлэнхийг байгаль хамгаалагч эзэлж байгаа нь хамгаалалтын захиргаадын үйл ажиллагаа бодит талбайн хамгаалалт, хууль хяналтын чиглэлд төвлөрч байгааг илтгэх боловч нөгөө талаас нэг байгаль хамгаалагчид ногдох талбайн ачаалал бүс нутгийн онцлогоос шалтгаалан ихээхэн ялгаатай байна. Ялангуяа говийн бүсийн томоохон дархан цаазат газруудад хүн амын нягтаршил багатай, дэд бүтэц сул, талбай асар өргөн тул байгаль хамгаалагчийн тоо харьцангуй цөөн боловч хариуцаж буй газар нутгийн хэмжээ маш их байгаа нь эргүүл, хяналт тогтмол хийх боломжийг хязгаарлаж, хууль сахиулах үйл ажиллагааны бодит ачааллыг нэмэгдүүлж байна.

Шигтгээ 8.

“...нэг хамгаалагч маш их талбай хариуцдаг тул байнгын хяналт хийх боломжгүй...”
“...тоног төхөөрөмж, унаа, шатахуун дутмаг байдлаас болж хяналтын ажил тасалддаг...”

Бүсийн хэлэлцүүлгийн ярилцлагаас

Харин төвийн бүс болон аялал жуулчлал төвлөрсөн хамгаалалтын газруудад талбай харьцангуй бага, хүний нөлөөлөл өндөр байдаг тул нэг хамгаалагчид ногдох талбай багасч, хяналтын давтамж илүү нягт байна. Ийнхүү байгаль хамгаалагч нь зөвхөн хээрийн хамгаалалтын ажилтан бус, хууль хэрэгжилтийг хангах, байгаль орчны хяналтын чиг үүргийг давхар хэрэгжүүлэгч албан тушаалтан бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн бодит гүйцэтгэл, хамгаалалтын үр дүн нь тэдний тоо, ачаалал, ажиллах орчны нөхцөлөөс шууд хамааралтай байна.

Судалгааны үр дүн, бүсийн хэлэлцүүлгээс харахад хамгаалалтын захиргаадын хүний нөөц хүрэлцээгүй, нэг байгаль хамгаалагчид ногдох хариуцсан талбайн хэмжээ /Хүснэгт 7/ хэт өргөн газрыг хамаарч байх тул хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлэх боломж хязгаарлагдах,

зөрчлийг урьдчилан илрүүлэх бус, гарсны дараа арга хэмжээ авах хандлага давамгайлах, хамгаалалтын дэглэмийн хэрэгжилт жигд бус байна.

Хүснэгт. 8 Байгаль хамгаалагчид ногдох талбайн хэмжээ

№	Хамгаалалтын захиргааны нэр	Харьяалах ТХГН	Хамрах талбай (га)	Нэг хамгаалагчид ногдох талбай (га)
1	Хан Хэнтийн УТХГ	Хан хэнтий ДЦГ, Өндөрхаан уул БЦГ, Биндэръяа хан уул ДГ, Хангал нуур ДГ	1,762,660.37	46,385.80
2	Богдхан уулын ДЦГ	Богдхан уул ДЦГ	42,192.36	1,834.45
3	Горхи-Тэрэлж БЦГ	Горхи-Тэрэлж БЦГ, Нагалхаан уул БНГ	295,396.17	32,821.80
4	Тужийн нарсны БЦГ	Тужийн нарс БЦГ	70,804.72	14,160.94
5	Зэд-Хантайн ДЦГ	Зэд-Хантай-Бүтээлийн нуруу ДЦГ	604,265.56	46,482.73
6	Ноён уулын ДЦГ	Ноён уул ДЦГ	22,320.00	3,720.00
7	Говь гурван сайхан БЦГ	Говь гурван сайхан БЦГ	2,697,170.84	107,886.83
8	Говийн их ДЦГ “А”	Говийн их ДЦГ, Ээж хайрхан ДГ	6,469,024.67	281,262.81
9	Их Богд уулын БЦГ	Заг байдрагийн голын эхэн сав БЦГ, Их Богд уул БЦГ	379,164.35	25,277.62
10	Говийн бага ДЦГ	Говийн бага ДЦГ	1,830,429.42	96,338.39
11	Их газрын чулуу БЦГ	Их газрын чулуу БЦГ	175,906.14	43,976.54
12	Дорнодын Улсын тусгай хамгаалалттай газар	Дорнод Монгол ДЦГ, Монгол дагуур ДЦГ, Тосон хулстай БНГ, Угтам БНГ, Яхь нуур БНГ	1,453,808.61	121,150.72
13	Нөмрөгийн ДЦГ	Нөмрөг ДЦГ	320,979.46	35,664.38
14	Дарьганы БЦГ	Дарьганга БЦГ	64,547.60	6,454.76
15	Онон-Балжийн БЦГ	Онон-Балж БЦГ, Өндөрхаан уул БЦГ, Хар ямаат БНГ	484,757.49	44,068.86
16	Гутайн даваа БЦГ	Гутайн даваа БЦГ	102,640.69	20,528.14
17	Хангайн нурууны БЦГ	Ноён хангай БЦГ, Хангайн нуруу БЦГ	995,742.66	82,978.56

18	Отгонтэнгэрийн УТХГ	Отгонтэнгэр уул ДЦГ, Тарвагатайн нуруу БЦГ	638,128.55	39,883.03
19	Хөвсгөлийн УТХГ	Хөвсгөл БЦГ, Даяндээрхийн агуй ДГ	1,206,879.38	44,699.24
20	Улаан тайгын УТХГ	Улаан тайга ДЦГ, Хорьдол сарьдаг ДЦГ, Тэнгис- Шишгэдийн голын ай сав БЦГ	1,534,077.76	47,939.93
21	Тарвагатайн БЦГ	Тарвагатайн нуруу БЦГ	547,629.89	45,635.82
22	Орхоны хөндийн БЦГ	Орхоны хөндий БЦГ, Хүйсийн найман нуур ДГ	92,717.99	7,132.15
23	Хөгнө-Тарнын БЦГ	Хөгнө-Тарна БЦГ	84,143.06	12,020.44
24	Тэсийн гол-Булнайн нуруу БЦГ	Тэсийн гол-Булнайн нуруу БЦГ	369,630.89	73,926.18
25	Хар-Ус нуур УТХГ	Хар ус нуур БЦГ, Шарга манхан БНГ	1,249,286.04	73,487.41
26	Увс нуурын ай сав УТХГ	Увс нуурын ай сав ДЦГ	755,244.05	47,202.75
27	Ачит нуур-Дэвэлийн арал БЦГ	Дэвэлийн арал БНГ	211,552.83	30,221.83
28	Хан Хөхийн нуруу УТХГ	Хан Хөхийн нуруу, Хяргас нуурын БЦГ	221,598.00	14,773.20
29	Монгол Алтайн нуруу УТХГ	Алтай таван богд БЦГ, Сийлхэмийн нуруу БЦГ, Цамбагарав уул БЦГ	917,712.65	61,180.84
30	Хөх Сэрхийн нуруу УТХГ	Хөх Сэрхийн нуруу ДЦГ, Чигэртэйн голын ай сав БЦГ	242,938.39	34,705.48
31	Мөнххайрханы БЦГ	Мөнххайрхан БЦГ	506,094.61	29,770.27
32	Говийн их ДЦГ "Б"	Говийн их ДЦГ, Алаг хайрхан БНГ	6,469,024.67	308,048.79
33	Монгол элсний БЦГ	Хасагт хайрхан ДЦГ, Монгол Элс БЦГ	298,073.88	49,678.98
34	Мянган угалзатын БЦГ	Мянган Угалзатын нуруу БЦГ	303,774.59	30,377.46

Эх сурвалж: БОУАӨЯам

(6) Мэргэжлийн чадавх, техникийн боломж

Байгаль хамгаалагчид хуульд заасан өргөн хүрээний чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй боловч мэргэжлийн сургалт, давтан бэлтгэл хангалтгүй, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийн хангамж харилцан адилгүй, хяналт, мониторинг хийх арга зүйн нэгдсэн стандарт дутмаг байгаа нь хамгаалалтын ажлын чанарт нөлөөлж байна.

Ялангуяа биологийн олон янз байдлын мониторинг, экосистемийн өөрчлөлтийн үнэлгээ зэрэг нарийн мэргэжлийн чиглэлд чадавхийг сайжруулах шаардлагатай. Түүнчлэн, байгаль хамгаалагчийг улсын байцаагчийн эрхтэй гэж заасан хэдий ч хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх нэгдсэн процедур, байгууллага хоорондын уялдаа тодорхой бус байгаа нь эрх хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна. Зарим тохиолдолд цагдаа болон бусад хяналтын байгууллагатай хамтын ажиллагаа сул, илэрсэн зөрчил шийдвэрлэгдэхгүй удаашрах, баримтжуулалт хангалтгүйгээс хэрэг хэрэгсэхгүй болох нөхцөл үүсдэг.

Мөн байгаль хамгаалагчийн аюулгүй байдал, эрх зүйн хамгаалалт хангалтгүй байгаа нь бүрэн эрхийн бодит хэрэгжилтэд саад болж байна. Хуулиар зэвсэг, тусгай хэрэгсэл ашиглах боломжийг заасан боловч ашиглах журам, зөвшөөрөгдөх төрөл тодорхойгүй, шүүхийн практикт хамгаалагдах нөхцөл бүрдээгүй байгаа талаар хамгаалалтын захиргаад онцолсон.

Шигтээ 8.

“...хулгайн ан, зөрчилтэй тулгарах үед байгаль хамгаалагчийн эрх зүйн хамгаалалт сул, аюулгүй ажиллагааны зохицуулалтыг сайжруулах шаардлагатай.”

Бүсийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс...

(в) Гүйцэтгэлийн стандарт, үнэлгээний тогтолцоо

Хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчийн үйл ажиллагааг үнэлэх нэгдсэн, үр дүнд суурилсан шалгуур үзүүлэлт хангалтгүй буюу гүйцэтгэлийг хэмжих тодорхой индикатор дутмаг, ажлын үр дүнг бодитоор үнэлэх тогтолцоо сул, урамшуулал, хариуцлагын механизм тодорхой бус байгаа нь гүйцэтгэлийн чанарыг сайжруулах хөшүүргийг сулруулж байна.

Шигтээ 9.

“...ямар ажлыг сайн хийсэн гэж үзэх, гүйцэтгэлийг яаж үнэлэх нь тодорхой биш...”

Оролцогч талын ярилцлагаас

(г) Институцийн уялдаа, дэмжлэг

Хамгаалалтын захиргаа нь бусад байгууллагуудтай (орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, цагдаа гэх мэт) уялдан ажиллах сайшгүй шаардлагатай боловч чиг үүргийн зааг тодорхой бус, хамтын ажиллагаа тогтмолжоогүй, мэдээлэл солилцооны нэгдсэн систем бүрдээгүй байгаа нь хамгаалалтын ажлын үр нөлөөг бууруулж байна. Тухайлбал, газар ашиглалт, албадан чөлөөлөлт, ан агнуурын менежмент зэрэг асуудалд хамгаалалтын захиргаад бодит шийдвэр гаргах эрх дутмаг, орон нутгийн байгууллагын шийдвэрээс хамааралтай хэвээр байгаа нь хамгаалалтын горимыг мөрдүүлэхэд хүндрэл учруулж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 33–35 дугаар зүйлд заасан зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Шийдвэр гаргалтын шалгуур, ил тод байдал, дотоод бүсчлэлтэй уялдаа хангагдаж байгаа эсэх.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 33–35 дугаар зүйлд газар ашиглалтын харилцааг хүсэлт гаргах, сонгон шалгаруулах, шийдвэр гаргах, гэрээ байгуулах, ашиглалтын хугацаа, хэмжээ тогтоох зэрэг үе шаттайгаар зохицуулсан бөгөөд уг зохицуулалт нь газар ашиглалтын шийдвэрийг ил тод, нэгдсэн, хамгаалалтын зорилготой нийцүүлэн хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна.

(а) Газар ашиглуулах эрх зүйн үндэс, журам (33 дугаар зүйл)

Хуулийн 33.1-д дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрч, зөвшөөрлийн үндсэн дээр байгаль орчинд сөрөг нөлөөгүй хэлбэрээр ашиглуулах зохицуулалтыг тусгасан.

Байгаль орчны сайдын 1996 оны 36 дугаар тушаалаар баталсан “Улсын тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах журам” мөрдөгдөж байгаа нь судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн суурь болж байна.

Дээрх журам нь түүхэн үүргээ гүйцэтгэсэн, өнөөгийн зөвшөөрлийн тогтолцоо, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн зохицуулалттай бүрэн нийцэхгүй байгаа нь хэрэгжилтийн хүндрэл үүсгэж, судалгаа, шинжилгээний зөвшөөрөл, газар ашиглуулах гэрээ, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хоорондын уялдааг хангахгүй байгаагаас нэг ижил бүсэд давхар зөвшөөрөл олгогдох, хяналтын механизм сулрах нөхцөл бүрдэж байна.

(б) Газар ашиглах хэмжээ, хугацаа тогтоох (34 дүгээр зүйл)

Хуулиар газар ашиглах гэрээний хугацааг 5 жилээс доошгүй байхаар тогтоож, газрын хэмжээг төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон дээд хязгаарт багтаан орон нутаг тогтоохоор зохицуулсан нь хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах давуу талтай боловч газрын хэмжээг тогтоох эрх давхардсан, хамгаалалтын захиргаанд мэдэгдэлгүй шийдвэр гарах, нөөц даац, бүсчлэлийг харгалзахгүй хэмжээ тогтоох эрсдэл үүсгэсэн. Мөн урт хугацааны гэрээ нь байгаль орчны мониторинг сул нөхцөлд хэрэгжих үед нөлөөллийг үе шаттай үнэлэх боломжийг хязгаарлаж байна.

Түүнчлэн, 2025 оны байдлаар нийт 19 тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглалт бүртгэгдэж, 3051 иргэн, аж ахуйн нэгж нийт 6429 га талбайг ашиглаж байгаа нь хамгаалалтын бүс дэх ашиглалтын ачааллыг илэрхийлэх нэг үзүүлэлт болж байна. Эдгээрээс зарим хамгаалалттай газарт 100-аас дээш аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа нь менежмент, хяналт, даацын зохицуулалтыг илүү нарийвчлах шаардлагатайг харуулж байна.


Хүснэгт. 9 ТХГН-д газар ашиглалтын нөхцөл байдал

№	Үзүүлэлт	Тоо
1	Газар ашиглалттай ТХГН	19
2	Газар ашиглагч иргэн, ААН	3051
3	Ашигласан талбай	6429 га

Эх сурвалж: БОУАӨЯам, 2025 он

Эдгээр үзүүлэлт нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын дэглэмд ашиглалтын дарамт бодитоор үүсэж байгааг илтгэхийн зэрэгцээ зөвшөөрөл олголт, гэрээний хэрэгжилт, хяналт-шалгалтын үр нөлөө, мэдээллийн уялдаа холбоотой холбоотой асуудлыг системийн түвшинд авч үзэх шаардлагатайг харуулж байна.

График. 3 Тусгай хамгаалалттай газарт газар ашиглаж буй аж ахуйн нэгжийн тоо



Эх сурвалж: БОУАӨЯам, 2025 он

(в) Хүсэлт, сонгон шалгаруулалтын үйл явц (35 дугаар зүйл)

Хуулиар хүсэлтийг төв байгууллагад гаргаж, хамгаалалтын захиргааны саналд үндэслэн сонгон шалгаруулалтад оролцуулах зохицуулсан нь санал авах хугацаа (5 хоног) бодит нөхцөлд нийцэхгүй, газар дээр нь үнэлгээ хийх боломж хязгаарлагдах, байгууллага хоорондын уялдаа сул байгаа нь мэргэжлийн дүгнэлтийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

Түүнчлэн нөөц даацын судалгаа, экологийн үнэлгээг системтэй шаардахгүй байгаа нь сонгон шалгаруулалтын чанарыг бууруулж байна.

Шигтгээ 10.

“...хамгаалалтын байгууллагын санал бодит шийдвэрт нөлөөлөхгүй байх тохиолдол байдаг...”
 “...нэг ижил газарт давхар зөвшөөрөл олгогдох асуудал гардаг...”

Хамгаалалтын захиргааны санал, хэлэлцүүлгээс

Эдгээрээс дүгнэхэд, газар ашиглалтын зөвшөөрөл олголтын тогтолцоо нь эрх зүйн актын шинэчлэл хийгдээгүй, шийдвэр гаргалтын шалгуур тодорхойгүй, нөөц даац, дотоод бүсчлэлтэй уялдаа сул, байгууллага хоорондын уялдаа хангалтгүй, хяналт, хэрэгжилтийн механизм бүрэн ажиллахгүй байх тул байгаа тул ил тод, нэгдмэл, экосистемд суурилсан шийдвэр гаргалтыг хангах түвшинд хүрээгүй байна.

Иймээс Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 33–35 дугаар зүйлд заасан зохицуулалт нь бодит хэрэгжилтийн түвшинд хамгаалалтын зорилгыг бүрэн хангаж чадахгүй, ашиглалт–хамгаалалтын тэнцвэрийг алдагдуулах эрсдэлийг бий болгож байна гэж дүгнэж байна.

3.3. “Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал:

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36¹, 36², 37, 38 дугаар зүйлд заасан газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалт, гэрээ, газар ашиглагчийн эрх, үүргийн зохицуулалтын хэрэгжилт практикт хэрхэн хангагдаж байгаа, ямар эрх зүйн хийдэл, хүндрэл, давхардал үүсэж байна вэ?

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36¹, 36² дугаар зүйлээр 2023 оны нэмэлт, өөрчлөлтөөр газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалтын үйл явцыг ил тод, үе шаттай зохион байгуулах шинэ эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн. Үүнд сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй зарлах, төслийг хүлээн авах, хамгаалалтын захиргааны санал авах, үнэлгээ хийх, шалгарсан этгээдэд газар ашиглах эрх олгох дарааллыг тодорхойлсон нь өмнөх зохицуулалтаас илүү өрсөлдөөнт, ил тод механизм бий болгосон гэж үзэж байна.

Мөн 37 дугаар зүйлд газар ашиглах гэрээ байгуулах, 38 дугаар зүйлд газар ашиглагчийн эрх, үүргийг тодорхойлсноор газар ашиглалтыг гэрээ, хариуцлагын тогтолцоонд оруулах, хамгаалалтын нөхцөлийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Уг зохицуулалтын хэрэгжилт дараах системийн шинжтэй хүндрэл, үр дагаврыг бий болгож байна.

(а) Сонгон шалгаруулалтын тогтолцооны хийдэл (36¹, 36²)

Хуулиар сонгон шалгаруулалтын үе шат тодорхой болсон боловч түүнийг хэрэгжүүлэх дэд журам, үнэлгээний аргачлал бүрэн боловсроогүй байна. Тухайлбал:

- “Төрийн захиргааны төв байгууллагын санаачилгаар сонгон шалгаруулалт явуулах” зохицуулалтын хэрэгжилтийн журам батлагдаагүй,
- үнэлгээний нэгдсэн аргачлал, онооны систем, дүгнэлтийн загвар байхгүй,
- төслийг хүлээн авах журам нь зөвхөн бүртгэлийн шатанд хязгаарлагдсан байгаа нь сонгон шалгаруулалтын чанар, нэгдмэл байдлыг алдагдуулж байна.

Мөн цахим системийн нэгдсэн шийдэл бүрэн хөгжөөгүй, хамгаалалтын захиргааны чадавх харилцан адилгүй байгаа нь баримтжуулалт, ил тод байдлыг сулруулж, хэрэгжилтийн зөрүүг нэмэгдүүлж, үр дагавар нь сонгон шалгаруулалт хэлбэрийн төдий болж, бодит өрсөлдөөн, нэгдмэл үнэлгээ хангагдахгүй, шийдвэрийн чанар ялгаатай болох нөхцөл бүрдэж байна.

(б) Гэрээний зохицуулалтын хийдэл (37 дугаар зүйл)

Хуулиар газар ашиглах гэрээг төрийн захиргааны төв байгууллага болон хамгаалалтын захиргаа хамтран байгуулахаар заасан боловч нэгдсэн гэрээний маягт, стандарт журам шинэчлэгдээгүй, гэрээний агуулга байгууллага бүрт харилцан адилгүй, хамгаалалтын нөхцөл, нөхөн сэргээлтийн үүрэг жигд бус тусгагдах асуудлууд үүсжээ.

Түүнчлэн, хамгаалалтын захиргааны мэргэжлийн санал гэрээний нөхцөлд бүрэн тусгагдахгүй байгаа нь хамгаалалтын дэглэмийг гэрээгээр дамжуулан хэрэгжүүлэх боломжийг сулруулж, гэрээ нь хамгаалалтын хэрэгсэл биш, байх ёстой баримт бичиг болж хувирч, хяналт, хариуцлагын механизм сулрах нөхцөл бүрдэж байна.

(в) Газар ашиглагчийн үүргийн хэрэгжилтийн сул тал (38 дугаар зүйл)

Хуулиар газар ашиглагчид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, газрын төлөв байдалд өөрчлөлт оруулахад зөвшөөрөл авах, эрх дуусахад газрыг нөхөн сэргээж хүлээлгэн өгөх үүргийг тодорхой хүлээлгэсэн боловч бодитод байдал дээр үүргийн биелэлтийг үнэлэх шалгуур, стандарт тодорхой бус, мониторингийн тогтолцоо сул, нөхөн сэргээлтийн үнэлгээ, хүлээлгэн өгөх журам дутмаг, хамгаалалтын захиргааны оролцоо хангалтгүй байна.

Иймд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36¹, 36², 37, 38 дугаар зүйлд заасан зохицуулалт нь эрх зүйн шинэчлэл хийсэн, ил тод, үе шаттай тогтолцоог бий болгосон хэдий ч хэрэгжилтийн түвшинд зарим зохицуулалт, аргачлал дутмаг, гэрээ, хяналтын стандарт байхгүй, үүргийн хэрэгжилтийг үнэлэх механизм бүрэн ажиллахгүй байгаа тул бодит үр нөлөөтэй хэрэгжихгүй, системийн зөрчил, давхардал, эрх зүйн хийдлийг бий болгож байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 39 дүгээр зүйл. Газар ашиглагчид хориглох үйл ажиллагаа, газар ашиглагчид хориглох үйл ажиллагааны зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, хэрэгжилтийн явцад ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлээр газар ашиглагчид ашиглаж байгаа газраа бүхэлд нь буюу хэсэгчлэн бусдад дамжуулан ашиглуулах, хамгаалалтын дэглэм, гэрээнд зааснаас өөр буюу байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулахыг хориглосон нь хамгаалалтын бүсэд газар ашиглалтыг зориулалтын дагуу байлгах, дам ашиглалт, зохисгүй бизнесийн үйл ажиллагааг хязгаарлах эрх зүйн суурь зохицуулалт болж байна. Мөн газрыг хуульд заасан үндэслэлээр эргүүлэн авсан тохиолдолд дахин газар олгохгүй

байж болох зохицуулалт нь хариуцлагын механизмын нэг хэлбэр болж байна. Бодит байдал дээр дараах хүндрэлүүд ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, газрыг бусдад дамжуулан ашиглуулахыг хориглосон боловч аялал жуулчлал, үйлчилгээний гэрээт хэлбэрийн үйл ажиллагаа болон туслан гүйцэтгэгчийн ажил хоорондын зааг тодорхой бус байгаа нь “дам ашиглалт”-ыг ялган тодорхойлоход хүндрэл үүсгэдэг. Үүний улмаас зарим тохиолдолд гэрээний нэрээр гуравдагч этгээд ашиглалт явуулах эрсдэл гарч байна.

Хоёрдугаарт, байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагааг хориглосон боловч “сөрөг нөлөө”-г тодорхойлох шалгуур, мониторингийн аргачлал нэгдсэн байдлаар хэрэгжихгүй байгаа нь зөрчлийг тогтоох, хариуцлага тооцох ажиллагаанд хүндрэл учруулж байна. Хамгаалалтын захиргаадын саналд аялал жуулчлал, дэд бүтцийн ашиглалт нэмэгдэхийн хэрээр нөөц даацын судалгаанд тулгуурласан хяналт шаардлагатай байгааг онцолсон.

Гуравдугаарт, газар эргүүлэн авах шийдвэр гарсны дараа дахин газар олгохгүй байж болох зохицуулалт байгаа боловч ямар шалгуураар “дахин олгохгүй” байхыг тодорхойлох аргачлал, мэдээллийн нэгдсэн сан дутмаг байгаа нь хэрэгжилтийн жигд бус байдал үүсгэж байна.

Иймд хуулийн 39 дүгээр зүйлд газар ашиглагчид хориглох үйл ажиллагааг тодорхой заасан боловч хэрэгжилтийн түвшинд дам ашиглалтын ойлголтыг нарийвчлах, байгаль орчны нөлөөллийг үнэлэх шалгуур, хяналтын аргачлалыг тодорхой болгох, зөрчил гаргасан ашиглагчийн мэдээллийг нэгдсэн байдлаар бүртгэх тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 40 дүгээр зүйл. Газар ашиглах зөвшөөрлийн эрх дуусгавар болох, хүчингүй болох, газрыг чөлөөлөх, газар ашиглах зөвшөөрлийн эрх дуусгавар болох, хүчингүй болох, газрыг чөлөөлөх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, хэрэгжилтийн явцад ямар хүндрэл, бэрхшээл гарч байна вэ?

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлээр газар ашиглах эрх дуусгавар болох, хүчингүй болох үндэслэл, газрыг чөлөөлөх хугацаа, албадан чөлөөлөх ажиллагааг тодорхой зохицуулсан. Тухайлбал, хамгаалалтын горимыг удаа дараа буюу ноцтой зөрчих, Газрын тухай хуульд заасан үндэслэл үүсэх, тэмдэгтийн хураамж төлөөгүй зэрэг нөхцөлд газар ашиглах эрх хүчингүй болохоор заасан нь хамгаалалтын бүсийн дэглэмийг сахиулах хариуцлагын механизм болж байна. Мөн эрх дуусгавар болсны дараа 90 хоногийн дотор газрыг чөлөөлөх, шаардлагатай бол хамгаалалтын захиргаа албадан чөлөөлөх шийдвэр гаргах зохицуулалт нь хэрэгжилтийг хангах эрх зүйн үндэс болж байна. Бодит байдал дээр дараах хүндрэлүүд ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, “удаа дараа буюу ноцтой зөрчил” гэсэн ойлголтыг тодорхойлох нэгдсэн шалгуур, үнэлгээний аргачлал дутмаг байгаа нь газар ашиглах эрхийг дуусгавар болгох шийдвэр гаргахдаа байгууллага бүр өөр өөрөөр тайлбарлах нөхцөл үүсгэдэг.

Хоёрдугаарт, газрыг 90 хоногийн дотор чөлөөлөх зохицуулалт байгаа боловч бодит нөхцөлд дэд бүтэц, барилга байгууламжтай холбоотой асуудлаас шалтгаалан хугацаандаа чөлөөлөх боломжгүй тохиолдол гарч, албадан чөлөөлөх ажиллагаа удаашрах хандлагатай байна.

Гуравдугаарт, албадан чөлөөлөх шийдвэрийг хамгаалалтын захиргаа гаргах эрхтэй боловч хэрэгжүүлэхэд цагдаа болон бусад байгууллагатай уялдаа сул, санхүүжилтийн эх үүсвэр тодорхой бус байдаг нь шийдвэрийн биелэлтийг удаашруулах хүчин зүйл болж байна. Мөн газар ашиглах эрх хүчингүй болсон этгээдийн мэдээллийг нэгдсэн байдлаар бүртгэх, дахин газар олгохгүй байх зохицуулалтыг хэрэгжүүлэх мэдээллийн тогтолцоо хангалтгүй байна. Иймд 40 дүгээр зүйлд газар ашиглах эрх дуусгавар болгох, газрыг чөлөөлөх эрх зүйн үндэс тодорхой боловч хэрэгжилтийн түвшинд зөрчлийн шалгуур тодорхой бус, албадан чөлөөлөх ажиллагааны механизм, байгууллага хоорондын уялдаа, мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулалт дутмаг байгаа нь практикт гарч буй гол хүндрэл, бэрхшээл болж байна. Цаашид зөрчлийн үнэлгээний шалгуурыг тодорхой болгох, албадан чөлөөлөх ажиллагааны журмыг нарийвчлах, эрх дуусгавар болсон ашиглагчийн мэдээллийг нэгдсэн байдлаар бүртгэх шаардлагатай.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 43 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 43 дугаар зүйлд хууль зөрчигчид Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр ерөнхий байдлаар зохицуулсан нь хэрэгжилтийн түвшинд тодорхойгүй байдал үүсэх нөхцөл ажиглагдаж байна.

Тухайлбал, Байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан болон Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан дахь холбогдох мэдээллийг үзэхэд 2017–2025 оны хугацаанд илэрсэн зөрчил, гэмт хэргийн дийлэнх хувийг ойн сан болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүй мод бэлтгэхтэй холбоотой үйлдлүүд эзэлж байна. Байгаль орчны гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан дахь хэрэг зөрчлүүдийн ихэнх нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлгийн хүрээнд зүйлчлэгдсэн байна. Газарзүйн байршлаар нь авч үзэхэд Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө, Алтанбулаг сум, Хөвсгөл, Өвөрхангай, Булган, Завхан аймаг, мөн Улаанбаатар хотын Налайх дүүрэг, Богдхан уул орчимд гэмт хэрэг, зөрчил харьцангуй их, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойд зөвшөөрөлгүй мод бэлтгэх, гарал үүслийн гэрчилгээгүй мод, модон материал тээвэрлэх, хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, байгаль орчинд хохирол учруулах, хориотой хугацаанд ан агнах, ургамал түүх, ой болон газрын хэвлийг гэмтээх, түймэр гаргах зэрэг үйлдлүүд өндөр хувийг эзэлж байна.

Иймд хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны хяналт шалгалтын давтамжийг нэмэгдүүлэх, мод бэлтгэлтэй холбоотой зөвшөөрлийн мэдээллийг цахимжуулж гарал үүслийн бүртгэлийг ил тод болгох, ойн сан бүхий бүсэд эргүүл, хяналтын техник хэрэгслийг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд урьдчилан сэргийлэх бодлогын түвшинд орон нутгийн иргэдэд зориулсан байгаль хамгааллын

сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах, байгаль орчны гэмт хэрэг илрүүлэх олон нийтийн оролцоог дэмжих, тусгай хамгаалалттай бүсийн орчимд альтернатив амьжиргааны эх үүсвэрийг хөгжүүлэх нь зүйтэй байна.

Түүнчлэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд Эрүүгийн хууль болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн уялдаа холбоог сайжруулах, байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээний аргачлалыг нэг мөр болгох, давтан үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг шатлалтайгаар нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд байгаль орчны гэмт хэрэг, зөрчил нь илрүүлэлтийн шатнаас шүүхийн шат хүртэл үргэлжилж байгаа боловч ихэнх нь ижил төрлийн буюу мод бэлтгэлтэй холбоотой байгаагийн зэрэгцээ хамгаалалтын бүсийн менежмент, хяналтын тогтолцоо хангалтгүй байгаа тул эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн хяналт болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг харилцан уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Тодруулбал, шууд хариуцлагын төрөл, хэмжээ, хэрэглэх шалгуур, тусгай хамгаалалттай газар нутгийн онцлогт нийцсэн ялгамжтай зохицуулалтыг тодорхойлоогүй бөгөөд бусад хуулиудад ерөнхий байдлаар шилжүүлсэн зохицуулалттай байгаа нь практикт зөрчил ангилах, хариуцлага ногдуулахдаа байгууллагуудын тайлбар харилцан адилгүй байх шалтгаан болдог. Ялангуяа хамгаалалтын горим зөрчих, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулах, газар ашиглалтын гэрээний нөхцөл зөрчих зэрэг тусгай хамгаалалттай газар нутгийн онцлог зөрчлүүдийг ямар шалгуураар эрүүгийн шинжтэй эсэхийг тогтоох нэгдсэн аргачлал дутмаг байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан эдийн засгийн хөшүүргийг ТХГН-т хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгах шаардлагатай. Ингэснээр байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд ахиц гарах, нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нөхцөл бүрдэх бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд тодорхой зохицуулалт тусгагдаагүй.

Мөн байгаль хамгаалагч, хамгаалалтын захиргаа, улсын байцаагчийн эрх хэмжээний уялдаа тодорхой бус байгаа нь зөрчлийг илрүүлэхээс эхлээд шийдвэрлэх хүртэлх шат дамжлагад хугацаа алдах, хариуцлага хэрэгжихгүй үлдэх эрсдэлийг бий болгож байна. Иймд 43 дугаар зүйлийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн зөрчлийн ангилал, нотлох баримтын шаардлага, хариуцлага тооцох үйл ажиллагааны уялдаа холбоог нарийвчлан тодорхойлсон эрх зүйн болон арга зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн уялдаа, нийцэл нь ямар үр дагавар үүсгэж байна вэ? Эрх зүйн давхардал, зөрчил, хийдэл нь шийдвэр гаргалт болон хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байна вэ?

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль нь байгаль орчны салбарын суурь хуулиуд болох Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Төсвийн тухай хууль зэрэг

олон хуультай нягт уялдаатайгаар хэрэгжих шаардлагатай. Иймд эдгээр хуулиудын уялдаа, нийцэл нь тус хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлох чухал хүчин зүйл болдог.

Гэвч судалгааны үр дүнгээс харахад хууль хоорондын уялдаа хангалтгүй, нэр томьёо, зохицуулалтын түвшин, харилцааны зааг тодорхой бус байдал ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, газар ашиглалт, зөвшөөрөл, байгаль орчны үнэлгээтэй холбоотой зохицуулалтуудын хоорондын уялдаа сул байгаагаас нэг ижил үйл ажиллагаанд давхар зөвшөөрөл олгох, эсхүл шаардлагатай зөвшөөрөл дутуу олгогдох нөхцөл үүсч байна. Энэ нь шийдвэр гаргалтын ил тод байдал, нэгдмэл байдлыг алдагдуулж, хууль хэрэглээний зөрүүг бий болгодог.

Хоёрдугаарт, хариуцлагын тогтолцооны хувьд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон салбарын хуулиудын хооронд уялдаа хангалтгүйгээс ижил төрлийн зөрчилд өөр өөр хариуцлага оногдуулах, эсхүл хариуцлага сулрах, хэрэгжилт хангалтгүй байх нөхцөл бүрдэжээ.

Гуравдугаарт, зарим харилцааг ямар хуульд зохицуулах нь тодорхойгүй, хууль-журам хоорондын зааг алдагдсан байдал ажиглагдаж байна. Үүний улмаас хуульд тусгагдах ёстой асуудлыг журмаар зохицуулах, эсхүл эсрэгээр журамд байх асуудлыг хуульд ерөнхий байдлаар үлдээх зэргээр эрх зүйн зохицуулалтын шатлал алдагдаж, хэрэгжилтэд тодорхойгүй байдал үүсгэж байна.

Дөрөвдүгээрт, санхүүжилт, төлбөр, эдийн засгийн зохицуулалттай холбоотой харилцаанд Төсвийн тухай хууль болон бусад холбогдох зохицуулалттай уялдаа сул байгаа нь тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэхэд саад болж байна.

Тавдугаарт, мэдээлэл, бүртгэл, судалгааны үр дүнг ашиглахтай холбоотой зохицуулалт нь салбар хоорондын мэдээллийн солилцоог хангах түвшинд хүрээгүй, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хоорондын уялдаа, нийцэл хангалтгүй байгаа нь эрх зүйн зохицуулалтын давхардал, зөрчил, хийдлийг бий болгож, шийдвэр гаргалтын нэгдмэл байдал алдагдах, хэрэгжилтийн үр нөлөө буурах үндсэн шалтгаан болж байна.

Иймэд хуулиудын уялдаа холбоог системтэйгээр хангаж, зохицуулалтын заагийг тодорхой болгох, нэр томьёо, хариуцлага, зөвшөөрлийн тогтолцоог нэг мөр болгох шаардлагатай гэж дүгнэж байна.

3.4. Гадаад улс орнуудын тусгай хамгаалалттай газар нутгийн зохицуулалтын харьцуулсан шинжилгээ

Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг бодитой үнэлэхийн тулд уг харилцааг олон улсын түвшинд хэрхэн зохицуулж ирсэн туршлагыг харьцуулан судлах нь зайлшгүй ач холбогдолтой. Ялангуяа хамгаалалтын зорилго, ашиглалтын зохицуулалт, институцийн бүтэц, санхүүжилтийн тогтолцоог системийн түвшинд уялдуулж чадсан улс орнуудын туршлага нь Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын сул болон давуу талыг тодорхойлоход чухал суурь болдог. Энэ хүрээнд байгаль хамгаалалтын бодлого, эрх зүйн тогтолцооны хувьд тогтсон практиктай Герман, Австрали, Япон улсын зохицуулалтыг сонгон авч, ангилал, менежмент, санхүүжилт, хяналтын тогтолцооны үндсэн элементүүдээр харьцуулан шинжилсэн болно.

(а) Ангилалд суурилсан хамгаалалтын зохицуулалтын логик

Герман, Австрали, Япон улсын нийтлэг онцлог нь тусгай хамгаалалттай газар нутгийг зөвхөн нэршлээр бус, экологийн үнэ цэнэ, хамгаалалтын зорилго, хүний оролцооны түвшинд үндэслэн ялгамжтай ангилдагт оршино.

Герман улсад “Nature Reserve”, “National Park”, “Protected Landscape” зэрэг ангилал бүр нь хамгаалалтын түвшин, хүний үйл ажиллагааны хязгаарлалт, зөвшөөрөгдөх ашиглалтаар тодорхой ялгаатай бөгөөд эдгээрийг Холбооны байгаль хамгаалалтын тухай хуулиар нарийвчлан зохицуулсан байдаг. Ялангуяа Nature Reserve ангилалд хүний үйл ажиллагааг бараг бүрэн хориглодог бол Protected Landscape ангилалд уламжлалт ашиглалтыг тодорхой нөхцөлтэйгээр зөвшөөрдөг.

Австрали улсад ангиллын ялгаа нь экосистемийн хамгаалалт ба нийтийн хэрэглээний тэнцвэрийг хангах үндсэн хэрэгсэл болдог. National Park нь хамгаалалт давамгайлсан боловч зохион байгуулалттай аялал жуулчлал зөвшөөрөгддөг бол Conservation Park ангилалд илүү уян хатан ашиглалтын хэлбэрүүдийг зөвшөөрдөг.

Япон улсын хувьд ангиллын тогтолцоо нь зөвхөн байгалийн бус, соёл-экологийн хосолмол үнэт зүйлсийг хамгаалах чиглэлд хөгжсөн бөгөөд National Park, Quasi-National Park, Natural Monument зэрэг ангилал бүрд ашиглалтын болон хамгаалалтын дэглэмийг ялгавартай тогтоосон байдаг. Эдгээр туршлагаас харахад ангилал нь зөвхөн нэршил бус, эрх зүйн дэглэмийг ялгах үндсэн хэрэгсэл болж ажилладаг бөгөөд ангилал бүр хамгаалалтын зорилго, зөвшөөрөгдөх үйл ажиллагаа, хориглох үйл ажиллагаа, менежментийн арга барил тодорхой ялгаатай тогтоогддог байна. Харин Монгол Улсад ангиллыг хуульчилсан боловч ангилал тус бүрийн дэглэмийн ялгаа бодит хэрэгжилтийн түвшинд бүдгэрч, “нэг загварын зохицуулалт” давамгайлах хандлага ажиглагдаж байна.

(б) Менежментийн төлөвлөлтийн институцийн үүрэг

Гадаад улс орнуудын туршлагаас харахад тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент нь хуульд заасан ерөнхий зохицуулалтаар бус, менежментийн төлөвлөгөөгөөр бодитоор хэрэгждэг байна.

Герман, Австрали, Япон улсад менежментийн төлөвлөгөө нь эрх зүйн хувьд заавал байх, тодорхой хугацаанд шинэчлэгдэх, хэрэгжилтийг нь үнэлдэг бодлогын үндсэн баримт бичиг байдаг. Эдгээр төлөвлөгөөнд хамгаалалтын зорилгоос гадна газар ашиглалтын нарийвчилсан зохицуулалт, судалгаа, мониторингийн төлөвлөгөө, санхүүжилтийн бүтэц, оролцогч талуудын үүрэг зэрэг нь нэгтгэгдсэн байдлаар тусгагддаг.

Мөн институцийн хувьд шийдвэр гаргах түвшин (үндэсний/орон нутгийн), хэрэгжилт хариуцах байгууллага, хяналт тавих субъект тодорхой ялгаатай, давхардалгүй зохицуулагдсан байдаг. Харин Монгол Улсад менежментийн төлөвлөгөөний эрх зүйн статус, хэрэгжилтийн хяналт, үнэлгээний механизм жигд бус байгаа нь хамгаалалтын бодлогыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

(в) Санхүүжилтийн олон эх үүсвэр ба урамшууллын тогтолцоо

Гадаад улс орнуудын нийтлэг онцлог нь тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийг зөвхөн улсын төсвөөс хамааралтай байлгахгүйгээр олон эх үүсвэрт суурилсан тогтолцоог бүрдүүлсэн явдал юм.

Тухайлбал:

- Герман улсад экосистемийн үйлчилгээний төлбөр, нөхөн олговор, орон нутгийн санхүүжилт,
- Австрали улсад аялал жуулчлалын орлого, лиценз, тусгай сан,
- Япон улсад төв болон орон нутгийн хамтарсан санхүүжилт зэрэг нь хамгаалалтын санхүүжилтийн чухал эх үүсвэр болдог.

Эдгээр орнуудын хувьд онцлог нь орлого нь хамгаалалттай шууд холбогддог бол санхүүжилт нь гүйцэтгэлтэй уялддаг байна. Харин Монгол Улсад тусгай хамгаалалттай газар нутгийн орлого нь улсын нэгдсэн төсөвт төвлөрдөг тул хамгаалалтын үйл ажиллагаанд шууд зарцуулагдах санхүүгийн уян хатан механизм хязгаарлагдмал байна.

(г) Мониторинг, тайлагнал ба шийдвэр гаргалт

Герман, Австрали, Япон улсад хамгаалалтын үр нөлөөг тогтмол мониторинг, шинжлэх ухаанд суурилсан үнэлгээ, ил тод тайлагналтай уялдуулан хэмждэг.

Дээрх байдал нь бодлогын шийдвэрийг өгөгдөлд суурилсан болгодог менежментийн алдааг цаг тухайд нь засах боломж бүрдүүлдэг давуу талтай. Монгол Улсад мониторингийн тогтолцоо (жишээлбэл SMART) нэвтэрч эхэлсэн боловч нэгдсэн мэдээллийн сан, тайлагналын стандарт, шийдвэр гаргалттай уялдах механизм бүрэн төлөвшөөгүй хэвээр байна.

Үзүүлэлт	Герман	Австрали	Монгол (одоогийн)	Шинжилгээ
Ангилал	Nature Reserve	Conservation Park	Байгалийн нөөц газар	Монгол ангилал ойролцоо боловч зорилго, дэглэмийн ялгаа тодорхой биш
Менежментийн төлөвлөгөө	Заавал	Заавал	Заавал бус	Монголд хэрэгжилтийн гол сул тал – төлөвлөлт системгүй
Хариуцах байгууллага	Тодорхой (холбооны/муж)	Тодорхой (муж)	Тодорхой бус	Институцийн тодорхойгүй байдал → хэрэгжилт сул
Санхүүжилт	Олон эх үүсвэр	Олон эх үүсвэр	Голчлон төсөв	Санхүүгийн тогтолцоо сул, тогтвортой биш
Тайлагнал	Жил тутам	Тогтмол	Жигд бус	Өгөгдөлд суурилсан удирдлага байхгүй

Эх сурвалж: “IUCN-ийн хамгаалалттай газар нутгийн удирдлагын олон улсын ангилал, удирдлагын зарчимд тулгуурлан харьцуулсан болно

(д) Монгол Улсын зохицуулалттай харьцуулсан нэгдсэн дүгнэлт

Гадаад улс орнуудын туршлагатай харьцуулахад Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн зохицуулалт нь ангиллын суурь бүтэцтэй боловч түүнийг хэрэгжүүлэх менежментийн, институцийн болон санхүүгийн механизмын түвшинд сул байгааг харуулж байна.

Ялангуяа ангилалд суурилсан ялгамжтай дэглэм бүрэн төлөвшөөгүй, менежментийн төлөвлөгөө бодит хэрэгжилтийн хэрэгсэл болж чадахгүй, санхүүжилт орлоготой шууд уялдаагүй, мониторинг, тайлагнал бодлоготой холбогдохгүй байгаа нь хамгаалалтын бодлогын үр нөлөөг хязгаарлаж байна.

Иймд цаашид ангилал–менежмент–санхүүжилт–хяналтын уялдааг системийн түвшинд шинэчлэх хамгаалалтыг “зохицуулалт”-аас “удирдлагын тогтолцоо” руу шилжүүлэх шаардлага тулгамдаж байгаа бөгөөд харьцуулсан шинжилгээнээс үзэхэд Монгол Улсад тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн суурь бүрдсэн боловч менежментийн төлөвлөлт, институцийн хариуцлага, санхүүжилт, мэдээллийн тогтолцооны уялдаа хангалтгүй байгаа нь хамгаалалтын бодит үр нөлөөг хязгаарлаж байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн тулгамдсан асуудал нь дан ганц зохицуулалтын агуулга бус, харин зохицуулалтын түвшин, институцийн уялдаа, хэрэгжилтийн механизм, мэдээллийн тогтолцооны системийн доголдлоос шалтгаалж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1.ДҮГНЭЛТ

Судалгааны хүрээнд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг “зорилгод хүрсэн түвшин”, “практикт нийцэж байгаа байдал”, “бусад үр дагавар” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлж, дараах нэгдсэн дүгнэлтэд хүрэв.

1. Зорилгод хүрсэн түвшин

Хуулийн зорилт нь байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалах суурь эрх зүйн орчныг бүрдүүлж, тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг тэлэхэд тодорхой ахиц гаргав. Гэсэн хэдий ч зорилтын агуулга нь экосистемд суурилсан менежмент, нөөцийн даац, уур амьсгалын өөрчлөлт, экосистемийн үйлчилгээ зэрэг орчин үеийн бодлогын чиг хандлагыг бүрэн тусгаагүй хэвээр үлдэж, хэрэгжилтийг хэмжих тодорхой шалгуур, индикатороор дутуу байна.

Захиргааны хэм хэмжээний актын зохицуулалтын хэрэгжилт жигд бус: зарим журам батлагдаагүй, зарим нь хүчингүй болсон, нөгөө хэсэг нь хуульд нийцэхгүй хэлбэрээр мөрдөгдөж буй нь зохицуулалтын тогтолцоог сулруулж, тодорхой харилцаанд эрх зүйн хийдэл үүсгэжээ.

Төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрхийн хуваарилалт тодорхой бус, зарим тохиолдолд давхардсан шинжтэй тул шийдвэр гаргалтын нэгдмэл байдал алдагдаж, хамгаалалтын зорилгоос зөрөх нөхцөл бүрдсэн.

Мэдээллийн сангийн шинэчлэл, ашиглалт хангалтгүй байгаагаас мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, бодлого боловсруулах ба хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай өгөгдлийн чанар, хүртээмж дутмаг байна.

Иймд хуулийн зорилт нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх түвшинд тодорхой үр дүн өгсөн боловч чанарын удирдлага, засаглал, мэдээллийн тогтолцооны хувьд зорилгодоо бүрэн хүрээгүй гэж дүгнэлээ.

2. Практикт нийцэж байгаа байдал

Хуулийн зохицуулалтын бодит хэрэгжилтэд хэлбэрийн төдий шинж давамгайлж, төлөвлөсөн механизм бодит шийдвэр гаргалттай бүрэн уялдахгүй хэв шинж тогтжээ.

Менежментийн төлөвлөлт өргөн хүрээнд боловсруулагддаг ч санхүүжилт, зөвшөөрөл, хяналтын шийдвэртэй сул холбогддог тул “цаасан” дээр үлдэх хандлага түгээмэл байх тул хамгаалалтын зорилго бодит үйл ажиллагаанд бүрэн тусахгүй байна.

Хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчийн чадавх (хүний нөөц, техник, төсөв) хязгаарлагдмал хэвээр, хяналт урьдчилан сэргийлэхээс илүү зөрчлийн дараах арга хэмжээнд төвлөрөх хандлагатай.

Газар ашиглалт, зөвшөөрөл, сонгон шалгаруулалт, гэрээний хэрэгжилтэд нэгдсэн шалгуур, ил тод байдал дутмаг, байгууллага хоорондын уялдаа хангалттай хэмжээнд хөгжөөгүй байдлаас шалтгаалан ижил нөхцөлд ялгаатай шийдвэр гаргах, давхар зөвшөөрөл үүсэх, хамгаалалтын дэглэм алдагдах эрсдэл нэмэгдэж байна.

Дотоод бүсчлэлийн зохицуулалт бодит шийдвэр гаргалтад хангалттай нөлөөлөхгүй, нөөцийн даац, экологийн үнэлгээнд үндэслэхгүй байгаагаас ашиглалт-хамгаалалтын тэнцвэр алдагдах нөхцөл бүрдэж байна.

Дүгнэвэл, хуулийн зохицуулалт практикт бүрэн нийцэхгүй, хэрэгжилтийн үр нөлөө хязгаарлагдмал байна.

3. Бусад үр дагавар

Хуулийн хэрэгжилтийн явцад системийн шинжтэй дараах үр дагавар илэрч байна.

Хууль хоорондын уялдаа хангалтгүй байгаагаас хариуцлагын тогтолцоо жигд бус хэрэгжиж, ижил үйлдэлд өөр өөр эрх зүйн зохицуулалт үйлчлэх, эсхүл хариуцлага сулрах нөхцөл үүсчээ.

Зөвшөөрөл, сонгон шалгаруулалт, гэрээ, хяналтын хоорондын уялдаа хангалтгүй, холбогдох журам, стандарт дутмаг байдал нь эрх зүйн хийдэл, давхардлыг бий болгож, хэрэгжилтийн нэгдмэл байдлыг алдагдуулж байна.

Хүний нөөц, дэд бүтэц, санхүүжилтийн тогтолцоо хангалтгүй байгаа нь хамгаалалтын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хязгаарлаж, урт хугацааны үр нөлөөг сулруулж байна.

Ашиглалт-хамгаалалтын зохистой харьцааг хангах олон улсын сайн жишиг зөв тогтоогүй байдлаас үүдэн экосистемийн доройтол, нөөцийн хэт ашиглалтын эрсдэл өсөх хандлагатай буурах төлөвгүй байна..

Судалгаа, шинжилгээний үр дүн бодлого, шийдвэр гаргалтад хангалттай нэвтэрч чадахгүй, мэдээллийн нэгдсэн тогтолцоо сул хэвээр байна.

Иймд, хуулийн хэрэгжилтийн асуудал нь зөвхөн зохицуулалтын агуулгаас бус, харин институцийн уялдаа, хэрэгжилтийн механизм, санхүүжилт, мэдээллийн системийн доголдлоос үүдэлтэй системийн шинжтэй гэж нэгтгэн дүгнэлээ.

4.2.ЗӨВЛӨМЖ

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээний дүнд илэрсэн эрх зүйн зөрчил, институцийн сул тал, санхүүжилтийн үр ашиггүй бүтэц, мэдээллийн системийн доголдол зэргийг арилгах зорилгоор дараах бодлогын зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Хуулийн зорилго, зарчим, нэр томьёо болон хууль зүйн техникийн шаардлагыг системчлэн шинэчилж, зохицуулалтын тодорхой байдлыг хангах

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль нь байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалах үндсэн эрх зүйг орчинг бүрдүүлсэн боловч орчин үеийн байгаль хамгааллын бодлогын шаардлага болох экосистемд суурилсан менежмент, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицох бодлого, экосистемийн үйлчилгээний үнэлгээ, биологийн олон янз байдлын сүлжээний хамгаалалт зэрэг агуулгыг системтэй тусгаагүй байна. Иймээс хуулийн зорилгыг хамгаалалтын уламжлалт хориглох хандлагаас гадна шинжлэх ухаанд суурилсан, урт хугацааны тогтвортой менежментийн чиг баримжаатай уялдуулан шинэчлэх шаардлагатай.

Түүнчлэн, нэр томьёоны тодорхой бус байдал нь зөвшөөрөл олголт, хяналт-шалгалт, шүүхийн шийдвэрлэлтийн шатанд зөрүүтэй тайлбар гарах шалтгаан болж байна. “Хамгаалалтын горим”, “дэглэм”, “уламжлалт мал аж ахуй”, “зөвшөөрөгдөх үйл ажиллагаа”, “хязгаарлалт” зэрэг ойлголтыг хуулийн тусгай зүйлд нэгтгэн тодорхойлж, ангилал тус бүрийн хамгаалалтын зорилго, хориглох болон зөвшөөрөгдөх үйл ажиллагааг ялгавартай, давхардалгүй томъёолох нь хуулийн хэрэгжилтийг сайжруулахад чухал нөлөө үзүүлэхээр баайна.

Мөн 1994 онд батлагдсан хуулийн бүтэц нь тухайн үеийн хууль зүйн техникийн стандартад нийцсэн боловч өнөөгийн Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль зэрэг суурь хуулиудын шинэчлэлтэй уялдуулах шаардлага үүссэн. Захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон заалтуудын хамрах хүрээ, шалгуур, хугацаа, хяналтын шаардлагыг тодорхой болгож, нэг заалтад олон төрлийн харилцааг ерөнхий байдлаар хамруулсан зохицуулалтыг нарийсгах нь зүйтэй.

2. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг гүйцэтгэлд суурилсан, санхүүжилттэй уялдсан удирдлагын тогтолцоонд шилжүүлэх

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн одоогийн тогтолцоо нь зөвшөөрөл олголт, төлөвлөлт, санхүүжилт хоорондын уялдаа сул, гүйцэтгэлийн хэмжигдэхүйц шалгуур дутмаг байгаагаас хамгаалалтын бодит үр дүнг хангах боломж хязгаарлагдмал байна. Менежментийн төлөвлөгөө, газар ашиглах гэрээ, хамгаалалтын арга хэмжээ нь ихэвчлэн хэлбэрийн төдийн хэрэгжилтэд тулгуурлаж, санхүүжилт нь эдгээрийн бодитой болгох гүйцэтгэлтэй шууд холбогдохгүй байгаа нь системийн түвшний хийдэл үүсгэж байна.

Хэдийгээр ТХГНтХ-ийн 6 дугаар зүйлд ТХГН-ийн санхүүжилтийн эх үүсвэрийг дурдсан байдаг боловч түүнийг хэрхэн хангах, хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулах, зарцуулалтын

суурь зарчим юу болох, үр дүнг хэрхэн хэмжих, тайлагнах талаар тодорхой тусгаж өгөөгүй нь хийдэл үүсгэсэн шинжтэй байна. Түүнчлэн Төсвийн тухай хуулийн 3.4-т “Төсвийн харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулах бөгөөд орон нутаг, салбарын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээг хуульчлан тогтоох, түүнийг хуваарилах аливаа харилцаа үүнд нэгэн адил хамаарна.” гэж заасныг зөрчилдсөн шинжтэй байгааг анхаарах шаардлагатай байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг зөвшөөрөлд суурилсан хяналтаас гүйцэтгэлд суурилсан удирдлагын тогтолцоонд үе шаттай шилжүүлэх нь зүйтэй. Энэ хүрээнд менежментийн төлөвлөгөө, газар ашиглах гэрээ, хамгаалалтын арга хэмжээг экосистемийн даац, биологийн олон янз байдлын төлөв байдал, нөхөн сэргээлтийн үр дүн зэрэг хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлттэй уялдуулж, тэдгээрийн хэрэгжилтийг тогтмол үнэлэх, тайлагнах, дүгнэх эрх зүйн шаардлагыг тодорхой болгох шаардлагатай.

ТХГН-ийн санхүүжилт нь үндсэндээ урсгал зардлыг л нөхсөн байдлаар хэрэгжиж байгаа нь хамгааллын менежментийн төлөвлөгөө хэрэгжихгүй байх суурь нөхцөл болоод байна. 2025 оны байдлаар 120 улсын тусгай хамгаалалттай газрын 74.2 хувь нь менежментийн төлөвлөгөөгүй, 26.7 хувь нь ямар ч хамгаалалтын захиргаанд харъяалагдахгүй байгаа нь төсвийн шинэчлэл, санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх хэрэгцээ шаардлагатайг харуулж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн санхүүжилтийн эх үүсвэр, төсвийн хариуцлагыг хамгаалалтын ангилал болон удирдлагын түвшнээр ялгамжтай, тодорхой хуульчлах нь зүйтэй. Одоогийн хуульд санхүүжилтийн эх үүсвэрийг нэгдмэл байдлаар жагсаасан боловч аль ангиллын газар нутгийг улсын төсвөөс, алийг нь орон нутгийн төсвөөс тогтвортой санхүүжүүлэхийг тодорхой заагаагүй байна. Иймээс менежментийг улсын болон орон нутгийн төсвөөр ангилан санхүүжүүлэх суурь зарчмыг тусгах нь төсөв хоорондын хариуцлага, санхүүгийн тодорхой байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Одоогийн зохицуулалт нь хамгаалалтын ажлын төсөв юунаас бүрдэхийг заасан боловч менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, хамгааллын үр нөлөөтэй уялдсан санхүүжилтийн механизм агуулаагүй байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны суурь зардал болон менежментийн төлөвлөгөөнд суурилсан үр дүнгийн санхүүжилтийг тусад нь тогтоосноор төсвийн үр ашиг, гүйцэтгэлийн хариуцлагыг дээшлүүлэх боломж бүрдүүлэх боломжтой.

Тусгай хамгаалалттай газар нутгаас бий болсон орлого, нөхөн төлбөр, төлбөр хураамжийн тодорхой хувийг хамгаалалтын захиргаа болон менежментэд чиглүүлдэг эрх зүйн механизмыг илүү тодорхой болгох нь зүйтэй. Одоогийн хуульд орлого төвлөрөх эх үүсвэрүүдийг заасан ч орлого хамгаалалтын нэгжид ямар зарчмаар буцан хуваарилагдах нь хангалттай тодорхой биш, зарим орлого Засгийн газрын тусгай санд төвлөрөхөөр тусгагдсан байна. Иймээс байгалийн нөөц ашигласны төлбөр, зөрчил, гэмт хэргийн хохирол, нөхөн төлбөр, торгуулийн орлогоос хувь тэнцүүлэн хамгаалалтын захиргаанд санхүүжилт олгох зохицуулалтыг тусгах нь чухал.

Менежментийг гэрээгээр хариуцах этгээд, хамгаалалтын захиргааны санхүүжилтийн эрх зүйн статусыг нэг мөр болгож, нэмэлт санхүүгийн эх үүсвэрүүдийг хуульд тодорхой нээж өгөх шаардлагатай. Одоогийн хуульд орлого, төлбөрийн эх үүсвэрүүд бий боловч тэдгээрийг хамгаалалтын захиргаа, гэрээт менежментийн этгээд бодитоор хэрхэн ашиглах эрх зүйн хүрээ тодорхой бус хэвээр байна. Иймд гэрээгээр эрх шилжүүлэн менежмент хэрэгжүүлэгч этгээдэд ижил зохицуулалт үйлчлэхээр тусгаж, нэвтрэх хураамж, нэг удаагийн үйлчилгээний хураамж, дүйцүүлэн хамгаалах санхүүжилт, төр-хувийн хэвшлийн түншлэл, карбон кредит зэрэг эх үүсвэрийг тусгайлан нэрлэх нь менежментийн санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах ач холбогдолтой.

Төсвийн төлөвлөлт, тайлагнал, хяналт, олон нийтэд мэдээлэх үүргийг санхүүгийн тусгай зохицуулалттай уялдуулан илүү нарийвчлан хуульчлах шаардлагатай. Одоогийн хуульд менежментийн төлөвлөгөө, үнэлгээний талаар тодорхой зохицуулалт байгаа боловч санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтын бүтэц, үр дүнгийн мэдээллийг олон нийтэд тогтмол мэдээлдэг, нээлттэй болгох санхүүгийн тусгай бүлгийн зохицуулалт сул байна. Энэ сул талыг засаж, журам батлах эрх, шалгуур үзүүлэлт тооцох аргачлал, мөн орлого-зарлага-үр дүнгийн мэдээллийг нээлттэй тайлагнах үүргийг тодорхой болгоаж нь ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх үндэслэл болно.

Одоогийн хүчин төгөлдөр хуульд тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн санхүүжилт, зардлыг төлөвлөх, тайлагнах, хяналт тавих журам, мөн үр дүнгийн шалгуур үзүүлэлт тооцох аргачлалыг батлан мөрдүүлэх тухай тусгай зохицуулалт байхгүй тул энэ асуудлыг шинэчилсэн найруулгад тодорхой тусгаагүй нь санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж байна. Иймд энэ зохицуулалтыг тусгайлан оруулснаар төсвийн сахилга бат, хариуцлага, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэг мөр бүрдүүлэх боломжтой болно.

Үүнтэй уялдуулан санхүүжилтийн тогтолцоог гүйцэтгэл, үр дүнд суурилсан загварт шилжүүлж, төсөв хуваарилалт, нэмэлт санхүүжилт, урамшууллыг менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, хамгаалалтын үр дүнтэй холбох нь чухал. Тусгай хамгаалалттай газар нутгаас бүрдэж буй орлогыг хамгаалалтын үйл ажиллагаанд буцаан чиглүүлэх, гүйцэтгэлд суурилсан санхүүгийн урамшуулал, хариуцлагын механизмыг нэвтрүүлэх замаар санхүүжилтийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Мөн гүйцэтгэлийн үнэлгээ нь зөвхөн тайлагналын шинжтэй бус, газар ашиглах эрхийг сунгах, цуцлах, урамшуулал олгох, хариуцлага тооцох шийдвэртэй шууд уялдах зохицуулалттай байх шаардлагатай. Ингэснээр тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент нь формаль төлөвлөлтөөс бодит үр дүн, экосистемийн төлөв байдлаар хэмжигддэг, хариуцлагатай, уялдаатай удирдлагын тогтолцоонд шилжиж, хамгаалалтын бодлогын үр дүнг бодитоор хэмжих, санхүүжилтийг үр дүнд суурилан оновчтой хуваарилах боломж бүрдэнэ.

Герман, Австрали, Япон улсын туршлагаас үзэхэд тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг гүйцэтгэл, үр дүнд суурилсан шалгуур, санхүүжилттэй шууд уялдуулсан

тогтолцоогоор хэрэгжүүлж, менежментийн төлөвлөгөө нь бодит хэрэгжилтийн үндсэн хэрэгсэл болж ажилладаг байна. Иймд Монгол Улсад менежментийн төлөвлөгөө, гэрээ, санхүүжилтийн уялдааг гадаад туршлагад нийцүүлэн бэхжүүлэх нь хамгаалалтын бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

3.Хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчийн эрх зүйн статус, гүйцэтгэлийн стандарт, хяналт-шалгалтын тогтолцоог бэхжүүлэх

Хамгаалалтын захиргаа нь менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх, хяналт тавих, зөрчил илрүүлэх, орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах зэрэг өргөн хүрээний үүрэг гүйцэтгэдэг боловч хариуцсан талбайн хэмжээ, суурьшлын дарамт, санхүүжилт, хүний нөөцийн хязгаарлалт нь гүйцэтгэлийн жигд бус байдал үүсгэдэг. Байгаль хамгаалагчийн үйл ажиллагаанд нотлох баримт бүрдүүлэх процесс, эрх хэмжээ, хамгаалалтын арга хэрэгслийн стандарт нэг мөр тогтоогдоогүйгээс зөрчил шийдвэрлэлтийн шатанд хүндрэл үүсэх тохиолдол түгээмэл байна.

Дээрх хүндрэлтэй байдлыг арилгахын тулд хамгаалалтын захиргааны чиг үүргийг менежментийн төлөвлөгөө, хамгаалалтын зорилтот үзүүлэлттэй уялдуулсан гүйцэтгэлийн шалгууртай болгох шаардлагатай. Нэг байгаль хамгаалагчид ногдох талбайн хэмжээ, эргүүл-хяналтын давтамж, зөрчил илрүүлэх аргачлал, баримтжуулалтын стандарт зэргийг журам болон хуульд тодорхой тусгаснаар хэрэгжилтийн жигд байдал хангагдана.

Хяналт-шалгалтын мэдээллийг нэгдсэн цахим системд бүртгэж, зөрчил илрүүлэлтээс нөхөн төлбөр барагдуулах хүртэлх үйл явцыг нарийвчлан хуульчлах нь институцийн хариуцлага, ил тод байдлыг бэхжүүлэх чухал алхам болж, эрсдэлд суурилсан хяналт хэрэгжих боломж бүрдэнэ.

4. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглалт, эрхийн бүртгэл, мэдээллийн сангийн уялдааг хууль зүйн түвшинд нэг мөр болгох

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх олголт, түүний бүртгэл, эрх шилжилт, зориулалтын өөрчлөлт, барилга байгууламжийн бүртгэл нь хэд хэдэн хууль, мэдээллийн системийн огтлолцолд хэрэгждэг. Газрын тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон кадастрын мэдээллийн сан хооронд бодит цагийн мэдээлэл солилцох зохицуулалт хангалтгүй байгаа нь эрх давхцах, шилжилтийн мэдээлэл хоцрох, хуулийн шаардлага хангахгүй этгээдэд эрх шилжих эрсдэлийг бий болгодог.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хил зааг, дотоод бүсчлэл, хамгаалалтын горимыг кадастрын мэдээллийн нэгдсэн системд заавал тусгах, тухайн бүсэд эрх олгох аливаа шийдвэрийг өмнө нь батлагдсан бүсчлэл, хамгаалалтын дэглэмтэй автоматаар тулган шалгах механизмыг хуульчлах шаардлагатай. Ингэснээр бүсчлэлтэй зөрчилдөх шийдвэр гарах боломж хумигдана.

Газар ашиглах эрхийн шилжилт, хуулийн этгээдийн өмчлөгчийн өөрчлөлт, хувьцаа эзэмшигчийн солигдолт зэрэг мэдээллийг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн байгууллагад заавал мэдэгддэг, мэдээллийн нэгдсэн системээр баталгаажуулдаг зохицуулалт бий болгох нь зүйтэй. Тусгай хамгаалалттай газар нутагт барилга байгууламж барих, үл хөдлөх хөрөнгө бүртгэх, ашиглалтын зориулалт өөрчлөх тохиолдолд хамгаалалтын захиргааны санал, дүгнэлтгүйгээр улсын бүртгэлд бүртгэхгүй байх эрх зүйн шаардлагыг тодорхой тусгах нь хяналтын үр нөлөөг нэмэгдүүлж, эрхийн давхардал, хууль бус шилжилт буурч, шийдвэр гаргалт бодит мэдээлэлд тулгуурлах нөхцөл бүрдэнэ.

5. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, хамгаалалтын горим, дотоод бүсчлэлийн зохицуулалтыг шинэчлэн тодорхой болгох

Ангилал бүрийн зорилго, хамгаалалтын үнэт зүйл, зөвшөөрөгдөх болон хориглох үйл ажиллагааг илүү нарийвчлан тодорхойлохгүй тохиолдолд газар ашиглалт, аялал жуулчлал, судалгаа, орон нутгийн хэрэгцээний огтлолцолд зөрчил үүсэх магадлал буурах боломжгүй юм. Нөөц болон дурсгалт газрын хувьд хамгаалалтын горимын тодорхой бус байдал нь бодит хамгаалалтаас илүү хэлбэрийн төдий статустай үлдэх эрсдэл дагуулж байна.

Дотоод бүсчлэлийг ангилал бүрт заавал тогтоож, бүс бүрт хамаарах үйл ажиллагааны жагсаалт, ачаалал даацын шалгуур, хяналтын аргачлалыг хууль болон дагалдах журамд тодорхой тусгах шаардлагатай. Дотоод бүсчлэл нь зөвхөн зураглалын баримт бичиг бус, шийдвэр гаргалтын заавал шалгах үндсэн шалгуур болох ёстой.

Олон улсын туршлагаас харахад ангилал тус бүрд хамгаалалтын зорилго, зөвшөөрөгдөх болон хориглох үйл ажиллагааг ялгамжтай тогтоох нь хамгаалалтын дэглэмийг бодитой хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болдог бөгөөд Герман, Австрали, Япон улсын хувьд ангилал нь эрх зүйн ялгаатай дэглэмийн суурь болж байна. Иймд ангилалд суурилсан ялгамжтай зохицуулалтыг Монгол Улсын хуульд илүү тодорхой болгох шаардлагатай.

Ангилал хоорондын шилжилт, хил заагийн өөрчлөлт, дотоод бүсчлэлийн шинэчлэлийг зөвхөн улс төрийн шийдвэр бус экологийн үнэлгээ, нийгэм-эдийн засгийн дүн шинжилгээ, олон нийтийн оролцоонд тулгуурлан шийдвэрлэх эрх зүйн шаардлагыг тодорхой болгох нь хамгаалалтын тогтвортой байдлыг хангах үндэслэл болно.

6. Орчны бүсийн зохицуулалтыг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн бүтцэд нэгтгэх

Орчны бүсийн харилцаа нь бие даасан, тусгаарлагдсан эрх зүйн объект бус бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын зорилгыг хангахад дэмжлэг үзүүлэх, тусгаарлах бүсийн зохицуулалт юм. Орчны бүсийн үндсэн зорилго нь хамгаалалтын дэглэмийн үр нөлөөг нэмэгдүүлэх, орон нутгийн иргэдийн оролцоог хангах, хамгаалалтын дарамтыг бууруулахад чиглэдэг тул агуулгын хувьд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хүрээнд хамаарах зохицуулалт гэж үзэх бүрэн үндэслэлтэй.

Нөгөө талаар хууль тогтоомжийн системчлэлийн зарчмын үүднээс нэг ижил харилцааг хоёр өөр хуульд хуваан зохицуулах нь норматив давхардал, хэрэгжилтийн зөрчил үүсгэдэг. Орчны бүс нь тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүсчлэл, менежментийн төлөвлөгөө, хамгаалалтын горимтой салшгүй холбоотой тул түүнийг бие даасан хуулиар зохицуулах шаардлага бодит агуулгын хувьд үндэслэл сул байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад орчны бүсийн зохицуулалтыг тусгай бүлэг болгон нэгтгэж, нэгдсэн байдлаар тодорхой тусгах нь зүйтэй.

Олон улсын практикт орчны бүс нь тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн салшгүй хэсэг байдлаар зохицуулагдаж, хамгаалалтын үндсэн бүсийг дэмжих, хүний үйл ажиллагааны дарамтыг бууруулах интеграцчилсан механизм болж хэрэгждэг. Иймд орчны бүсийн зохицуулалтыг тусгаарласан бүс, нэгдсэн менежментийн хүрээнд авч үзэх нь оновчтой.

Ингэснээр орчны бүс нь хамгаалалтын тогтолцооны дэмжих механизмын хувьд тодорхой байр суурь эзэлж, бодлогын уялдаа сайжирна. Мөн хууль зүйн давхардал арилж, менежментийн төлөвлөгөө, санхүүжилт, хяналт-шалгалт нэгдсэн логикт шилжинэ.

7. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн зохицуулалтыг нэгдсэн шалгуур, мэдээллийн уялдаанд суурилан шинэчлэх

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн зохицуулалт нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Газрын тухай хууль болон орон нутгийн өөрийн шийдвэр гаргалтын практикт тулгуурлан хэрэгждэг боловч эрх зүйн болон мэдээллийн уялдаа хангалтгүй хэвээр байна. Орон нутгийн хамгаалалтын шийдвэр хурдтай нэмэгдсэн ч хил заагийн баталгаажуулалт, кадастрын тулгалт, экологийн үндэслэл, давхардлын шалгалт тогтолцооны түвшинд нэг мөр болоогүйгээс эрх зүйн зөрчил, газарзүйн давхцал, шүүхийн маргаан үүсэх нөхцөл бүрддэг.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн шийдвэрийг улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, ашигт малтмалын кадастр, газрын улсын бүртгэл, тусгай хамгаалалттай газар нутгийн газар зүйн системтэй уялдуулах механизмыг бий болговол давхар эрх олголтоос урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэнэ.

Мөн орон нутгийн хамгаалалтын менежмент нь төсөв, хүний нөөц, мэргэжлийн чадавхаас хамааран ялгаатай хэрэгжиж байгаа тул менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах үүргийг хуульд тодорхой зааж, улсын дэмжлэг, хамтын менежмент, оролцоонд суурилсан санхүүжилтийн хэлбэрийг хослуулах зохицуулалт тусгах нь зохистой.

8. Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал, суурьшлын бүсийн зохицуулалтыг даац, бүсчлэл, хамгаалалтын зорилготой уялдуулан шинэчлэх

Хэрэгжилтийн үнэлгээ, хамгаалалтын захиргаадын санал, шүүхийн практик зэргээс харахад тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал болон суурьшлын бүсийн төлөвлөлт хангалттай нарийвчлагдаагүй, экосистемийн даацын үнэлгээ тогтмол хийгддэггүй, зөвшөөрөл олголтын шалгуур нэг мөр бус байгаа нь хөрс, ургамлын талхлалт, замын олон салаалал, хог

хаягдлын менежментийн доголдол, барилга байгууламжийн зөрчил нэмэгдэхэд нөлөөлж байна. Суурьшлын дарамт өндөр бүсүүдэд хамгаалалтын зорилго болон үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын ашиг сонирхол зөрчилдөх хандлага түгээмэл ажиглагддаг.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд 2023 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглуулах сонгон шалгаруулалтын зохицуулалт бий болсон ч энэ нь экосистемийн даац, дотоод бүсчлэл, менежментийн төлөвлөгөөтэй нэгдмэл уялдсан шалгуурт бүрэн суурилаагүй хэвээр байна. Хууль шинэчлэх хүрээнд аялал жуулчлал, суурьшлын бүсийн асуудлыг хамгаалалтын зорилго, бүсчлэлийн дэглэм, даацын үнэлгээтэй уялдуулан системтэй зохицуулах шаардлагатай.

9. Тусгай хамгаалалттай газар нутагт байгаль орчны хохирол, эрхийн хязгаарлалттай холбоотой нөхөн төлбөр, маргаан шийдвэрлэх зохицуулалтыг системчлэх

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд хамгаалалтын горим зөрчсөнөөс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, газар нутгийг хамгаалалтад авсантай холбоотой иргэн, хуулийн этгээдийн эрх ашигт нөлөөлөх асуудлыг зохицуулах суурь заалтууд бий. Гэвч хохирол тооцох аргачлал, нөхөн төлбөрийн шалгуур, маргаан шийдвэрлэх шатлал нэгдмэл стандартгүй байгаа нь зөрчил давтагдах, шүүхийн маргаан удаашрах, хамгаалалтын болон өмчийн эрхийн хоорондын зөрчил гүнзгийрэх шалтгаан болж байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт учруулсан хохирлыг ангилал, экосистемийн үнэ цэн, биологийн төрөл зүйлийн эмзэг байдалтай уялдуулсан үнэлгээний аргачлалаар тооцох зарчмыг хуульд тодорхой тусгах нь зүйтэй. Мониторингийн өгөгдөл, судалгааны үр дүн, нөхөн сэргээлтийн бодит өртөгт суурилсан үнэлгээ хийх тогтолцоо бүрдүүлбэл хариуцлага бодитой хэрэгжинэ.

Тусгай хамгаалалттай газар нутгийг шинээр тогтоох, хил зааг өөрчлөх, хамгаалалтын горим чангарах үед өмнө олгогдсон газар ашиглалтын эрхэд үүсэх хязгаарлалтыг үе шаттай шийдвэрлэх, шаардлагатай бол нөхөх олговор олгох зарчим, шалгуур, санхүүгийн эх үүсвэрийг тодорхой болгох шаардлагатай. Ингэснээр хамгаалалтын бодлого болон өмчийн эрхийн тэнцвэр хадгалагдана.

10. Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн зохицуулалтыг газрын харилцааны нэгдсэн тогтолцоонд уялдуулан системийн түвшинд дахин загварчлах¹³

Тусгай хамгаалалттай газар нутгийг бие даасан “хамгаалалтын объект” хэлбэрээр тусгаарлан зохицуулж ирсэн хандлагыг өөрчилж, газрын харилцааны нэгдсэн менежментийн

92	33.1. Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр энэ хуулийн 27 дугаар зүйлийн 12-т заасан зөвшөөрлийн үндсэн дээр гэрээгээр ашиглуулж болно.	УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ ЯВУУЛАХ ЖУРАМ
93	36 ¹ .1. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалтыг өөрийн санаачилгаар явуулах бол тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд үндэслэн олон нийтэд нээлттэй явуулна.	
94	36 ¹ .4. Сонгон шалгаруулалтад оролцогчид болон ирүүлэх төсөлд тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлсон журмыг тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалтад оролцогчдоос төсөл хүлээн авах журам
95	37.1. Энэ хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар ашиглах тухай гэрээг төрийн захиргааны төв байгууллага хамгаалалтын захиргаатай хамтран байгуулснаар тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах тухай гэрчилгээг олгож, улсын бүртгэлд бүртгэнэ	https://legalinfo.mn/mn/detail?lawId=208296
96	41.1. Тусгай хамгаалалттай газар нутагт Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.6-д заасан зөвшөөрөл авсан байгууллага, гадаадын болон олон улсын эрдэм шинжилгээний байгууллага судалгаа, шинжилгээний ажлыг гэрээний үндсэн дээр явуулж болно	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа шинжилгээний ажил явуулахад мөрдөх журам
97	42.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хамгаалалтын захиргаа, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина	ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

98	42.2. Байгаль орчны хяналтын улсын байцаагчид тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, зөрчигчдөд эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага хүлээлгэнэ.	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт хяналт, шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулахад ашиглагдах "СМАРТ" програмын гарын авлагын арга зүйг батлах тухай
99		Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн гэрээ, гэрчилгээний загвар батлах тухай

	Хамааралтай бусад зохицуулалтууд	
2	Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ус ашигласан усны төлбөр тооцох тухай	https://eic.mn/legalinfo/upload/2018/talegalanne/20181226_8990_752.pdf
3	"Байгаль орчин, уур амьсгалын сангийн зохион байгуулалт, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам	https://eic.mn/legalinfo/upload/2025/talegalinfo/20250702_7745.pdf
4	Монгол Улсын байгалийн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалт	https://eic.mn/legalinfo/upload/2025/talegalinfo/20250702_2767.pdf
5	Ховор ургамлын жагсаалт	https://legalinfo.mn/mn/detail?lawId=202703&showType=1
6	НЭН ХОВОР, ХОВОР АМЬТДЫГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	https://legalinfo.mn/mn/detail?lawId=202927
7	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийг (эхний үе шатанд 1999-2005 онд) хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	https://legalinfo.mn/mn/detail?lawId=3968
8	МОНГОЛ ОРНЫ ХОВОР УРГАМЛЫГ ХАМГААЛАХ, ЗОХИСТОЙ АШИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР	https://legalinfo.mn/mn/detail?lawId=201393&showType=1
9	АГНУУРЫН ЗАГАС ХАМГААЛАХ, ӨСГӨН ҮРЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	https://legalinfo.mn/mn/detail?lawId=202409&showType=1
10	Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай	https://eic.mn/legalinfo/upload/2022//8/20221025_7304_8.pdf
11	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын бүтэц, орон тооны хязгаар, мэдээллийн төвүүдийн байршлыг шинэчлэн батлах	https://eic.mn/legalinfo/upload/2022//8/20221020_8579_8.pdf
12	Аялал жуулчлалын зам, чиглэл тогтоох, тушаалын холбогдох хэсгийг хүчингүй болгох	https://eic.mn/legalinfo/upload/2020//8/20200902_3354_8.pdf
13	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт чоныг тоог зохицуулах, зэрлэгшсэн нохой устгахад мөрдөх журам	https://eic.mn/legalinfo/upload/1995/talegalanne/19950215_2796_182.pdf

Эх сурвалж: Өнө мөнхийн Монгол” хөтөлбөрийн зохицуулах нэгж

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГУУДЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААДЫН БАРУУН БҮСИЙН УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдуулан

хамгаалалтын захиргаадаас гаргасан санал

Хаана: Завхан аймгийн Дөрвөлжин сум, Хомын талын БЦГ

Хэзээ: 2025 оны 08 сарын 07

Цаг: 09.00-12.00

Үндсэн зохион байгуулагч: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам

ТХГН-ийн Бодлого, зохицуулалтын газар

Хуралд оролцогчид:

1. ТХГН-ийн Бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Батцогт
2. Хомын талын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
3. Монгол элсний байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
4. Хар-ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа
5. Ачит нуур дэвлийн арлын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
6. Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
7. Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
8. Хан Хөхийн нурууны тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа
9. Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа
10. Тарвагатайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
11. Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа
12. Монгол алтай нурууны улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа
13. Хөх сэрхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа

Хамтран оролцогчид:

- Монголын Байгалийн Өв Сан А Удирдах зөвлөлийн гишүүн С.Амгаланбаатар
- Удирдах зөвлөлийн гишүүн Ө.Азжаргал
- Гүйцэтгэх захирал Э.Номиндарь
- Бодлого, хамтын ажиллагаа хариуцсан менежер Ч.Намжилмаа
- Мэргэжилтэн Calvin Moschkau
-
- “Өнө мөнхийн Монгол” хөтөлбөрийн зохицуулах нэгж ТХГН-ийн менежмент хариуцсан мэргэжилтэн Ж.Очирхуяг
-

Хуулийн хэлэлцүүлгийн хөтөлбөр 09.00-09.40	ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга (БОУАӨЯ-наас олон нийтэд танилцуулсан агуулгын хүрээнд)	Монголын Байгалийн Өв Сангийн Бодлого, хамтын ажиллагаа хариуцсан менежер Ч.Намжилмаа
09.40-10.00	Тодруулга, асуулт хариулт	ТХГН-ийн Бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Батцогт

10.00-11.45	Хамгаалалтын захиргаадаас хуулийн төсөлд холбоотой саналууд	ТХГН-ийн захиргаадын төлөөлөл
11.45-12.00	Дүгнэлт	ТХГН-ийн Бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Батцогт

Хуулийн танилцуулга хийгдсэний дараа хамгаалалтын захиргаадын төлөөллөөс дараах саналуудыг гаргасан болно.

Гаргасан саналууд

Хар-Ус нуур

- Хуулийн төслийг эцэслэсэн хувилбараар нийт хамгаалалтын захиргаадад илгээж, БОУАӨЯ-аас санал ирүүлэх хугацаа заан албан ёсоор санал авахаар зохион байгуулах
- Хамгаалалтын захиргаадад туслах аж ахуй эрхлэх эрхийг хуулиар олгох
- ТХГН-т мод тарьж болж байгаатай адил амьдарч буй иргэдэд ногоо тарих эрхийг олгох
- Ахуйн зориулалтаар хадлан хадах гэдэг заалт нь механик ашиглаад хадлан авч байгаа хүнээс татвар хураамж авах боломжгүй болгож байна. Ховд аймгийн хадлангийн 80% нь манай газар нутгаас гардаг. Тиймээс зохицуулалтыг илүү тодорхой болгох
- БНХМН-тэй гэрээ байгуулах эрхийг хамгаалалтын захиргаадад олгоогүй. Малчдын нөхөрлөл Засаг даргатай гэрээ байгуулдаг. Хамгаалагдаж буй газар давхцдаг учраас цаашид энэ асуудлын зохицуулалтыг оновчтой тусгавал ТХГН-т амьдарч буй малчдын байгаль хамгааллын үүрэг, оролцоо илүү оновчтой болдог.
- ТХГН-т байгаа усны болон ойн сав газартай холбоотой асуудлыг зохицуулалт байхгүй байна. Ашиглалт дээр орлого нь сав газрын захиргаанд ордог, эргүүл хамгааллыг нь хамгаалалтын захиргаа хийж байдаг нь зөрчил үүсгэдэг. ТХГН-ийг хамгаалж байгаа газар нутагт сав газар ашиглалтын менежмент хийгээд байхаар зөрчил үүсдэг асуудал байна.
- Усан замын тээврийн тухай хуулийн тухай хуулиар усан дээр хөвөгч ашиглах эрхийг орон нутаг шийддэг. Мөн устай газрууд дээр хөвөгч байх хугацааг орон нутаг шийддэг боловч хаана байхыг нь хамгаалалтын захиргаа шийддэг. Аялал жуулчлал гэх мэт зорилгоосоо хамаараа Хар-Ус нуур дээр зун хөвөгч ашигламаар өөр газар бас нээмээр байдаг. Хуулиуд хоорондоо зөрчилдөх нь хамгаалалтын захиргаа хэрэгжүүлэлт хийхэд зөрчил, асуудал үүсгэдэг нь шийдэгдэх шаардлагатай байна.
- Онцгой байдлын ерөнхий газар, засаг дарга зудын эрсдэлээс сэргийлэх гээд бараг жил бүр ТХГН-аас хадлан авахуулж бэлдүүлдэг ба хамгаалалтын захиргаа үүн дээр юу ч хийх эрх мэдэлгүй байдаг.
- ТХГН байгаль хамгаалагч 60 нас хүртэл ажилладаг. Хөдөлмөрийн хүнд хүчир нөхцөлд ажилладаг хүмүүс 60 хүртлээ ажиллах нь хэцүү ба нийгмийн халамжийг нь сайн олгоод 50 хүрэхэд нь тэтгэвэрт гаргах хэрэгтэй.
- Ахмадын тухай хууль бас асуудал дагуулдаг ба ахмад байгаль хамгаалагчийг тэтгэвэрт гарахаасаа 3 жилийн өмнөөс бэлдүүлэх, ажлын цагийг багасгах, томилолтод явуулахгүй байх гэх мэт зүйлсийг хориглоод байдаг.
- Энгийн байгаль хамгаалагчид мэргэжлийн байцаагчийн үнэмлэх өгчихөөр зөрчил илрүүлээд байгаа ч зохих үндэслэл зэргийг ерөөсөө гаргаж мэдэхгүй байгаа. Үүн дээр сургалт хэрэгтэй байна.

- Хэрэг илрүүлсэн байгаль хамгаалагч, төрийн албан хаагчийг ноцтой хууль зөрчөөгүй байна гээд цагдаа нь хэрэгтний өмнө загнадаг, доромжилдог асуудал гарсан. Тэр байгаль хамгаалагч бол дахиж хэзээ ч ийм хэрэг мэдээлэх
- Цагдаагийн газар дээр хэрэг шийдэгдэхгүй хэргийн баримт утсан тохиолдол байгаа. Хэрэг үүсээд шийдэгдэхдээ жишээ нь Ховд хот дээр шийдэгдэнэ. Байгаль хамгаалагч нь олон км явах боломжгүй, завгүй байдаг.
- Экологи эдийн засгийн үнэлгээ мэргэжлийн бус гарч байна. Харь хортон зүйлийн эдийн засгийн үнэлгээ нь хамгаалж байгаа зүйлийн үнэлгээнээс өндөр байгаа тохиолдол байна. Ондатарыг 150,000 төгрөг гэж үнэлсэн нь хамгаалж байгаа амьтнаас өндөр үнэтэй болсон. Үүнийг засах шаардлагатай.

Хомын талын БЦГ

- Нөөцийг ашиглах зөвшөөрлийг хэн өгөх вэ болоод төлбөр хураамжийг хэн авах вэ гэдэг чухал байна. Орон нутагт хамгаалал гэхээсээ илүү орлого нэмэгдүүлэх нь чухал. Нөгөө талаар хамгаалалтын захиргаа байна уу, орон нутаг байна уу ялгаагүй төсөв бүрдүүлж байгаа учраас хамгаалалтын захиргаа нь хамгаалалттайгаа уялдуулан нөөцөө тогтоогоод ашиглалтыг зөвшөөрдөг эрхтэй болох нь зүйтэй байна.
- Ахуйн болоод үйлдвэрийн зориулалтын зохицуулалт хэрэгтэй байна. Ахуйн зориулалтаар жимс түүж байна гээд цаашаа үйлдвэрт нийлүүлдэг. Бүхий л нөөц дээр ахуйн зориулалтын болон үйлдвэрийн хэмжээ тогтоох шаардлагатай байна.
- Ангийн буу, байлдааны буу, ангийн нохой, гэрийн нохой гээд үүнийг тодорхой байлгахгүй бол хууль хэрэгжүүлэхэд зөрчил, үүсгэж байна. Нохойгоо дагуулаад ан хийхгүй байгаа, нүүж явахдаа буугаа үүрч байгаа хүнийг бид торгоод байж болохгүй. Тэгэхээд яг ямар тохиолдолд торгох ёстойг зохицуулалтыг маш тодорхой хуульд оруулах
- Ажилтны нийгмийн халамжийн тухай. Хувийн хэвшлийн хариуцаж байгаа болоод улсны хариуцаж байгаа ТХГН-ийн ажилчдын нийгмийн зохицуулалтыг адилхан байлгах хэрэгтэй
- ТХГН-ийн хураамжийн тухай асуудал. Орон нутаг нутгийн иргэдээс төлбөр авдаг боловч бурууг нь хамгаалалтын захиргаанд чихдэг байдал байна. Нутгийн иргэн газар нутагтаа амьдарч байгаад ТХГН-т авсантай холбоотойгоор газрын төлбөр төлөх үүрэг үүссэнээс иргэдийн хамгаалалттай газарт хандах хандлага сөрөг болж байна. Ойлголт мэдээллийг сайн өгөх, зохицуулалтыг оновчтой болгох шаардлагатай.
- Нөөцийг тогтоохтой холбоотойгоор нөөцийг хамгаалалтын захиргаа тогтоох эрхийг зохицуулах
- Өвөлжөө, хаваржааны гэрчилгээ өгөх, газрын асуудал дээр орон нутаг, хамгаалалтын захиргаа болон иргэд гурвалсан гэрээ хэрэгтэй. Орон нутаг бүр түлхүү хариуцах
- Төрийн бус байгууллага ТХГН-ийн менежмент хийхдээ шалгуур тогтооход хамгаалалтын ангилал, хэмжээ, зорилгоос хамаараад ялгавартай тогтоох
- Орон нутгийн хамгааллын статустай байж байгаад улсын хамгаалалтад авахад орон нутгийн хамгаалалттай холбоотой шийдвэр хүчингүй болдог зохицуулалт шаардлагатай. Тэгэхгүй бол 2 зэрэг хүчинтэй шийдвэр, тогтоолууд явах тохиолдлууд гарсан.
- Байгаль хамгаалагчийн байр хийхдээ хил залгаа хамгаалалтын захиргаад дундаа хийж болохоор байгаа. Бүсчилж ялгахар бол Хомын тал баруун бүсэд хамаарах хүсэлтэй байна.

Монгол алтайн нуруу

- Өсөж байгаа нөөц буюу аргаль, янгирын ашиглалт байхгүй байгаад байна. Хамгаалалт бол байнга хийж байгаа ч байгалийн жамаараа өсөж үхэл хорогдол өндөр байгаа амьтдаас,

нөөцөд үндэслэн олзворлолт хийлгэн хамгаалалтын захиргаа орлого олох боломж байгаа. Зөндөө олон нөөц эдийн засгийн эргэлт байхгүйгээр байгалиараа байхгүй болоод байна.

Хөх сэрхийн нуруу

- Хамгаалалтын захиргааны эрх мэдэл бага. Хамгаалалтын захиргааг мэдээгүй байхад л зөвшөөрөлтэй гээд ангийн отгууд байгуулагдаад, ан хийгээд байж байдаг. Бид нар очоод хариуцлага нэхэхэд зөвшөөрөлтэй гээд хүлээж авдаггүй.
- Рашаан сувилал ажиллуулдаг газрууд бид нар хураамж аваагүй байхад тэд нар өндөр хураамж аваад байдаг.
- Аймгийн засаг дарга ангийн квот зэргийг тодорхойлдог. Бүх ангийн отгууд орчны бүсэд байгаа ба ХЗ-аад үүн дээр ямар ч эрх мэдэл байхгүй байна.

С.Амгаланбаатар

- Хамгаалалтыг захиргааг байгаль хамгааллын мэргэжлийн байгууллага гэж хуулиар зөвшөөрч тодорхойлж тусгах шаардлагатай байна.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд хамгааллын асуудлаас гадна дотор нь ажилладаг хүмүүсийн нийгмийн орчны талаар оруулах хэрэгтэй.
- Ан агнууртай холбоотой асуудал бол алсан хойно нь хариуцлага тооцох биш агнахаас нь өмнө урьдчилан сэргийлэх асуудлыг оруулах хэрэгтэй.
- Хариуцлага, урамшууллын тогтолцоо байх хэрэгтэй. Байгаль хамгаалагч нь халдлагад өртсөн байвал ХЗ даргад хариуцлага тооцдог. Тогтолцоо нь хүнээ хамгаалдаг байх хэрэгтэй.
- Үйлдвэрлэлийн гэдэг нэр томъёо хэрэггүй ба арилжааны гэдэг үгээр орлуулах хэрэгтэй.
- Нохойг бол ангийн, энгийн гэж ялгах хэрэггүй зүгээр хүнд зугтах боломж гаргаж өгч байна гэсэн үг.
- Одоогийн байгаа ТХГН-ийн хуулиар ТХГН-т агнуур хийж болохгүй. Сүргийн зохицуулалт ч хэрэггүй. Бүх агнуурын бүсийг 5-р ангилалд оруулчих хэрэгтэй. Тэгэхээр агнуурын бүс нутгийг хариуцаж байгаа газрууд байхгүй болоод ХЗ бүгдийг нь хариуцаад явах боломжтой. Агнуурын бүс нутагт агнуулахдаа хамгийн томыг нь сонгож агнаад байна. Тэр агнуур хийлгэж байгаа хүмүүс боловсон хүчин байхгүй ба харин хамгаалалтын захиргаа хариуцвал тэнд ядаж мэдлэгтэй хүн болон жудагтай хүмүүс байгаа. Агнагдах хүртлээ улсын өмч, агнагдсан хойноо бол тэр анчны өмч гэдгийг сайтар ялгаж хуулиа хэрэглэх шаардлагатай.

Отгонтэнгэр

- Мэдээлэгчийн 15%-ийг хамгаалалтын захиргаа авдаг байсан боловч хууль хэрэгждэггүй. Үүнийг хуульд хэрэгжихээр оруулж өгмөөр байна. Зөрчил, гэмт хэргээр үйлдэгдсэн хохирлыг ХЗ-д өгөх.

Ачит нуур Дэвэл арал

- Хамгаалалтад авахаас өмнө зөвшөөрөлтэй хүмүүс байгаа ба зөвшөөрлөө хамгаалалтад орохоос өмнө авсан байгаа үүнийг яаж шийдэх ёстой вэ? Зохицуулалт нь тодорхойгүй, ТХГН-ийн хуулиар тогтоосон горим, дэглэм мөрдөгдөхгүй байна.

Мөнххайрхан

- Нүүрс тээврийн зам нь 2 тусдаа ТХГН-ийн хязгаарлалтын бүсээр дайрч гарч байгаа. Тээврийн компани 2 тусдаа төлөхгүй, нэг замаар явж байгаа гэсэн асуудал тавьж байгаа. Дамжин өнгөрөх зориулалтаар тээврийн үйлчилгээ явж байгаа бол төлбөрийн ялгаатай зохицуулалт шаардлагатай байна.

Хан хөхий, Хяргас нуур

- Хамгаалалтын захиргаадаас зөрчил торгууль ногдуулахдаа замын цагдаагаас торгууль, зөрчил тавьдаг шиг систем нэвтрүүлж, шууд хуудас гардуулдаг болох эрх зүйн орчныг бүрдүүлэх

Д.Батцогт дарга

- Захиргаадаас ирүүлсэн хуулийн орчныг сайжруулахтай холбоотой саналыг ажлын хэсэгт албан ёсоор хүргүүлэх
- Хамгаалалтын захиргаадад ТХГН-ийн хуулийн төсөлд албан ёсоор санал авах ажлыг зохион байгуулах
- Нүүрс тээвэртэй холбоотой шүүхийн маргааны асуудлыг яамны Хуулийн хэлтсээс дэмжлэг авах

- Хамгаалалтын захиргаадад газар ашиглалттай холбоотой харилцан туршлага судлах 2 цагийн арга хэмжээ зохион байгуулах. Газар ашиглалттай холбоотойгоор Богд хан уулын хамгаалалтын захиргаа болон Горхи тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаанаас туршлага судлах шаардлагатай.
- ТББ-аас гэрээний үндсэн дээр хамгааллын үйл ажиллагаа эрхэлж байгаа бол нийгмийн хамгамж, тэтгэмжийг төсвийн байгууллагатай адил байхаар хуульд тусгайлан анхаарч тусгах шаардлагатай.
- 10 сард зохион байгуулах ТХГН-ийн чуулганд идэвхтэй оролцох
- МБӨС-аас үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэхээр БОУАӨЯ, СЯ-тай ажлын хэсэг байгуулсантай холбоотойгоор хамгаалалтын захиргаадаас мэдээлэл авах арга хэмжээг зохион байгуулна. Мэдээллээ МБӨС-т сайн гаргаж өгөх шаардлагатай.

---o0o---

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГУУДЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААДЫН ХОЙД БҮСИЙН
УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ**

ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдуулан
хамгаалалтын захиргаадаас гаргасан санал

Хаана: Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон, AMI Resort

Хэзээ: 2025 оны 08 сарын 22

Цаг: 09.00-12.00

Үндсэн зохион байгуулагч: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ТХГН-ийн Бодлого, зохицуулалтын газар

Хуралд оролцогчид:

1. ТХГН-ийн Бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Батцогт
2. Орхоны хөндийн Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
2. Тужийн нарсны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
3. Хөгнө тархны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
4. Ноён уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
5. Зэд хантай бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
6. Тэнгис Шишгэдийн Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
7. Улаан тайгын Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа
8. Тэс булнай нурууны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
9. Их богдын Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
10. Хангайн нурууны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
11. Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа

Хамтран оролцогчид:

- Монголын Байгалийн Өв Сан Гүйцэтгэх захирал Э.Номиндарь
- Бодлого, хамтын ажиллагаа хариуцсан менежер Ч.Намжилмаа
-
- “Өнө мөнхийн Монгол” хөтөлбөрийн зохицуулах нэгж Зохицуулагч С.Амартүвшин
- Мэргэжилтэн С.Хулан
- Мэргэжилтэн М.Намуунаа
-

**Хуулийн хэлэлцүүлгийн ТХГН-ийн тухай хуулийн GIZ төслийн хуулийн
хөтөлбөр 09.00-10.00 шинэчилсэн найруулгын зөвлөх Лхагвабаяр
төслийн танилцуулга
(БОУАӨЯ-наас олон нийтэд
танилцуулсан агуулгын
хүрээнд)**

**Хуулийн танилцуулга хийгдсэний дараа хамгаалалтын захиргаадын төлөөллөөс дараах саналуудыг
гаргасан болно.**

Гаргасан саналууд

Улаан Уул

- Үндэсний бахархал болгох концепцийг хуульд нэмэх: Хуулийн нэр томьёо, бүтэц дотор “Үндэсний дархан газар”, “Үндэсний байгалийн дурсгалт газар”, “Үндэсний нөөц газар” гэх мэт нэршлийг оруулж өгөх.
- Тусгай хамгаалалттай газрын тухай хуулийг 20 гаруй жилийн дараа шинэчлэх цаг нь болсон. Хэлэлцэж буй оролцогчид хуульд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ анхааралтай, бодитой хандах шаардлагатай.
- 5 дахь ангилал нь ТХГН-ийн нэр хүнд, зэрэглэлийг бууруулах эрсдэлтэй. Учир нь УИХ батлах эрхтэй ангиллыг яамны сайдын түвшинд тогтоодог болбол хэт төвөгтэй, эмх замбараагүй тогтолцоо үүсч магадгүй. Ийм зохицуулалт нь орон нутгийн түвшинд дур мэдэн санал гаргах, шийдвэр гаргах эрсдэл дагуулна.
- Байгалийн нөөцийг ашиглахтай холбоотой зохицуулалтыг нэг бүлэг болгон нэгтгэх шаардлагатай. Одоогийн байдлаар хадлан, бэлчээр, ой, ус, загас, самар, жимс гэх мэт тусдаа заалттай байгаа нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй.
- Хэрэгжүүлэгч байгууллага, иргэдэд ойлгомжтой, хэрэглэхэд хялбар бүтэцтэй байвал үр дүнтэй.
- Гэрээгээр хамгаалалтын ажлыг хэрэгжүүлж буй тохиолдолд тэдгээрийг урамшуулдаг тогтолцоо байх ёстой. Олны хөл ихтэй газруудад (ж.н. Горхи-Тэрэлж, Хөвсгөл далай) отоглох цэгийг концессийн гэрээгээр зохицуулах боломжтой. Энэ нь: санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хамгаалалтын менежментийг сайжруулах, хариуцлагатай аялал жуулчлалыг дэмжих боломжийг бүрдүүлнэ.
- Гэрээгээр хамгаалалтын ажилд идэвхтэй оролцож буй орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах механизм хуульд тусгах шаардлагатай.
- Дархан цаазат газрын хамгаалалтын бүс дотор спорт ан агнуур, аялал жуулчлалын мэдээллийн төв зэргээр газар ашиглах боломжийг нээсэн хууль зүйн үг хэллэг буруу ойлгогдон, зөрчил, замбараагүй газар ашиглалт үүсгэх эрсдэлтэй байна. “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 13.1.10”-д “байгаль, түүх, соёл, аялал жуулчлалын сургалт, судалгаа, мэдээллийн төв байгуулах” гэж зааснаар “газар ашиглана” гэсэн утгатай орсон.
- Дархан цаазат газрын хамгаалалтын бүс дотор шинэ барилга байгууламж барих, газар эзэмшихийг хатуу хориглох заалтыг нэмж оруулах. Хамгаалалтын бүсэд зөвхөн судалгаа, хяналт, байгаль хамгааллын чиг үүрэгтэй байгууламж байршуулж болохоор нарийвчлан заах.

Тужийн нарс

- 310 га таримал ой шатсан боловч 2004 онд тарьсан үеийн үнэлгээгээр (1 га = 60–80 мянган төгрөгөөр) хохирол тооцож байгаа. Өнөөгийн өртөг (1 га = ~300 мянган төгрөг)–тэй харьцуулахад хохирол маш бага үнэлэгдэж байна. Байгаль орчны сайдын 1993/1994 оны журмаар “тариалсан үеийн үнэлгээгээр” хохирол тооцохоор заасан. Энэ заалт шинэ нөхцөлд тохирохгүй, бодит өртөг, зах зээлийн ханшаар үнэлэх шаардлагатай.
- Монгол Улсад “таримал ойн албан ёсны үнэлгээ” гэсэн тодорхой аргачлал байхгүй.
- Таримал ойн арчилгаа, нөхөн сэргээлтийн нэг га-ийн өртгийн тооцоо албан ёсоор батлагдах шаардлагатай. Монгол Улсад “таримал ойн албан ёсны үнэлгээ” гэсэн тодорхой аргачлал байхгүй. Таримал ойн арчилгаа, нөхөн сэргээлтийн нэг га-ийн өртгийн тооцоо батлах шаардлагатай.
- Тухайн асуудлаар хууль зүйн зөвлөмж, үнэлгээний албан ёсны аргачлал одоогоор байхгүй байна.

Их Богд

- Тусгай хамгаалалттай газрын тогтолцоо хуучирсан, өдөр тутмын үйл ажиллагаа бодит үр дүнгүй, хязгаарлагдмал нөхцөлд хэрэгжиж байна. Байгаль хамгааллын тогтолцоог шинэчлэх, хамгаалалтын захиргааг бие даасан агентлагийн статустай болгох. Төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх эрх хэмжээ, санхүүгийн чадавхыг орон нутгийн түвшинд нэмэгдүүлэх.
- Хамгаалалтын захиргааны дарга нарын эрх, үүрэг тодорхойгүй, шийдвэр гаргах эрх хязгаарлагдмал. Хуульд хамгаалалтын захиргааны эрх хэмжээ бүдэг, санхүүгийн эрх мэдэл төвлөрсөн. Төсвийн хязгаарлалт, улс төрийн нөлөөлөл их байна. Тиймээс хамгаалалтын захиргааны дарга нарын эрх, үүргийг хуульд нарийн тодорхой тусгах. Судалгаанд үндэслэсэн шийдвэрийг тухайн бүсийн захиргаад бие даан хэрэгжүүлэх эрх олгох. Ингэснээр шийдвэр гаргалт илүү хариуцлагатай, хурдан, нутаг дэвсгэрийн онцлогт нийцсэн менежмент хэрэгжинэ.
- ОН-ийн эрх хэмжээ гэхээсээ илүү ИТХ, ЗД-ын хүлээсэн үүргийг тодорхой тусгах. Нэгжийн тухай хууль болон орон нутгийн бодлого хоорондын уялдаа сул. Зарим орон нутаг бодлого хэрэгжүүлэх үүргээ биелүүлэхгүй, оролцоо нь ашиг сонирхлоор хязгаарлагддаг. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд орон нутгийн хариуцлагыг хуульчилж, үүргийг тодорхой болгох. Иргэд, ИТХ, ЗДТГ-ын оролцоог хариуцлагатай, тогтолцоотой болгох.
- Байгаль хамгаалагчдын аюулгүй байдал, эрх зүйн хамгаалалт хангалтгүй байна. Хуульд байгаль хамгаалагчийн эрх, хамгаалалтын арга хэмжээний зохицуулалт сул. Хулгайн ан, зөрчилтэй тулгарах үед хууль сахиулах бүрэн эрхийн орчин хангалтгүй байна. Иймээс Байгаль хамгаалагчийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгах. Онцгой нөхцөлд зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх, хамгаалалттай байх нөхцөлийг бүрдүүлэх. Байгалийн нөөц: тусгай зориулалтын анг ТХГН-ийг түшиж байгуулдаг ч ТХГН-т хамгаалагдаж буй амьтныг агнадаг, эргээд орлого хуваалцахгүй байна.
- Тусгай зориулалтын ан агнуурын орлого, менежментийн уялдаа сул. Ан агнуурын бүс нутгууд ТХГН-д түшиглэж байгуулагддаг ч орлого, ашиглалтын менежмент салангид байна. Тусгай зориулалтын ан агнуураас орох орлогын тодорхой хувийг хамгаалалтын сан, орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд чиглүүлэх. Ан агнуурын бүсүүдийн менежмент, хамгаалалтыг уялдуулах эрх зүйн зохицуулалт хийх.
- 1200 өрхтэй. ИНХ-аар айл өрхийн байршлыг хүлээн зөвшөөрүүлээд сумын ЗД-аас зөвшөөрөл аваад, ХЗ, иргэн, ЗД-тай гурвалсан гэрээ байгуулдаг. Газрын төлбөрөө авах, иргэн эдийн засгийн харилцаанд орох боломжтой байхаар зохицуулаад явж байна.

Зэд хантайн нуруу

- ТХГН-ийн агентлаг, захиргаатай болох асуудлыг дэмжиж байна.
- Газрын тухай хуультай уялдаа сул, өөрчлөлт оруулах шаардлагатай. Тусгай хамгаалалттай газрын эрх зүйн зохицуулалт “Газрын тухай хууль”-тай уялдаагүйгээс давхардал, маргаан үүсдэг. Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал уул уурхайн болон бусад ашиг сонирхлоор зөвшөөрөл олгодог тохиолдол гарч байна. Тусгай хамгаалалттай газрын хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахдаа Газрын тухай хуультай зайлшгүй уялдуулах, холбогдох нэмэлт өөрчлөлт хийх. Хуулийн төсөл боловсруулах баг энэ асуудлыг өндөр ач холбогдолтой амбицтайгаар авч үзэх.
- Санхүүжилтийн боломжуудыг хууль эрх зүйн хүрээнд бий болгох. Санхүү, хүний нөөцийн хүрэлцээ хомсдож, хамгаалалтын үр нөлөө буурч байна. Төсөв хангалтгүйгээс орон тоо цомхотгож эхэлсэн. Хуулийн төсөлд тусгай хамгаалалттай газрын санхүүжилтийн тогтолцоог (тусгай сан, байгаль хамгааллын төлбөр, хураамж, төслийн орлого гэх мэт) тусгах.

- Байгаль хамгаалагчдын орон тоо, цалин, хамгаалалтын тоног төхөөрөмжийн хангалтыг хуульд заасан доод стандартаар баталгаажуулах.
- Хуулийн хэрэгжилтэд оролцогчдын санал, дуу хоолой хангалттай тусгагдахгүй байна. Хуулийн хэлэлцүүлэг төвлөрсөн түвшинд явагдаж, хамгаалалтын захиргаа болон байгаль хамгаалагчдын санал бодол бүрэн тусгагдахгүй байна. Хуулийн төслийг хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчдын түвшинд дахин хэлэлцүүлж, бодит санал авах.
- Тусгай хамгаалалттай газрын байгууллагын бүтэц, оршин тогтнох чадвар сул байна. Хамгаалалтын захиргаад цөөн хүнтэй атлаа том газар нутаг дэвсгэр хариуцаж байна. Хүний нөөцийн хязгаарлалт, ажлын ачаалал өндөр, дэмжлэг сул. Байгаль хамгаалагчийн хариуцах газрын хэмжээг тухайлан заах
- Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн талаар ижил чиг үүрэг хэрэгжүүлж буй атлаа цалингийн зэрэглэл ялгаатай байна. Т37, Т39 гээд ялгаатай цалинжиж байна.
- Хамгаалалтын хориглох дэглэм дээр метал хайгчтай, уурга дэгээтэй орох, загас барих хэрэгсэлтэй явахыг хориглохоор тодруулах тусгах
- Санхүүжилт дээр байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дээр нэмээд ТТХГ-аас бусад газар гэж нэмэх

Орхоны хөндий

- Хуулийн шинэчилсэн төсөлд хамгаалалтын захиргааны институцийн үнэ цэн, үүрэг суларч болзошгүй байна. Хуулийн төслийн шинэ хувилбарт хамгаалалтын захиргааны бүтэц, эрх хэмжээний талаарх тодорхой бус заалтууд орсон. Зарим “эрх үүрэг хэт төвлөрсөн байна” гэсэн нэрийн дор хамгаалалтын захиргааны үүргийг багасгах хандлага ажиглагдаж байна. Хамгаалалтын захиргааны институцийг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага гэдгээр хуульд тодорхой зааж, эрх, хариуцлагыг нь хадгалах. Хамгаалалтын захиргааны үнэ цэн, нэр хүнд, институцийн тогтвортой байдлыг хамгаалах заалтыг тусгах.
- Бүс нутгийн онцлогийг тусгаагүй “нэгдмэл” хандлага нь хуулийн хэрэгжилтийг хүндрүүлэх эрсдэлтэй. Говь, хангай, хээр, баруун, зүүн бүсийн экологийн онцлог, нийгэм-эдийн засгийн нөхцөл өөр боловч хуулийн төсөл нийтлэг байдлаар хандсан.
- Хуулийн хэрэгжилтийг бүс нутгийн онцлогт нийцүүлэх нутагшуулсан зохицуулалтын зарчим тусгах. Тухайн бүсийн экосистем, ашиглалтын дарамт, хүн амын нягтралаас хамаарсан ангиллын ялгаа, удирдлагын загвар боловсруулах.
- Аялал жуулчлалтай холбоотой газар олголт нөөц даацын судалгаагүй явагдаж байна. Орон нутгийн хамгаалалтын захиргаа нөөц даацын судалгаа хийлгэх эрх, төсөвгүй. Яам, төв байгууллагаас арга зүйн зөвшөөрөл хүлээх шаардлага гардаг, судалгаа олон жил хийгдээгүй. Нөөц даацын судалгаа хийх, түүний үндсэн дээр газар ашиглалтыг зөвшөөрөх
- Хуулийн төсөлд “нөөц даацын судалгааг үндэслэж газар ашиглалтыг шийдвэрлэх” гэсэн заалт оруулах. Судалгааг хамгаалалтын захиргаа болон орон нутгийн түвшинд хийх боломж, аргачлал, хариуцлагыг тодорхойлох.
- Отоглох цэгийн ашиглалт, менежмент тодорхойгүй байна. Одоогоор отоглох цэгийн эрх зүйн статус, концесс эсвэл төрийн менежментэд байх эсэхийг зохицуулсан журам гараагүй. Зарим төслөөр баригдсан отоглох цэгийн өмчлөл, ашиглалт, хариуцлага тодорхойгүй. Хуулийн төсөлд “отоглох цэгийн менежментийн журам”-ыг заавал боловсруулах шаардлагатайг тусгах.

- Хамгаалалтын захиргаа нь отоглох цэгийг удирдах, хяналт тавих, санхүүгийн ашиглалтын ил тод байдлыг хангах үүрэгтэй байхаар тусгах. Гадаадын туршлага судалж, Монголын нөхцөлд нийцүүлэх.
- Хуулийн хэлэлцүүлгийн сүүлийн хувилбартай танилцах боломж хязгаарлагдмал байна. Төслийн эцсийн хувилбар албан ёсоор түгээх цахим холбоос, мэдээлэл ирүүлээгүй. Хэлэлцүүлэгт оролцогчид бодит баримттай танилцалгүй санал хэлэх хүндрэлтэй байна.
- Нөхөн төлбөр, торгуулийн орлого хамгаалалтын захиргаанд буцаж хуваарилагддаггүй. “Ойн тухай хууль”-д зааснаар ойн нөөцөд учруулсан хохирлын төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу Уур амьсгалын санд төвлөрүүлдэг. Шүүх байгууллага нь тухайн хуулийг баримталдаг тул нөхөн төлбөрийг хамгаалалтын захиргааны дансанд бус уур амьсгалын санд шилжүүлдэг. Хамгаалалтын захиргаа торгууль, нөхөн төлбөрийн шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх эрхтэй боловч орлого төвлөрүүлэх данс, зарцуулах эрхгүй. Мөн Уур амьсгалын сан татан буугдаж байгаа тул нөхөн төлбөрийн чиглэл тодорхойгүй үлдэж байна. Тусгай хамгаалалттай газрын тухай хууль”-д нэмэлт оруулж, нөхөн төлбөрийн орлогыг шууд тухайн хамгаалалтын захиргааны дансанд төвлөрүүлдэг байх зохицуулалт оруулах.
- “Ойн тухай хууль”-д давхар нэмэлт оруулж, ТХГН-ийн хамааралтай нөхөн төлбөрийг “Уур амьсгалын сан” бус ТХГН-ийн орлого болгон бүртгэх заалт оруулах. Хамгаалалтын захиргаанд төвлөрсөн нөхөн төлбөрийг байгаль нөхөн сэргээх, хамгаалалтын хяналт, сэргээн ойжуулалт, нийгмийн оролцооны хөтөлбөрт зарцуулах эрх олгох.

Хөвсгөл ТХГН

- Ойн сан, усан сангийн онцгой болон эрүүл ахуйн бүсэд баригдсан бүтээн байгуулалтуудын эрх зүйн статус тодорхойгүй байна. Ойн, усан санд хөрөнгө оруулалт хийсэн аж ахуй нэгжүүдийн газрын төлбөрийн хэмжээг ялгаатай болгох. Төлбөр хураамжийн хэмжээг 50м, 100м гэдгээс хамааран ялгаатай тогтоох. Өмнө нь газар олгогдож, барилга баригдсан баазуудыг буулгах боломжгүй, асар их нөхөн төлбөр шаардагдана. Гэвч эдгээр баазууд хууль ёсны хязгаарлалт бүхий бүсэд байрлаж байгаа нь хамгаалалтын зорилгыг зөрчиж байна.
- Албадан чөлөөлөх эрх, хэрэгжилт сул байна. Нуурын эрэг дээр барьсан байшинг албадан буулгах эрхийг ТХГН-ийн улсын байцаагчид олгох, сумын удирдлага буулгах шийдвэр гаргадаггүй. Одоо мөрдөж буй хуульд албадан чөлөөлөлтийг зөвхөн сум, аймгийн засаг дарга хэрэгжүүлж болно. Тэд улс төрийн сонгуульт албан тушаалтан тул нийтийн эрх ашгийн өмнөөс шийдвэр гаргахаас зайлсхийдэг. Тусгай хамгаалалттай газрын улсын байцаагчид, хамгаалагчид тодорхой нөхцөлд албадлагын арга хэмжээ авах эрх, бүрэн эрхийг хуульчлан олгох.

Ойн сан, усан сангийн онцгой бүсэд байрласан объектуудад түр хугацааны зөвшөөрөлтэй ашиглалт, шат дараалсан чөлөөлөлтийн зохицуулалт хийх. Газар ашиглалтын төлбөрийг шатлалтай тогтоох: Ердийн бүсийн төлбөр – үндсэн тарифтай; Онцгой, хамгаалалтын бүсийн төлбөр – өндөр хувьтай байхаар хуульчилж ялгавартай тогтоох. Ингэснээр хууль бус газар ашиглалтыг шат дараатайгаар бууруулж, ирээдүйд хамгаалалтын бүсэд барилга байгуулах сонирхлыг хязгаарлана.

- Байгаль хамгаалагч, улсын байцаагчийн аюулгүй байдал, өөрийгөө хамгаалах эрх тодорхой бус. ТХГН-ийн хуулийн хэрэгжилтийг хангуулах эрх хэмжээг баталгаажуулах. Хуулиар “зэвсэг хэрэгсэл ашиглаж болно” гэж заасан ч зөвшөөрөгдөх зэвсгийн төрөл, ашиглах журам тодорхойгүй. Хуульд цагдаагийн байгууллагатай зөвшилцөхөөр заасан ч, Прокурор ба сайдын хамтарсан тушаал хүчингүй хэм хэмжээтэй зөрчилтэй байна.
- Ашиглах зэвсэг хэрэгслийн төрлийг ЦЕБ-тай хамтран батлахаар заасан ч ТХГН-т байгаль хамгаалагч, улсын байцаагч зэвсэг хэрэгсэл хэрэглэж болохоор заасан ч шүүх дээр хамгаалагдаж чадахгүй байна. ЦЕБ-тай хамтран батлах зохицуулалт байхгүй хэвээр байна
- Кадастрын системийн давхардлаас үүдэн хамгаалалттай газрын хил зөрчигдөж байна. Газар ашиглалт: кадастр хийдэг компаниуд нэг л кадастрын системтэй гээд хийгээд өгдөг. Тиймээс ТХГН-т кадастрын системийг хийх процессыг өөрөөр хийх. Орон нутгийн кадастрын нэгжүүд ТХГН-ийн хилтэй уялдаагүй. Кадастр хийдэг компаниуд иргэдэд буруу мэдээлэл өгч, газар эзэмших хүсэл сонирхол бий болгож байна. Тусгай хамгаалалттай газрын кадастрын нэгжийг улсын кадастрын системд тусад нь бүртгэх. Газрын бүртгэл, кадастрын мэдээллийн санд “Protected Area Layer” үүсгэж, хил, статустай нь нэгдсэн байдлаар харуулах.
- Усан мандлын хамгаалалт сул, усан тээврийн хяналт дутмаг байна. Усан мандалд хувь хүмүүсийн завь, мотор бүхий тээврийн хэрэгсэл хяналтгүй орж ирдэг. Ариутгал, техникийн үзлэг, бичил биетний зөөвөрлөлтийн хяналт байхгүй.
- Хуулиар “усан мандлын хамгаалалтын дэглэм” тусгайлан тогтоох. Завь, тээврийн хэрэгслийг усан мандалд оруулахдаа ариутгал, техникийн хяналт, бүртгэлийн журам батлах. Хамгаалалтын захиргаанд усны хяналтын эрх бүхий байцаагчийн эрх олгох.
- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хэт формаль болж, хяналт сул. Нарийвчилсан үнэлгээ хийгдсэн нэртэй ч чанаргүй, хэд хэдэн газарт “хуулбарлагдан” ашиглагддаг. Газрын зөвшөөрөл олгохоос өмнө үнэлгээний чанар, үр дүн шалгагддаггүй. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг газрын зөвшөөрөл олгохоос өмнө заавал хийдэг болгох. Нарийвчилсан үнэлгээний байгууллагад мэргэжлийн хариуцлага, давхардлыг хориглох зохицуулалт оруулах.
- Орчны бүс дэх эдэлбэр газрын зохицуулалт тодорхойгүй. Орчны бүсийг хуулиар нэгтгэж байгаа ч дотор нь байгаа эдэлбэр газрын ашиглалт, төлбөр, хяналтын асуудал тусгагдаагүй. Хуулийн төсөлд эдэлбэр газрын ашиглалтын тусгай зохицуулалт, төлбөрийн ялгаа тусгах. Эдэлбэр газруудад байгаль орчны хяналт, төлбөр, стандартыг хамгаалалтын бүсийн жишгээр тогтоох.
- Байгалийн нөөц, дагалдах баялгийн орлого ТХГН-ийн санхүүжилтэд шууд очдоггүй. 2023 оны нэмэлт өөрчлөлтөөр орлогыг ТХГН-д хуваарилахаар тусгасан ч бусад хуулиудтай уялдаагүй. Байгалийн нөөцийн орлогыг шууд хамгаалалтын захиргааны санхүүжилтэд хуваарилдаг механизмыг хуулиар баталгаажуулах.
- Зөрчил, нөхөн төлбөрийн орлого буцаад ТХГН-ийн санд ордоггүй. Шүүхээс олгосон нөхөн төлбөр улсын санд төвлөрдөг, хамгаалалтын байгууллагад буцаж очдоггүй. Хуулиар нөхөн төлбөрийг тухайн ТХГН-ийн санхүүжилтэд шууд оруулах зохицуулалт тусгах. Байгаль орчны

улсын байцаагчийн тавьсан торгуулийн урамшууллыг буцаан олгодог зохицуулалтыг тодорхой болгох

- Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх гэхээр өөрсдөө машин унаа гаргах, өдөр шөнөгүй ажиллах зэрэг зардал гаргадаг ч нөхөн төлүүлэх зардлаа нотолж чадахгүй асуудлууд байна.
- Завины зогсоол: Усан замын тээврийн тухай хуулиар төв зогсоол болон бусад зогсоол гэж заадаг. Эрэг дээрх байгууламж барих бол газар ашиглалттай холбоотой гэрчилгээ, зөвшөөрөл олгох ёстой болдог. Түр зогсоолтой холбоотой зохицуулалт
- Зөрчил: хялбаршуулсан байдлаар шийдвэрлэж байгаа ч прокурорт бүртгүүлэх зэрэг процесс ажиллагаа явуулдаг. Авто замын цагдаа шиг торгууль ногдуулдаг болгох
- Чонын ав: Бүс нутгийн иргэдийн саналыг авч яамнаас зөвшөөрөл авч агнах зөвшөөрөл явдаг нь процесстой байдаг. Үүнийг хялбарчлах, хамгаалалтын захиргаанд холбоотой зохицуулалтыг хийх эрхийг олгох саналтай байна.
- Бааз: эргийн тохижилт хийх гээд сүүдрэвч писет хийдэг ч саун, пол хийдэг.
- Хил дамнасан тусгай хамгаалалт: хамгаалалтын захиргааны дарга нь хамгааллын үйл ажиллагаа явуулах боломжгүй байдаг. Хамтын судалгааг тохиргоо гэдэг нэрээр судалгаа явуулдаг. Үүнийг хялбарчлах зохицуулах
- Үл хөдлөх эд хөрөнгө: банкны барьцаанд тавьдаггүй ч томоохон баазууд авсан байдаг. Гэрчилгээ гаргах, татвар төлөх асуудлууд байгааг анхаарах

Хангайн нуруу

- Хамгаалалтын захиргааны төсөв хангалтгүй, дийлэнх нь урсгал зардалд зарцуулагдаж байна. Хамгаалалтын захиргаа өөрөө орлого, мөнгөө олдог боломжийг бүрдүүлэх. Одоогийн төсвийн бүтэц нь 80 орчим хувийг цалин, урсгал зардалд зарцуулдаг тул бодит хамгаалалтын үйл ажиллагаа, хяналт, судалгаа, хөтөлбөрийн хэрэгжилтэд хөрөнгө үлдэхгүй байна. Хамгаалалтын захиргаа өөрийн орлого төвлөрүүлэх эрх зүйн боломжгүй, улсын төсөвт бүрэн хамааралтай байгаа нь тогтвортой санхүүжилтэд сөргөөр нөлөөлж байна.
- Хуулийн төсөлд хамгаалалтын захиргааг санхүүгийн хувьд бие даах боломжтой, орлого төвлөрүүлж, зарцуулах эрхтэй байгууллага гэж тусгах. Өөрийн орлого бүрдүүлэх боломжийг дараах чиглэлээр нээх: Аялал жуулчлалын нэвтрэх тасалбар, байгаль ашиглалтын төлбөр, хураамжийн тодорхой хувийг буцаан хамгаалалтын захиргаанд хуваарилах; Хамтын менежментийн хүрээнд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжтэй орлого хуваах, төсөл хэрэгжүүлэх боломжийг хуульчилж өгөх гэх мэт.
- Нэвтрэх тасалбарын орлого төвлөрч байгаа ч хамгаалалтын захиргаанд буцааж хуваарилахгүй байна. Одоогийн системийн дагуу нэвтрэх тасалбарын орлого улсын төсөвт төвлөрдөг ч хамгаалалтын захиргааны үйл ажиллагаанд эргэн зарцуулагддаггүй. Нэвтрэх тасалбарын цахим систем нэвтрүүлж, Улаанбаатар хотын гарц (жишээ нь, 22-ын товчоо) зэрэг гол чиглэлд урьдчилан борлуулах хэлбэрийг туршиж эхлэх. Нэвтрэх тасалбарын орлогын тодорхой хувийг хамгаалалтын захиргаанд шууд буцаан олгодог зохицуулалт хуульд тусгах. Цахим төлбөрийн системийн орлогоос ил тод тайлан, хяналт бүхий сангийн данс байгуулах.
- Завины үйлчилгээтэй холбоотой түүнийг дагасан худалдаа үйлчилгээний цэг бий болж байгаа. Үүнийг менежментээр хэрэгжүүлэх боломжийг олгох
- Хамгаалалтын менежментийг орон нутгийн иргэдтэй үр дүнтэй хамтран хэрэгжүүлэх зохицуулалт сул байна. Хамтын менежментийн зарчим хэрэгжиж байгаа ч хуульд

оролцогч талуудын үүрэг, оролцооны хэлбэр тодорхой бус. Иргэдийн оролцоотой менежментийн үр ашиг, хариуцлагын хуваарилалт системтэй бус. Хуулийн төсөлд “хамгаалалтын менежментийн хамтын механизм” гэсэн шинэ заалт оруулж, орон нутгийн иргэд, малчид, хувийн хэвшлийн оролцоог хуульчилж өгөх. Урамшууллын систем бий болгож, хамтын менежментэд оролцогч иргэдийн орлого, үр дүнг хуваалцах нөхцөлийг тодорхойлох

- Хуулийн төсөлд хамгаалалтын захиргаадын санал, орон нутгийн байр суурь бүрэн тусгагдаагүй байна. Хуулийн хэлэлцүүлэг төвлөрсөн байдлаар явагдаж, газар дээр ажиллаж буй хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчдын бодит санал орхигдож байна. Хуулийн төслийг бүх хамгаалалтын захиргаадын түвшинд хүргүүлж, бичгээр санал авах
- Ойн сантай адилтган хариуцлагын зохицуулалтыг тусгах

Тэсийн гол Булнайн нуруу БЦГ

- Нэгжийн тухай хуульд тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын чиг үүрэг тодорхой тусгагдаагүй байна. Баг, сум, аймаг, иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг орон нутгийн байгууллагуудын ТХГН-д хамаарах эрх, үүрэг тодорхойгүй. Үүний улмаас орон нутгийн түвшинд ТХГН-ийн хамгаалалтын бодлого, хяналт, хэрэгжилт сул байна. “Нутгийн удирдлагын нэгжийн тухай хууль”-д ТХГН-ийн хамгаалалт хэрэгжүүлэх чиг үүргийг бүх шатны захиргаа, хуралд тодорхой хариуцуулан тусгах. Хамгаалалтын захиргаатай орон нутгийн бодлого, төлөвлөлтийн уялдаа бүхий үүрэг хуваарилалт бий болгох.
- Улсын байцаагчид, байгаль хамгаалагчдын үүрэг ижил боловч цалин, зэрэглэл зөрүүтэй байна. Орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч ТЗ-7, хамгаалалтын захиргааны мэргэжилтэн ТЗ-9 цалингийн шатлалд ажиллаж байна. Ижил төрлийн үүрэг гүйцэтгэж байгаа боловч урамшуулал, зэрэглэлд ялгаа байгаа нь шударга бус байдал үүсгэж байна. Байгаль хамгаалагч, хяналтын улсын байцаагчийн зэрэглэл, цалингийн шатлалыг ажлын ачаалал, үүрэгтэй уялдуулан ТЗ-7 түвшинд нэгтгэх. Цалин хөлсний ялгаанаас шалтгаалсан хүний нөөцийн тогтворгүй байдлыг арилгах
- Хог хаягдалтай холбоотой зөрчилд байгаль хамгаалагчид шууд арга хэмжээ авч чаддаггүй. Хуулиар торгуулийн шийтгэл оногдуулах эрх хамгаалагчид олгогдоогүй. Цагдаа шууд торгох эрхтэй байхад хамгаалагч зөвхөн анхааруулга өгөх хэмжээнд байна. Байгаль хамгаалагчид зөрчил илрүүлэх, торгууль оногдуулах хязгаарлагдмал эрх олгох. Хог хаягдлын зөрчилд шуурхай шийдвэр гаргах, цахим бүртгэлийн систем ашиглах
- Хуулийн хориглох үйл ажиллагаанд “загас агнах” үйлдэл тусгагдаагүй байна. Одоогийн хуулийн 18 дугаар зүйлд загас агнах, загас барих хэрэгсэл хэрэглэх тухай хориг тусгагдаагүй. Үүний улмаас хамгаалалтын бүсэд зөрчил илрүүлсэн ч арга хэмжээ авах эрхийн үндэс дутмаг байна. Хуулийн 18 дугаар зүйлд “загас агнах, загас барих хэрэгсэл хэрэглэхийг хориглоно” гэсэн заалт нэмэх
- Хохирлын нөхөн төлбөрийн хуулийн уялдаа алдагдсан. Тусгай хамгаалалттай газрын тухай хууль”-д 6.2.4-т хохирлын орлогоос санхүүжих заалт байгаа ч “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-д нийцээгүй. Прокурор, шүүхийн шатанд зөрүүтэй зүйлчлэл ашиглагдаж, ТХГН-ийн нөхөн төлбөр хамгаалалтын байгууллагад эргэн очдоггүй. “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлд Тусгай хамгаалалттай газар

нутгаас бусад газарт учруулсан хохирол, нөхөн төлбөр гэж тусган, хоёр хуулийн уялдааг хангах.

- Байгаль хамгаалагчийн хариуцах талбай хэт өргөн, хяналт хэрэгжүүлэх боломжгүй байна. Байгаль хамгаалагчийн хариуцах талбайг журамд заадаг ч хуульд тодорхой хэмжээ байхгүй. Ойн бүсэд харагдах хүрээ хязгаарлагдмал, 1 хамгаалагч 3–7 га талбайг хариуцдаг ч хяналт бодитой хэрэгждэггүй.
- Байгаль хамгаалагчид ногдох талбайн хэмжээг журмаар бус, хуулиар тогтоох.
- Экологийн бүс нутгийн онцлогоор ялгасан гадаргын хэмжээний стандарт боловсруулах (ойн бүс, хээр, говь гэх мэт)
- Тусгай хамгаалалттай газрын нөхөн төлбөр, торгуулийн орлого хамгаалалтын захиргаанд буцаан хуваарилагддаггүй. Прокурорын тогтоол, шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлбөр улсын санд төвлөрч, хамгаалалтын байгууллагын төсөвт очдоггүй. Хуулиар ТХГН-ийн нөхөн төлбөр, торгуулийн орлогыг хамгаалалтын захиргаанд буцаан хуваарилах тогтолцоог тодорхой тусгах
- Малчдын өвөлжөө, хаваржааны газар эзэмших, ашиглах эрхийн талаар Газрын тухай хууль ба Тусгай хамгаалалттай газрын тухай хуулийн хооронд хийдэл үүсч байна. Сумын засаг даргаас өвөлжөө, хаваржааны асуудлыг шийдвэрлэдэг. Гэрчилгээг сунгуулах асуудлыг ТХГН-ийн захиргаа шийдвэрлэх эрхгүй. Өвөлжөө хаваржааны зориулалтаар эзэмшүүлэх зохицуулалтыг нарийвчлан зохицуулах шаардлагатай. 450 орчим айл өрх байдгаас 50 орчим айл орж хуулийн сурталчилгаа хийсэн. Иргэдэд мэдээлэл сурталчилгаа хийхэд шаардлагатай санхүүжилт байхгүй байна
- РА week арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд таниулж мэдээлэх чиглэлээр хамтран ажиллах шаардлагатай байна.

Хөгнө тарна

- Малчдад өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар ашиглуулах гэрчилгээ олгох тохиолдолд газрын чанарын хяналт болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх шаардлага үүснэ. Газрын тухай хууль болон Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль-ийн дагуу аливаа газар ашиглалтын өмнө чанарын баталгаа, байгаль орчны үнэлгээ хийгдэх ёстой. Гэхдээ өвөлжөө, хаваржааны зориулалттай жижиг талбайд ийм үнэлгээ гаргуулах нь өрх бүрт эдийн засгийн хувьд хэт ачаалалтай, хэрэгжих боломж муутай. Малчид ихэнхдээ ахуйн болон уламжлалт ашиглалт хийдэг тул төслийн зориулалттай ашиглалттай адил төвөгтэй үнэлгээ шаардах нь оновчгүй байна.
- Өвөлжөө, хаваржааны зориулалтын ашиглалтад хялбаршуулсан үнэлгээ, чанарын баталгааг орон нутгийн түвшинд үнэлэх. Томоохон бүтээн байгуулалт, аж ахуйн зориулалттай ашиглалтад бүрэн хэмжээний нарийвчилсан үнэлгээ хийх.
- Үнэлгээний төлбөрийг малчдаас биш, орон нутгийн төсвөөс эсвэл холбогдох сангаас (жишээлбэл, Байгаль хамгааллын сан) санхүүжүүлэх. Хамгаалалтын захиргаа, орон нутгийн байгаль орчны мэргэжилтнүүдийг үнэлгээ хийн дүгнэлт гаргах эрхтэй болгож өгөх.
- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх журманд тусгай хамгаалалттай бүсийн өвөлжөө, хаваржааны зориулалтад зориулсан тусгай бүлэг оруулах.
- Тусгай хамгаалалтад авахаас өмнө байсан газар тариалангийн ашиглалтын газрын асуудлыг хэрхэх гэдгийг шийдвэрлэх. Хуучин атаршсан газар гэж ялгах

- ОН-ийн иргэд аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой зохицуулалтыг горимд тусгах
- Сонгуулийн санал авах зорилгоор хүмүүст замбараагүй газар олгодог асуудлыг шийдвэрлэх. Орчны бүсэд агнуур хийсэн бол биотехникийн арга хэмжээ авдаг байх
- Зөрчлийн болон процессын хууль дээр нэмэлт өөрчлөлт оруулах. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зөрчлүүд дээр цагдаагийн торгууль тавих асуудлыг зохицуулах
- Байгаль хамгаалагчийн төрийн тусгай хамгаалагч болгох зохицуулалтыг судлах
- Байгаль хамгаалагчийн тэтгэвэрт гарах насыг наашлуулах боломж
- Газар ашиглалтын сургалтыг зохион байгуулах
- Газар ашиглалттай холбоотой ГЗЗЕГ-т хандахаар хэрэгтэй туслалцаа авах боломж хязгаарлагдмал байдаг. VPN тасардаг, систем гацдаг

Д.Батцогт дарга

- Захиргаадаас ирүүлсэн хуулийн орчныг сайжруулахтай холбоотой саналыг ажлын хэсэгт албан ёсоор хүргүүлэх
- Хамгаалалтын захиргаадад ТХГН-ийн хуулийн төсөлд албан ёсоор санал авах ажлыг зохион байгуулах
- Нүүрс тээвэртэй холбоотой шүүхийн маргааны асуудлыг яамны Хуулийн хэлтсээс дэмжлэг авах
- Хамгаалалтын захиргаадад газар ашиглалттай холбоотой харилцан туршлага судлах 2 цагийн арга хэмжээ зохион байгуулах. Газар ашиглалттай холбоотойгоор Богд хан уулын хамгаалалтын захиргаа болон Горхи тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаанаас туршлага судлах шаардлагатай.
- ТББ-аас гэрээний үндсэн дээр хамгааллын үйл ажиллагаа эрхэлж байгаа бол нийгмийн хамгамж, тэтгэмжийг төсвийн байгууллагатай адил байхаар хуульд тусгайлан анхаарч тусгах шаардлагатай.
- 10 сард зохион байгуулах ТХГН-ийн чуулганд идэвхтэй оролцох
- МБӨС-аас үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэхээр БОУАӨЯ, СЯ-тай ажлын хэсэг байгуулсантай холбоотойгоор хамгаалалтын захиргаадаас мэдээлэл авах арга хэмжээг зохион байгуулна. Мэдээллээ МБӨС-т сайн гаргаж өгөх шаардлагатай.

---oOo---